

2023

ЖИЛИЙН ТАЙЛАН

ЕРӨНХИЙ АГУУЛГА

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	4
Удирдлагын баг, бүтэц зохион байгуулалт	5
Тогтвортой хөгжилд хамтдаа	8
Компанийн засаглал	10
Дотоод аудит, хяналт	11
Монгол Улсын эдийн засаг	12
Банкны сектор	14
2023 оны онцлох үйл явдал	15
Санхүүгийн хураангуй тайлан	18
Хүний нөөцийн удирдлага	20
Нийгмийн хариуцлага	23

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгууллагын зах зээл	26
Жижиг дунд бизнесийн зах зээл	30
Иргэдийн зах зээл	32
Цахим банкны үйлчилгээ	36
Гадаад харилцаа, Олон улсын банк	40
Харилцагчийн үйлчилгээ	43
Хөрөнгө зохицуулалтын удирдлага	44
Эрсдэлийн удирдлага	47
Мэдээллийн технологи	50

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

53

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын арилжааны ууган банк Худалдаа Хөгжлийн Банк анх 100 хувь төрийн өмчит компаниар үүсгэн байгуулагдсан. Тэр утгаараа олон улсын хөрөнгө оруулалт, санхүүжилт, бонд зэрэг Монгол Улсын Хөгжлийн банкны үүргийг гүйцэтгэж байсан. 1990-ээд оны эхээр зах зээлийн үед байгуулагдсан компани, аж ахуйн нэгжүүд бүгд л Худалдаа Хөгжлийн Банкны харилцагч. Бид хамтдаа өнөөдрийн Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг бүтээсэн гэж боддог.

Түүнчлэн Монгол Улсын гадаад худалдаа, аж үйлдвэржилт, дэд бүтцийн хөгжил, эрчим хүч, уул уурхай, төмөр зам, авто зам, цахилгаан станц, боловсруулах үйлдвэр гээд өнөөдрийн Монгол Улсыг авч явж байгаа макро эдийн засгийн сектор болгонд хувь нэмрээ оруулж ирсэн. Бид одоо ч Байгууллагын банкны зах зээлийн тэн хагасыг дангаар эзэлж, хамгийн том арилжааны банк хэвээр байна.

2023 онд арилжааны зургаан банк нээлттэй хувьцаат компани болж, хувьцаа нь хөрөнгийн бирж дээр арилжаалагдлаа. Арилжааны банкнууд системийн 100 жилийн түүхэн цаг үе дээрээ олон улсын стандарт хангасан, олон улсын дүрэм журам, хууль эрх зүйн орчинтой, олон улсын зах зээл дээрх бүх л бүтээгдэхүүн үйлчилгээтэй, орчин цагийн нээлттэй, тогтвортой ногоон банкны системийг хөгжүүлж чаджээ. Энэ олон сорилтуудыг амжилттай давсан банкны секторын хамт олон болон Монголбанкны хамт олонд баяр хүргэмээр байна.



Банк, санхүүгийн байгууллагууд нь өргөн цар хүрээ бүхий хамтын ажиллагаанд тулгуурлан байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) удирдлагыг түүчээлэх үүрэгтэй. Худалдаа Хөгжлийн Банк уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэй сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах зайлшгүй шаардлагатай гэж үздэг. Тиймээс ч бид эрчим хүчний хэмнэлт бүхий технологи, тогтвортой ус, хаягдлын хэрэглээ, ногоон дэд бүтэц зэрэг төслүүдийг санхүүжүүлэн дэмжиж ногоон эдийн засагт шилжихэд идэвхтэй хувь нэмэр оруулж байна.

Банк нь байгаль орчныг хамгаалахаас гадна нийгмийн тэгш байдал, оролцоог дэмжих чиглэлээр дорвитой алхмууд хийдэг. Олон нийтийн үйл ажиллагаа болон хүмүүнлэгийн санаачилгуудаар дамжуулан бид иргэдийг чадавжуулж, санхүүгийн боловсрол олгох, эрүүл мэнд, бизнес эрхлэлтийг дэмжиж байна. Бид нийгмийн дэвшил, эдийн засгийн хөгжил хоёр зэрэгцэн оршдог гэдэгт бат итгэдэг.

Тогтвортой хөгжлийг цогцлоох үйлсийг бид хамтын ажиллагаа, нэгдмэл хүсэл зориггүйгээр бүтээх боломжгүй. Бидний хүчин чармайлтад үнэлшгүй хувь нэмэр оруулж буй зорилго нэгт нөхөд, харилцагч, хамтрагч, хувьцаа эзэмшигч нартаа гүн талархал илэрхийлье.

Бид хамтдаа илүү сайхан, тогтвортой ирээдүйг бүтээж чадна гэдэгт итгэлтэй байна!

Хүндэтгэсэн,
ХХБ-ны Гүйцэтгэх захирал
О.Орхон

УДИРДЛАГЫН БАГ



О.ОРХОН
Гүйцэтгэх захирал



Р.ВҮҮД
Ерөнхийлөгч



О.БАНЗРАГЧ
Гүйцэтгэх захирлын
тэргүүн орлогч



А.ЭНХМЭНД
Гүйцэтгэх захирлын
тэргүүн орлогч



**STEPHANE
LAMOUREUX**
Гүйцэтгэх захирлын
тэргүүн орлогч



Ч.СОЛОНГО
Гүйцэтгэх захирлын
орлогч



Г.ГАНЦЭЦЭГ
Гүйцэтгэх захирлын
орлогч



С.БААТАР
Гүйцэтгэх захирлын
орлогч



Т.ГАНБАЯР
Гүйцэтгэх захирлын
орлогч



Л.ГАНТӨМӨР
Гүйцэтгэх захирлын
орлогч



П.МӨНХНАСТ
Гүйцэтгэх захирлын
орлогч

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХАМТДАА



Банкны лого нь мөнгөний нэгж болох зоосны хэлбэрт суурилсан бөгөөд зоосны голд дүрслэгдсэн мөнгөний авдарт тасралтгүй эргэлдэх эргэлтээр дөрвөн зүг найман зовхисоос мөнгө, эд баялаг хуримтлагдан арвижиж, элбэг дэлбэг байхын бэлгэдэлтэй.



УРИА

Хөгжил дэвшилд хамтдаа

Банкны ажилтнууд, харилцагчид, хөрөнгө оруулагчид зэрэг хүн бүхнийг хөгжил дэвшлийн зүгт хамт алхахыг уриалан дуудах, нэгтгэх, зоригжуулах утгатай.

Тогтвортой хөгжилд хамтдаа

Тогтвортой хөгжлийн тодорхойлолт болох ирээдүй хойч үеийн хэрэгцээг бууруулахгүйгээр дэлхийн өнөөгийн хүн амын хэрэгцээг хангах цогц үйл явцыг банк, харилцагч, түнш болон улс орон хамтдаа дэмжиж, нэг зорилгын дор нэгдэж ажиллахыг уриалсан утгатай.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагчдадаа хүсэл, тэмүүлэлдээ хүрэхэд нь зориулж, хүлээлтээс нь давсан санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологиор хүргэнэ.



АЛСЫН ХАРАА

Хөгжиж буй Монголын дэвшил бүхнийг манлайлагч банк байна.

ҮНЭТ ЗҮЙЛС



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХХБ нь олон улсын туршлагаар шалгарсан компанийн засаглалын бүхий л хэм хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг. Дээд түвшний, сайн байгууллагын засаглал нь бидний үйл ажиллагааны гол чиглүүлэгч болдог билээ. Бид компанийн засаглалын бүтцэдээ Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн болон удирдлагын багийн гишүүд, хувь нийлүүлэгчдийн хамтын ажиллагаа, нягт харилцааг нарийн тодорхойлдог. Байгууллагынхаа эрхэм зорилго, зорилтдоо хүрэхийн тулд ажилтан бүр ёс зүйн ямар хэм хэмжээг үйл ажиллагаандаа баримтлахыг ч нарийвчлан заасан.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХХБ-ны ТУЗ нь байгууллагын бүхий л шатанд ил тод, үнэнч шударга байдлыг чухалчлан, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ ямар ч нөхцөлд тохирсон алсын хараа, стратеги бүхий бодлогоор банкны үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

УДИРДЛАГЫН БАГ

ХХБ-ны удирдлагын баг нь банк, санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохистой бүтэц, олон жилийн туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог. Мөн банкны урт удаан хугацааны ашигт ажиллагааг хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог.

АЖИЛТНУУД

ХХБ-ны амжилтын үндэс нь эрч хүчтэй, чадварлаг ажилтнууд бөгөөд тэднийг шударгаар урамшуулах, дэмжих, албан тушаал дэвшүүлэх хөгжлийн тогтолцоог сайжруулснаар харилцагчдадаа банкны шилдэг үйлчилгээг үзүүлж чаддаг.

БИД

ХХБ нь хууль, ёс зүйн хариуцлагын хүрээнд нийцсэн ажиллах орчныг бүрдүүлэхийг үргэлж эрмэлзсээр ирсэн. Харилцагч, бизнесийн түншүүд болон нийгэмдээ банкны шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэн, хувь нийлүүлэгчид болон харилцагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхдээ шударга байх зарчимтай.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗОРИЛГО

Компанийн засаглалыг сайжруулан олон улсын шилдэг зарчим, туршлагуудын хэмжээнд хүргэх. Олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц, нэр хүндтэй үнэ цэнтэй, хөрөнгө оруулалтыг татах.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ИЙН ДАРГА
Рандолф КОППА

ГИШҮҮД
Должин ЭРДЭНЭБИЛЭГ
Дамбийжав ХҮРЭЛБААТАР
Дагмид ЯНЖМАА
Авгаан ЭНХМЭНД
Дэмчигжав ОТГОНБИЛЭГ

ХАРААТ БУС ГИШҮҮД
Жалбаа БОЛОРМАА
Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН
Загдхүү НАРАНТУЯА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Навааншарав Нямсүрэн

ДОТООД АУДИТ, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Дотоод аудит нь байгууллагын засаглалын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явцын үр нөлөөг зохион байгуулалттай, дэг журамтай аргаар үнэлж, сайжруулах замаар байгууллагыг зорилгодоо хүрэхэд нь тусалдаг. ХХБ-ны дотоод аудитын үйл ажиллагааг ТУЗ-ийн харьяа Аудитын хороо, Дотоод аудитын газар хариуцан ажиллаж байна.

Дотоод аудитын газар нь Гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд банкны үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэн нэмэх зорилготой хараат бус, бодитой баталгаажуулалт хийх, зөвлөмж, зөвлөгөө өгөхөд чиглэж ажилладаг. Түүнчлэн Дотоод аудиторчуудын олон улсын институт (IIA)-ийн гаргасан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (International Professional Practice Framework), олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаандаа удирдамж, жишиг болгон ажиллаж байна.

ТАЙЛАНТ ОНД ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

- Аудитын хараат бус, бодитой баталгаажуулах үйлчилгээг зохистой түвшинд гүйцэтгэж, банканд үнэ цэн нэмэн, банкныхаа үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмрээ оруулж ажиллав.
- Салбар, тооцооны төвүүдийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх үүднээс салбарын зарим үйл ажиллагааны эрсдэлд суурилсан зайны аудит болон салбарын тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээний цогц аудитуудыг хийж гүйцэтгэв.
- Дотоод аудитын үйл ажиллагааны баримт бичиг, арга зүйг дотоод аудитын олон улсын стандарттай нийцүүлэн сайжруулав.



ДОТООД АУДИТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Дотоод хяналтын үйл ажиллагаа нь банкны өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг ба бизнес, үйл ажиллагааны бүх түвшинд эрсдэлийг бууруулах тогтолцоо юм. Үүнд банкны дээд удирдлага, Гүйцэтгэх удирдлага, ажилтнууд, бусад холбоотой талууд оролцож, дотоод хяналтын үр дүнтэй, үр ашигтай байдалд Аудитын хороо, Дотоод аудитын газар үнэлэлт дүгнэлт өгөх, сайжруулах зарчмаар ажилладаг. ХХБ нь дотоод хяналтын тогтолцоогоо оновчтой болгох талаар арга хэмжээ авч, тасралтгүй сайжруулдаг билээ. Тухайлбал, банкны бүх нэгжүүд Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан "Дотоод хяналтын матриц"-ыг мөрдөн ажиллаж байна. Мөн заавар журамдаа дотоод хяналттай холбоотой зохицуулалт, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод хяналтын зохих үүргүүдийг тусгаж, шаардлагатай шинэчлэлт, сайжруулалтыг тухай бүр хийн ажилладаг. Түүнчлэн хяналтын чиг үүрэг бүхий ажлын байр, тайлагналтын тогтолцоотой.


МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ

ГАДААД ОРЧНООС ХАМААРСАН ҮНИЙН ДАРАМТ БАГАСАЖ, ЭКСПОРТЫН ОРЛОГО ӨССӨН ЖИЛ БОЛЛОО

ДНБ, 2023 оны эхний 9 сард 6.9 хувиар өссөний 1.6 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар, 3.4 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 0.4 нэгж хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 4.1 нэгж хувийг үйлчилгээний салбар, 0.6 нэгж хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар бүрдүүлсэн байна. Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2023 оны эхний 9 сард 3.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 320.1 (9.5%) тэрбум төгрөгөөр буурсан нь ДНБ-ий өөрчлөлтөд 1.6 нэгж хувиар сөрөг нөлөө үзүүлсэн байна. Уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2023 оны эхний 9 сард 2.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 683.1 (33.2%) тэрбум төгрөгөөр өслөө.

Энэхүү өсөлтөд нүүрс болон газрын тосны олборлолт өссөн нь голлон нөлөөлжээ. Тээврийн зардал, гадаад үнэ, ханш зэрэг гадаад шалтгаантай үнийн дарамт багасаж байгаагийн зэрэгцээ инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулахад чиглэсэн бодлогын арга хэмжээ үр дүнгээ өгснөөр инфляц алгуур буурч байна. Гэхдээ инфляцын цаашдын төлөв төсвийн зардал, тэр дундаа цалин, тэтгэврийн өсөлтийн нөлөө, цаг агаарын нөхцөл байдал, түлш, шатахууны ханган нийлүүлэлт зэрэг хүчин зүйлсээс ихээхэн хамаарахаар байна.

ДНБ, их наяд төгрөгөөр



ДЭЛХИЙН ЗЭСИЙН ЗАХ ЗЭЭЛД ТОМ ТОГЛОГЧ БОЛОХ БОЛОМЖИЙН ЭХЛЭЛ ТАВИГДЛАА

Оюутолгойн ордын зэсийн нөөцийн 80 хувь агуулагдаж буй Гүний уурхайн олборлолт 2023 оны гуравдугаар сарын 13-ны өдөр албан ёсоор эхэлсэн юм. Оюутолгойн ил болон гүний уурхайгаас 2028-2036 оны хооронд жилд дунджаар 500,000 тонн зэс олборлоно гэж тооцсон нь зургаан сая цахилгаан автомашин үйлдвэрлэхэд хүрэлцэх хэмжээ аж. Ийнхүү Монгол Улс 2030 он гэхэд дэлхийн дөрөвдүгээрт эрэмбэлэгдэх зэсийн Гүний уурхайтай болох урт хугацааны аяллаа эхлүүлэв. Мөн 2032 оноос эхэлж Оюутолгой төслөөс ногдол ашиг хүртэж эхлэх талаар “Эрдэнэс Оюу толгой” компани онцолсон.



НҮҮРСНИЙ ЭКСПОРТ МАНАЙ УЛСЫН ТҮҮХЭН ДЭЭД ХЭМЖЭЭНД ХҮРЧ ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ АШИГТАЙ ГАРАВ

Ковид-19 цар тахлаас хойш гурван жил дараалан алдагдалтай байсан улсын нэгдсэн төсвийн тэнцэл 2023 онд 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 23.2 их наяд төгрөг хүрч, өмнөх оноос 35.6 хувиар өсөөд байна. Хэдийгээр төсвөөс гарсан зарлага, цэвэр зээлийн хэмжээ 22.5 их наяд төгрөг болж, 23.7 хувиар өссөн ч төсвийн тэнцэл ашигтай гарлаа. Нийт орлого өсөхөд орлогын албан татварын орлого 51.6 хувь, нийгмийн даатгалын орлого 29.8 хувь, НӨАТ 21 хувиар болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хоёр дахин өссөн нь голлон нөлөөлжээ. 2023 онд Монгол Улс түүхэн дээд хэмжээ болох 70 сая тонн нүүрс экспортолсон нь 2022 оныхоос 2.1 дахин өссөн үзүүлэлт болсон юм.


- **Инфляц алгуур сулрав:**
2022 оны эцэст жилийн 13.2 хувьтай байсан инфляц 2023 оны эцсээр жилийн 7.9 хувьд хүрч төв банкны зорилтот түвшинд алгуурч дөхөж байна.
- **Иргэдэд олгосон зээлийн өсөлтийн хурд 2022 оны эцсээс хойш эрчимжив:**
Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 15.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 32.4 хувиар өсжээ. Үүнд хадгаламж барьцаалсан болон тэтгэврийн зээлийн өсөлт гол жин дарж байгаа аж. Үүнийг дагаад импортын бүтцэд удаан эдэлгээтэй бараа буюу цахилгаан бараа, ахуйн хэрэгсэл, автомашины импорт нэмэгдэх хандлагатай байгааг Монголбанк тодотгов.

БАНКНЫ СЕКТОР

Манай улсын хувьд банкны салбар давамгайлсан зах зээлийн бүтэцтэй эдийн засагтай тул банкны салбарын эрүүл мэнд, тогтвортой байдал нь санхүүгийн системийн ерөнхий дүр зургийг харуулах чухал үзүүлэлт билээ. Тайлант онд банкны секторын нийт актив жилийн 24.2 хувийн өсөлт үзүүлж 57.0 их наяд төгрөгт хүрлээ. Активын дийлэнх хувийг иргэд, байгууллагад олгосон зээл бүрдүүлж байна.

ЗЭЭЛ

Банкны салбарын зээл 2023 оны эцсийн байдлаар нийт активын 48 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оноос 23.6 хувиар буюу 5.2 их наяд төгрөгөөр өсөж 27.4 их наяд төгрөгт хүрэв. Зээлийн өсөлтийг өмнөх онтой харьцуулахад 17.3 нэгж хувиар өссөн байгаа бөгөөд иргэдийн зээлийн өсөлт эергээр нөлөөлжээ. Тайлант оны эцсийн байдлаар нийт зээлийн 7.0 хувь нь чанаргүй зээл байна. Банкнуудын зээл олгосон голлох салбаруудаас уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарын чанаргүй зээлийн хувь 2023 оны эцэст харгалзан 24.7, 16.9, 19.7 хувь байна. Энэ нь банкны системийн дунджаас өндөр байгаа бол үл хөдлөх хөрөнгө 3.2 хувь, худалдааны салбар 5.2 хувьтай байгаа нь бусад салбаруудтай харьцуулахад бага байна.




ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ


Банкнуудын харилцах, хадгаламж 2023 оны эцсийн байдлаар пассивын 69%-ийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оноос 26.3 хувиар өсөж 34.9 их наяд төгрөгт хүрсэн байна. Харилцах, хадгаламжийн өсөлтийг өмнөх онтой харьцуулахад 18.7 нэгж хувиар өссөн байна. Тодруулбал, хадгаламж өмнөх оноос 26.6 хувиар өсөж 21.1 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд энэхүү өсөлтөд иргэдийн төгрөгийн хадгаламж өссөн нь нөлөөлжээ. Харин харилцах өмнөх оноос 25.8 хувиар буюу 2.8 их наяд төгрөгөөр өсөж 13.7 их наяд төгрөгт хүрсэн нь байгууллагын төгрөгийн харилцах нэмэгдсэнээр тайлбарлагдаж байна.

АШИГТ АЖИЛЛАГАА

2023 онд банкны салбар 1,294 тэрбум төгрөгийн ашигтай буюу өнгөрсөн оноос 21 хувиар илүү ашигтай ажиллаа. Цар тахлын нөлөө буурч, эдийн засаг сэргэхтэй зэрэгцэн банкны ашигт ажиллагаа сайжирч байна. Банкнууд ашигтай ажиллаж, банкнуудын өөрийн хөрөнгө нэмэгдэж байгаа нь банкны системийн эрсдэл даах чадварыг сайжруулж байна.



2023 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



МОНГОЛ УЛСЫН ХАМГИЙН ТОМ БАЙГУУЛЛАГЫН БАНК
БОЛОХ ХХБ IPO ХИЙЖ, ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ
КОМПАНИ БОЛЛОО.



中國銀行
BANK OF CHINA

Bank of China -тай стратегийнтүвшинд хамтран ажиллах санамж бичиг үзэглэлээ.



Монгол Япон хоёр улсын бизнесийн орчин, хамтын ажиллагааг сайжруулах зорилготой МОНГОЛ - ЯПОН бизнес форум зохион байгуулаа.



Монгол Улсад анх удаа худалдааны санхүүжилтийн форумыг зохион байгуулаа.

WORLD ECONOMIC FORUM


Монгол Улсаас анх удаа ХХБ Дэлхийн эдийн засгийн форумтай албан ёсны түнш боллоо.

25%


Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Гүйцэтгэх удирдлагаас бусад ажилтнуудын бүтээмжийн цалинг 25 хүртэлх хувиар нэмэгдүүллээ.




Монгол Улсад үйлчилгээний төгөлдөршил ISO23592, чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартуудыг нэвтрүүлсэн анхны банк боллоо.



Бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжээ нэмэгдүүлэх зорилгоор Голомт банк, Төрийн банк нартай хамтран гурван банкны картын харилцагчид харилцан нэгнийхээ ATM дээр бэлэн зарлагын гүйлгээг шимтгэл багатай хийдэг боллоо.



БНСУ-ын Сонгодо хотод зохион байгуулагдсан Азийн Хөгжлийн Банкны 56 дахь удаагийн олон улсын уулзалтад Худалдаа хөгжлийн банк уригдан оролцлоо.



Скай Хайпермаркет ХХК-тай хамтран Имарт сүлжээ дэлгүүрт WeChat Pay-р төлбөр хүлээн авах үйлчилгээг нэвтрүүллээ.

2023 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМААС ТОДРУУЛДАГ ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖИЙН 6 -Д ЭРЭМБЭЛЭГДЛЭЭ.




Зээлийн батлан даалттай бизнесийн ногоон зээлийг зах зээлд анх удаа нэвтрүүлээ.

NEXT SOLUTIONS

ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧ НАРЫГ ДЭМЖИХ ЗОРИЛГОТОЙ NEXT SOLUTIONS NETWORKING EVENT ЗОХИОН БАЙГУУЛЛАА.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар, ТоС Холбоо, IFS, ОУСК нартай хамтран Ногоон Санхүүгийн Олон Улсын Манлайлын Хөтөлбөр 2023 арга хэмжээг зохион байгууллаа.



Худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт зориулсан төлбөрийн шинэ шийдэл HAPPY POS үйлчилгээг зах зээлд анхлан нэвтрүүлээ.



Тогтвортой санхүүжилтийн холбооны Онцлох ТоС банкаар шалгарлаа.



АНУ-ын томоохон технологийн компани болох Genesys-с "GENESYS CX 2023" шагнал хүртлээ. Энэ нь АНУ-ын программ хангамжийн компаниас Монгол компани шагнал авч байгаа анхны тохиолдол юм.



MITSUI & CO.

Mitsui & Co., Ltd. компанитай хамтран Зэсийн Экспортыг дэмжих санхүүжилтийг амжилттай олголоо.



Хөдөө орон нутагт зээлийн батлан даалттай ипотекийн хөнгөлөлттэй зээлийг олж эхэллээ.



БҮС ба ЗАМ санаачилга ногоон хөрөнгө оруулалтын зарчмууд (GIP)-аас шалгаруулдаг "GIP AWARDS 2023" -н "Шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээ" үзүүлэгч байгууллагаар шалгарлаа.



Эйнштейн картыг зах зээлд амжилттай байршуулж, Cashback хөтөлбөрт e-commerce платформуудыг нэмснээр банкны харилцагчдын тоог залуу сегментээр амжилттай тэллээ.



Бритто картын харилцагч нартаа зориулсан Happy Pay хөтөлбөрийг эхлүүлж 2153 харилцагчаа урамшууллаа.

МОНГОЛ УЛС СААРАЛ ЖАГСААЛТАД ОРШНООС ХОЙШ АНУ-ЫН БАНКАНД АМ.ДОЛЛАРЫН НОСТРО ДАНС НЭЭСЭН АНХНЫ БАНК БОЛЛОО.

Монгол Улсыг дэлхийн ам.долларын төлбөрийн системд дахин холбосон амжилтыг олон улсад үнэлж "World Economic Magazine" сэтгүүлээс Монгол Улсын гадаад төлбөр тооцооны тэргүүлэгч банк буюу "Best Bank for Remittances Mongolia 2023" -аар шагналаа.



ХУРИМТЛАЛТАЙ
МОНГОЛ

БАЙРТАЙ
ХАДГАЛАМЖТАЙ
АЯН

Хуримтлалтай Монгол аяныг 4 дэх жилдээ амжилттай зохион байгуулж 250 харилцагчаа мөнгөн урамшууллаар урамшуулж, 10 харилцагчаа хосоор нь гадаад аялуулж, 1 харилцагчдаа ТАУН ХАУС бэлэглэв.



Иргэд болон жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулсан зээлийн үйлчилгээнүүдээ цахимжуулав.



Цаасгүй цахим салбараа шинээр нээлээ.

САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТУСДАА САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тэрбум төгрөгөөр		
	2021	2022	2023
Хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь мөнгөн хөрөнгө	976.4	1,756.2	2,308.7
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь мөнгөн хөрөнгө	504.4	767.1	1,651.8
Санхүүгийн хөрөнгө оруулалт	2,602.6	1,669.9	1,917.9
Охин болон хараат компани дахь хөрөнгө оруулалт	0.5	0.9	5.2
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	101.6	265.4	172.2
Эзэл ба урьдчилгаа	4,588.5	4,137.2	4,933.5
Бусад хөрөнгө	200.1	466.0	509.2
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	79.9	80.0	53.3
Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө	3.6	24.7	8.3
Үндсэн хөрөнгө, цэвэр	480.8	470.6	568.0
Ашиглах эрхтэй хөрөнгө	7.9	15.4	13.2
Биет бус хөрөнгө, цэвэр	2.3	1.4	25.3
НИЙТ ХӨРӨНГӨ	9,548.7	9,654.8	12,166.6
Өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	13.9	33.1	318.4
Буцаан худалдаж авах гэрээгээр борлуулсан үнэт цаас	289.8	316.8	51.3
Харилцагчдын харилцах, хадгаламж	6,266.3	6,207.3	9,086.8
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	78.0	166.2	159.1
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	1,408.7	1,418.8	872.7
Хоёрдогч өглөг	-	-	-
Гаргасан өрийн үнэт цаас	160.1	-	-
Бусад өр төлбөр	289.1	260.5	172.7
Түрээсийн өр төлбөр	9.0	15.9	13.9
Орлогын татварын өглөг	12.5	55.7	76.9
Хойшлогдсон татварын өглөг	1.0	2.5	6.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,528.6	8,476.8	10,758.2
Өөрийн хөрөнгө			
Хувьцаат капитал	323.8	323.8	340.9
Нэмж төлөгдсөн капитал	-	-	64.1
Дахин үнэлгээний нөөц	151.2	145.7	143.5
Борлуулах боломжит санхүүгийн хөрөнгийн хуримтлагдсан хэрэгжээгүй олз (гарз)	4.4	3.0	35.4
Тусгай зориулалттай нөөц	54.6	110.2	134.8
Хуримтлагдсан ашиг	486.2	595.3	689.8
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	1,020.1	1,178.0	1,408.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	9,548.7	9,654.8	12,166.6

ТУСДАА ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	2021	2022	2023
Хүүгийн орлого	597.1	674.1	764.7
Хүүгийн зардал	(405.6)	(354.5)	(469.0)
Хүүгийн цэвэр орлого	191.5	319.6	295.7
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого	44.4	50.4	61.4
Үйл ажиллагааны бусад орлого (алдагдал), цэвэр	(13.4)	13.9	54.7
Хүүгийн бус цэвэр орлого	31.0	64.4	116.1
Үйл ажиллагааны орлого	222.5	384.0	411.7
Үйл ажиллагааны зардал	(130.9)	(172.8)	(183.8)
Үнэ цэнийн бууралтын нөөцийн алдагдал	57.7	28.3	(35.4)
Хараат компанийн алдагдлаас ногдох хувь	(28.7)	0.4	4.3
Татварын өмнөх ашиг	120.5	239.9	196.8
Орлогын татварын зардал	(15.7)	(45.7)	(45.6)
Тайлант жилийн цэвэр ашиг	104.8	194.2	151.2

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2021	2022	2023
Ашигт ажиллагаа			
Зардлын орлогод эзлэх хувь	58.8%	45.0%	44.6%
Цэвэр хүүгийн зөрүү	2.9%	4.4%	3.7%
Өөрийн хөрөнгийн өгөөж	10.3%	16.5%	10.7%
Активын өгөөж	1.1%	2.0%	1.2%
Өсөлтийн харьцаанууд	2021	2022	2023
Активын өсөлт	17.6%	1.1%	26.0%
Зээлийн өсөлт	11.7%	-9.8%	19.2%
Харилцах, хадгаламжийн өсөлт	18.0%	-0.9%	46.4%
Өөрийн хөрөнгийн өсөлт	0.3%	15.5%	19.6%
Активын чанар	2021	2022	2023
Зээл / Харилцах, хадгаламж	73.2%	66.7%	54.3%
Зээлийн активт эзлэх хувь	48.1%	42.9%	40.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	40.6%	43.4%	49.7%
Өөрийн хөрөнгийн харьцаа	2022	2023	2023
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	13.0%	15.2%	16.6%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	13.0%	15.2%	16.6%

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Худалдаа, хөгжлийн банк нь хүн төвтэй хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэн ажилтнуудынхаа сайн сайхан байдал, цалин хөлсний өрсөлдөхүйц багц болон тасралтгүй сургалт хөгжил зэрэгт голчлон анхааран шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаа.



2023 онд давхардсан тоогоор 21439 ажилтныг 256 төрлийн 579 удаагийн сургалтад хамруулан ажиллав. Тайлант хугацаанд 1 ажилтан дунджаар 9.3 удаагийн сургалтад хамрагдсан байна. Мөн стратегитай уялдсан сургалтын хөтөлбөрүүдийг шинээр бий болгон нийт ажилтнуудын 82%-ийг тус сургалтуудад хамрууллаа.



Нийт ажилтны 82% сургалтад хамрагдсан

Бид олон улсын болон Монгол улсын тэргүүлэгч сургалтын платформ болох Udemy болон Melearn-тэй хамтран ажиллаж ажилтнуудад олон төрлийн сургалтын сувгийг санал болгож ажиллав. Мөн дотоодын программ хангамжийн тусламжтайгаар видео сургалтын санг бий болгож ажилтнууддаа цогц мэдээ мэдээллийг хүргэн ажилтнууддаа тасралтгүй сурч, хөгжих боломжоор хангаж ажиллаа.



- Олон улсын мэргэшсэн эрх олгох сургалт, шалгалтад хамрагдсан ажилтнууддаа зориулсан "Дэмжих хөтөлбөр - 2023"-г хэрэгжүүлэн 1000\$-ын буцаалтыг олгож эхлэв.
- "Удирдах ажилтан бэлтгэх хөтөлбөр", "Харилцааны менежер бэлтгэх хөтөлбөр" болон "Ахлах ажилтан бэлтгэх хөтөлбөр"-үүдийг амжилттай зохион байгуулж, 96%-ийн дундаж үнэлгээтэйгээр өндөрлөв.
- Гадаадын шилдэг их, дээд сургуулиудын 17 онлайн хөтөлбөрт ажилтнууддаа хамруулж мэргэшсэн эрхтэй ажилтнууд бэлтгэв.



САНХҮҮГИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ, ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН СТРАТЕГИ:

- 2023 онд бид нийт ажилтнуудынхаа цалинг дөрвөн жилийн турш тасралтгүй нэмэгдүүлэх Зөгийн үүр хөтөлбөрийг эхлүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд ТУЗ-ийн шийдвэрээр нийт ажилтныхаа бүтээмжийн цалинг 25 хүртэлх хувиар нэмэгдүүллээ.
- Ажилтнуудын зорилтот таргетын гүйцэтгэлийг үнэлэх, урт хугацаанд тогтвортой ажиллуулах зорилготой KPI-д суурилсан нэмэгдэл цалинг олгож эхлэв. Тус систем нэвтэрснээр ажилтнуудын сэтгэл ханамж, бүтээмжийн цалингийн дүн хэмжээ зэрэг нэмэгдэж эерэг үр дүнг бий болгов.
- Тайлант хугацаанд ажилтнууддаа хөнгөлөлттэй нөхцөлөөр 9 тэрбум төгрөгийн зээл олгож нийгмийн асуудлыг нь шийдвэрлэлээ.
- 120 гаруй шилдэг ажилтнаа Тайланд, Вьетнам, Жэжү, Хайнань арлаар аялууллаа.
- 200 гаруй ажилтнаа Монгол банк болон бусад байгууллагын шагналаар шагналаа.



БИЕЙН БОЛОН СЭТГЭЛ ЗҮЙН САЙН САЙХАН БАЙДАЛ:

- Нийт ажилтны ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангах, ажлын байран дээрээ сэтгэл ханамжтай, тогтвортой ажиллах боломжийг бий болгох "Уян хатан цагийн систем"-ийг хэрэгжүүлж байна.
- Банкны харилцагчтай шууд харилцдаггүй ажлын байрны ажилтнууд Business casual dress стандартаар хувцасладаг болов.
- Ажилтнуудын сэтгэл зүй, биеийн эрүүл мэндэд чиглэсэн Well being club-г үүсгэн байгууллаа. Давхардсан тоогоор 200 гаруй ажилтнууд тус клубийн үйл ажиллагаанд хамрагджээ.
- Томоохон 100 гаруй байгууллагатай хамтран "TDB Employee Benefit Book"-г хэрэгжүүлж ажилтнуудын санхүүгийн сайн сайхан байдалд дэмжлэг үзүүллээ.



УЯН ХАТАН
ЦАГИЙН СИСТЕМ



BUSINESS
CASUAL DRESS



Well-being
club



TDB EMPLOYEE
BENEFIT BOOK



АЗ ЖАРГАЛТАЙ АЖИЛТАН, АЗ ЖАРГАЛТАЙ ХАРИЛЦАГЧ:

- Салбар, тооцооны төвд ажиллаж буй 1000 гаруй ажилтны сэтгэл ханамжийн судалгааны хувь дунджаар 85% байна.
- Залгамж халаа болсон шинэ ажилтнуудаас улирал бүр Дасан зохицох хөтөлбөрийн судалгаа авахад дундаж хувь 98 гэж үнэлэгдэв.
- Ажилтанд чиглэсэн сайн дурын 8 клуб тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:
 - Хувь хүний хөгжлийн клуб
 - Good readers club
 - English speaking club
 - Спорт хамтлаг
 - E-Sport club
 - Жендер нетворкинг клуб
 - Hiking club
 - Digital transformation club
- Тайлант хугацаанд "TDB Quiz Night", "TDB Open Mic", "TDB 33 Quiz", "Баярлалаа аян" зэрэг ажилтан хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх үйл ажиллагаанууд зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 1200 гаруй ажилтан оролцжээ.



INFORMATION
174-81
LG CNS

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА





SAVE THE PLANET

Хөгжмөөр дамжуулан шинэ залуу үеэ эх дэлхийгээ хайрлан, хамгаалахыг уриалсан Save The Planet контенттой хамтран ажиллав. Мөн энэ хүрээндээ биет картын пластик бэлдцийг байгаль орчинд хортой хог хаягдал болгохгүй байхыг уриалж, сошиал контент бүтээж түгээв.



ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТНУУД

Монгол Улсын хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах эрхэм үйлсийн эзэд болсон эмч, эмнэлгийн ажилтнуудыг ипотекийн зээлд тэргүүн ээлжид хамруулж эхэллээ.



МОНГОЛЧУУДЫН ТҮҮХ

Өв соёлоо эрхэмлэн дээдлэгч үндэсний банк болохынхоо хүрээнд Монголчуудын түүх контентыг ивээн тэтгэж, түүх соёлоо залуу үедээ өвлүүлэн түгээх ажлыг дэмжив.

ХЯЗГААРГҮЙ МӨРӨӨДӨЛ

Бид 2018 оноос эхлэн хүүхэд, залууст оюуны хөрөнгө оруулалт хийх зорилготой Хязгааргүй мөрөөдөл төслөө эхлүүлсэн. Тайлант онд ч мөн төслөө хэрэгжүүлж нийт 55 сургуулийн номын санг тохижуулж, номын фондыг нь баяжуулж өгөөд байна. Төслөөрөө дамжуулан 200 мянга орчим хүүхэд залуусыг «БҮТЭН» боловсролоор дэмжихийн төлөө ажиллаа.



BNY MELLON

АНУ-н клирингийн топ банк болох Bank of New York Mellon -д ностро данс нээх болзлоо хангалаа. Ингэснээр Монгол Улс ФАТФ-н саарал жагсаалтад орсноос хойш эргэн дэлхийн ам.долларын төлбөрийн системд нэгдэж чадахаар болов.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар, ToC Холбоо, IFS, OUSK болон бусад гадаад, дотоодын дэмжигч байгууллагатай хамтран Ногоон Санхүүгийн Олон Улсын Манлайллын Хөтөлбөр 2023-г зохион байгууллаа. Энэ үеэр Монгол Улс ТХЗ-ын таксономи баталсан дэлхийд анхдагч улсуудын нэг боллоо.



БИЗНЕСИЙН ОРЧИН

Тайлант онд AustCham Mongolia MYTHS & LEGENDS гала арга хэмжээ, TDB and JICA business matching event, NEXT SOLUTIONS networking event, TRADE FINANCE FORUM 2023, JAPANESE - MONGOLIAN business networking event, INVEST KHOVD 2023, Bloomberg TV Mongolia awards 2023 зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, дэмжин ажиллаа. Ингэснээр Худалдаа, хөгжлийн банк Монгол Улс болон гуравдагч хөрш улс хоорондын бизнесийн нөхцөл байдал, эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэлээ.



Монгол Улсад анх удаа худалдааны санхүүжилтийн форум зохион байгууллаа. Худалдаа, үйлчилгээний бизнесийн орчныг шинээр харж, сорилт бэрхшээл, амжилт ололт, шинэ боломжийг хүндэт харилцагч, бизнесийн итгэлт түншүүдтэйгээ хамт хэлэлцлээ.



Welcome to Mongolia уриатай Монголын эдийн засгийн форум 2023 арга хэмжээг дэмжин ажиллав. Форумын үеэр IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгөө ногоон санхүүжилтэд зарцуулах ба цаашид ч тогтвортой санхүүжилтийн дүнг нэмэгдүүлэн ажиллах тухайгаа олон нийтэд зарлав.



СЕКТОРЫН ХАМГИЙН ӨНДӨР ЦАЛИН

Банкны ажилтнуудын сэтгэл ханамж, сайн сайхан байдал, амьдралын чадавхыг дээшлүүлэх зорилгоор нийт ажилтнуудын бүтээмжийн цалинг 25 хүртэлх хувиар нэмлээ.



MONGOLIAN OPEN INNOVATION CO-CREATION FOR SDG'S

Жайка олон улсын байгууллагатай хамтран Монгол улсад тулгарч буй нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх санал, санаачилга, шийдэл гаргах төсөл зохион байгуулав. Шалгарсан төслийг ивээн тэтгэж, дэмжин ажиллахаар болов.



Монгол Улсын хүүхэд залууст зориулсан шинжлэх ухааны цорын ганц эвент арга хэмжээ болох WORLD SPACE WEEK -г ивээн тэтгэж, 30 мянга гаруй хүүхдийг шинжлэх ухаанд дуртай болгохын төлөө ажиллав.



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТТАЙ НОГООН ЗЭЭЛ

Зээлийн батлан даалтын сантай хамтран батлан даалттай бизнесийн ногоон зээлийг зах зээлд анх удаа нэвтрүүллээ. Мөн хөдөө орон нутагт зээлийн батлан даалттай ипотекийн хөнгөлөлттэй зээлийг олгож эхэллээ.



Улаанбаатар хотын хүний урсгал ихтэй дүүрэг дэх барилгын хана талбайд Happy Art урсгалын зургууд зурж байршууллаа. Энэ нь иргэдийн сэтгэл зүйг илүү эрч хүчтэй, эерэг байлгахад тустай нийгмийн нөлөөллийн ажил болов.



Bloomberg LED MEDIA SCREEN

Төр болон хувийн хэвшлийн байгууллагаас хэрэгжүүлж буй нийгэм, байгаль дэлхийн сайн сайхны төлөөх үйл ажиллагаануудыг дэмжиж ажиллав. Дэмжлэгийн хүрээнд 4 байгууллагын 8 төрлийн видеог төв байрны гадаа байрлах дэлгэцээрээ тус бүр 14 хоногоос дээш хугацаанд үнэгүй байршууллаа.

БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ


Худалдаа, хөгжлийн банк нь Монгол Улсын шилдэг байгууллагын банк тодотголтойгоор үйл ажиллагаагаа явуулдаг. Мөн бид "Харилцагч төвтэй банк болох" урт хугацааны стратеги зорилготой ажиллаж байна. Энэ хүрээндээ харилцагчдын эрэлт хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох, оновчтой сувгаар борлуулах, харилцагчаа халамжлахад ихээхэн анхаарч байгаа юм. Үр дүнд нь харилцагчид хүрэх үнэ цэнийг нэмэгдүүлж, хүлээлтээс давсан үйлчилгээг харилцагч нэг бүрд үзүүлэх болно.

2023 онд эдийн засгийн хөдөлгөгч хүч болсон уул уурхай, худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилга зэрэг салбар бүрийн манлайлагч 2700 гаруй томоохон аж ахуй нэгж байгууллага, групп компаниудтай хамтран ажиллаа. Харилцагч байгууллагуудын бизнесийн хэрэгцээ шаардлагад нь нийцсэн зээл, хадгаламж, худалдааны санхүүжилт болон төлбөр тооцооны 60 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж байгаа юм. Бид харилцагч нэг бүрийнхээ бизнесийг дэмжин, харилцан ашигтайгаар, хамтдаа хөгжин дэвшсээр байна.

ЗЭЭЛ, ЭХ ҮҮСВЭР

Бид банкны системийн том байгууллагын зээлийн 39%, байгууллагын харилцах, хадгаламжийн 24% тус тус бүрдүүлж байна.

НИЙТ ЗАХ ЗЭЭЛ



Худалдаа, хөгжлийн банк

НИЙТ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ



Худалдаа, хөгжлийн банк



ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ

Гадаад худалдааны хэмжээ өсөхийн хэрээр импорт, экспортын аккредитив болон инкассын үйлчилгээгээр бизнес эрхлэгчид эрсдэлээ бууруулж, хамтын ажиллагаагаа тэлсээр байна.

2023 онд байгууллагын сегментийн харилцагчдад гаргасан нийт аккредитив, баталгааны дүнг өмнөх оны эцсээс 24.6%-аар нэмэгдүүллээ.

Бид харилцагчийн бараа бүтээгдэхүүний эргэцийг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд тогтвортой тоглогч байх нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримталж байна. Түүнчлэн бараа материал барьцаалсан тээвэр ложистик, гаалийн төлбөрийг санхүүжүүлэх шинэ төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ.

Тайлант онд Худалдааны салбарын харилцагч нартаа зориулан Trade Finance Forum арга хэмжээг амжилттай зохион байгуулж, Худалдааны санхүүжилтийн 3F (Freight forwarding, Factoring, Forfaiting) бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн нэвтрүүлсэн онцлог жил байлаа.



НОГООН САНХҮҮЖИЛТ

Худалдаа, хөгжлийн банк нь байгаль орчинд ээлтэй бизнесийг дэмжин санхүүжүүлэх замаар урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгох "Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн систем" (БОНЭМС) хэмээх шинэ ойлголтыг Монгол Улсдаа цогцоор нь хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хүрээнд шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ дамжуулан банкны секторт тэргүүлэн ажиллаж байна.

Олон улсын банк болох стратегийн зорилгын хүрээнд даян дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх, Ногоон банк болох гэсэн зорилтуудыг тодорхойлж, эдгээрийн биелэлтийг хангахад чиглэсэн "Climate 30+ Ногоон сэргэлтийн хөтөлбөр"-ийг санаачлан эхлүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд 30.2 тэрбум төгрөгийн зээлийг доорх үйл ажиллагааны зориулалтаар олголоо.

CLIMATE 30+

НОГООН СЭРГЭЛТИЙН ХӨТӨЛБӨР

2023 ОНД НИЙТ 30.2 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙГ
ДАРААХ ЗОРИУЛАЛТААР ОЛГОСОН БАЙНА



Эрчим
хүчний
хэмнэлт



Тогтвортой
ус, хаягдлын
хэрэглээ



Бага
бохирдуулагч
эрчим хүч



Тогтвортой хөдөө аж ахуй,
газар ашиглалт, ой болон
эко аялал жуулчлал



Сэргээгдэх
эрчим хүч



Бохирдлоос сэргийлэх,
бууруулах үйл ажиллагаа

12.3
ТЭРБУМ

Мөн тайлант онд Зээлийн батлан даалтын сантай хамтран бага хүүтэй, урт хугацаатай бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүлж, 12.3 тэрбум төгрөгийн ногоон зээлийн хүсэлтийг судалж байна.

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

Худалдаа, хөгжлийн банк нь Эдийн засаг, зах зээлд үзүүлж буй Цар тахлын нөлөөллийг бууруулах, бизнес эрхлэгчдийг дэмжих, эдийн засгийг сэргээх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүд болон Монголбанк, Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, харилцагч нараа дэмжин ажилласаар байна.

Дараах төсөл хөтөлбөрүүдийг идэвхтэй дэмжин, 2023 онд нийт **2031** тэрбум төгрөгийн зээлийг шийдвэрлэн ажилласан. Ингэснээр харилцагч нарынхаа газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, зоорь агуулах, хүүхдэд чиглэсэн сүү, сүүн бүтээгдэхүүн, талх нарийн боов, гурилын үйлдвэр гэх мэт төсөлд хөрөнгө оруулалт хийж, эргэлтийн хөрөнгийн санхүүжилт олголоо.

Мөн Монгол улсын шатахууны нөөц бүрдүүлэх, шатахууны хангамжийн тасралтгүй байдлыг хадгалах, баталгаажуулсан захиалгын нийлүүлэлт тасалдахаас сэргийлэн шатахуун импортлогч харилцагч нарынхаа нийт **198.6** тэрбум төгрөгийн санхүүжилтийг сунган ажиллаа.

Түүнчлэн аялал жуулчлалын салбарыг дэмжих зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг баталгаажуулахаар ажиллаж байна.

ҮҮНД:

- Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалт - **167.8** тэрбум төгрөг
- Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн санхүүжилт - **3.0** тэрбум төгрөг
- 2024 оны мал, мах бэлтгэх, махны нөөц бүрдүүлэх зориулалтын зээл - **20.0** тэрбум төгрөг
- Дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих хөтөлбөр - **2.9** тэрбум төгрөг
- Ноолуур бэлтгэлд зориулан олгох хөтөлбөр - **9.4** тэрбум төгрөг



МОНГОЛБАНК
МОНГОЛ УАСЫН ТӨВ БАНК



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Байгууллагын харилцагч нарынхаа үйл ажиллагааг дэмжих, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэхээр шинээр 5 төрлийн бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлэн, борлуулж эхэллээ.



ЗБДС- БИЗНЕСИЙН НОГООН ЗЭЭЛ

Зээлийн батлан даалтын сантай хамтран ЖДҮ эрхлэгчдэд зориулан бага хүүтэй, урт хугацаатай Бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүллээ.



ЗАРЛАГА ГАРГАХ ЭРХТЭЙ ХАДГАЛАМЖ

Гэрээний хугацааны дундуур зарлага гаргах боломжтой уян хатан нөхцөлтэй, санхүүгийн хэрэгцээгээ шийдвэрлэх боломжтой Хадгаламжийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүллээ.



ФАКТОРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагчдын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан үл хөдлөх хөрөнгө шаардахгүй, байгууллага хоорондын авлагыг барьцаалан богино хугацааны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зориулалттай Факторингийн үйлчилгээг зах зээлд анхлан нэвтрүүллээ.



ТЭЭВРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭРХ

Импортлогч аж ахуйн нэгж, байгууллагад үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах, захиалсан бараа материалаа цаг хугацаандаа авах боломжийг олгосон Тээвэрлэлтийн төлбөр болон Гаалийн төлбөрийг санхүүжүүлэх бүтээгдэхүүн шинээр нэвтрүүллээ.



ЗБДС-ТАЙ ХАМТАРСАН ЭКСПОРТЛОГЧДОД ЗОРИУЛСАН ЗЭЭЛ

Зээлийн батлан даалтын сантай хамтран Экспортлогч компаниудын эрэлт хэрэгцээнд нийцсэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий бага хүүтэй, урт хугацаатай Эргэлтийн хөрөнгийн зээлийг шинээр нэвтрүүллээ.

ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН ЗАХ ЗЭЭЛ


Худалдаа, хөгжлийн банк нь “харилцагч төвтэй банк байх” стратеги чиглэлийн хүрээнд жижиг, дунд бизнесийн зах зээлийн тэлэлдээ ихээхэн анхаарч ажиллаж байна. Ингэхдээ гаднын хямд эх үүсвэрээр жижиг, дунд бизнес эрхлэгчдийн гарааны бизнесийг эхлүүлэх, өргөжүүлэх, чадавхжуулах зэрэг олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлж байгаа юм. Мөн цаашлаад санхүүжилтийн эко системийг бий болгож, санхүүгийн уламжлалт болон дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, байгаль орчин, нийгэмд ээлтэй банк байхыг зорьж байна.

Жижиг дунд сегмент нь иргэн болон байгууллагыг багтаасан маш онцлог сегмент юм. Сегментийн идэвхтэй 78,449 жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагч нар байна. Бид салбар, тооцооны төв болон цахим сувгаараа дамжуулан банкны суурь бүтээгдэхүүн үйлчилгээг, олон улсын стандартаар харилцагч нартаа хүргэж байна.

Тайлант онд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 785.86 тэрбум төгрөг болж, өөрийн банкны зээлийн багцын 15.5%-ийг бүрдүүллээ. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн хувьд 1,105.40 тэрбум төгрөг болж, өөрийн банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн 12.4%-ийг эзэлж байна.

Жижиг, дунд сегментийн бизнес эрхлэгч байгууллага нарын **34%** нь худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг. Харин барилгын салбарт 13%, Үйлчилгээний салбарт 11%, Тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт 6%, бусад салбарууд үлдсэн 37%-г эзэлж байна.

SME ХАРИЛЦАГЧ



Зээлийн багцын үлдэгдэл
785.86 тэрбум төгрөг

Татан төвлөрүүлсэн хөрөнгө
1,105.40 тэрбум төгрөг

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ

Ажлын байр шинээр бий болгох, хадгалах, өргөтгөх зорилгоор хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч болон гадаад улсаас эх орондоо ажиллаж амьдрахаар ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөнгөлөлттэй санхүүжилтийг санал болгож жижиг зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэн олголоо.



ГЭРЭЭ БАРЬЦААЛСАН ЗЭЭЛ

Барьцаа хөрөнгийн дутагдалтай бизнес эрхлэгч аж ахуй нэгжийн богино хугацааны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор төрийн байгууллага болон хувийн аж ахуйн нэгж, иргэний хооронд хийгдсэн бараа нийлүүлэх гэрээгээр зохицуулагдсан ирээдүйд орж ирэх орлогоор төлөгдөх боломжтой зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.



СҮЛЖЭЭ ДЭЛГҮҮРИЙН АВЛАГА БАРЬЦААЛСАН ЗЭЭЛИЙН ЭРХ

Сүлжээ дэлгүүрт бараа, бүтээгдэхүүн нийлүүлдэг ханган нийлүүлэгчид нь барааны төлбөр орж ирэх өдрийг хүлээх шаардлагагүйгээр авлагаа барьцаалан богино хугацааны эргэлийн хөрөнгөө санхүүжүүлэх, барааны эргэлтийг сайжруулах боломжийг олгох зорилготой зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн.



ҮЙЛЧИЛГЭЭ

Сүүлийн үеийн дэвшилтэт технологи ашиглан андройд гар утасны NFC-ээр дамжуулан картын төлбөрийг хүлээн авах боломжтой худалдаа, үйлчилгээнд зориулсан төлбөрийн шинэ шийдэл HAPPY POS үйлчилгээг зах зээлд нэвтрүүллээ. Уг бүтээгдэхүүний онцлог нь мерчантаар элсэхийг хүссэн иргэн, аж ахуй нэгжид үйл ажиллагааны чиглэлээс үл хамааран үнэ төлбөргүй ухаалаг төхөөрөмж дээр нь суурилуулах юм.



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭХ ҮҮСВЭРТЭЙ БАТЛАН ДААЛТТАЙ БИЗНЕСИЙН НОГООН ЗЭЭЛ

Ногоон бизнесийг дэмжих замаар барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөжүүлэх, шинэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг олгох, ногоон эдийн засгийг дэмжих зорилготой зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.

ИРГЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Тайлант онд Худалдаа Хөгжлийн Банк иргэдийн сегментийн зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж, харилцагч нарт цоо шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэх, уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээгээ цахимжуулах чиглэлд түлхүү ажиллаа. Үүний үр дүнд бид хугацаатай хадгаламжийн секторт эзлэх хувиа 20.9%-д хүргэж чадлаа. Цаашид ч харилцагчдад хүргэж буй бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээндээ технологи, инновацыг шингээн илүү хялбар шийдлийг хүргэх болно.



Банкны дунд хугацааны зорилтын нэг нь хоёр сая харилцагчтай болох ба тайлант онд бид зорилгодоо илүү ойртож 931 мянган харилцагчтай боллоо.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Бид харилцагч нартаа бусад арилжааны банкнуудаас илүү уян хатан нөхцөлтэй хадгаламжийн бүтээгдэхүүн санал болгож ирсэн. 2023 оны хувьд ч мөн адил хамгийн өндөр хадгаламжийн хүүг харилцагч нартаа санал болголоо.

Монгол улсын иргэн бүрийг хуримтлалтай болгох, хуримтлалын ач тусыг таниулан мэдүүлэх, түүнийг нь урамшуулах зорилготой Хуримтлалтай Монгол аянаа 4 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. Үүний үр дүнд бид 2023 онд 13%-ийн өсөлт үзүүлж чадлаа.

ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ



Худалдаа, хөгжлийн банк

ЗЭЭЛ

Харилцагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүх төрлийн санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэн ажиллаж байна. Монгол улсын инфляц, бүтээгдэхүүний үнийн өсөлт, иргэдийн худалдан авах чадвар гэх мэт олон хүчин зүйлсээс хамааран иргэдэд санхүүгийн олон шаардлага үүсдэг. Энэхүү хэрэгцээг санхүүгийн болон өрийн дарамтад оруулахгүйгээр хангуулахын тулд олон шинэ үйлчилгээг зах зээлд нэвтрүүллээ. Бидний баримталж буй үндсэн зорилго бол харилцагчийн сэтгэл ханамжийг хамгийн өндөр түвшинд байлгах юм. Үүнийхээ хүрээнд бид системийн нөлөө бүхий банкнуудаас хамгийн бага хүүтэй зээл олгон ажиллаж байна.

ДААТГАЛ

Бид даатгал зуучлалын үйлчилгээндээ харилцагчийн эрх ашиг бүрэн хамгаалагдаж, гэрээний дагуу даатгалын хамгаалалтаа авч байх зарчмыг нэн тэргүүнд баримталж ажилладаг. Энэ хүрээндээ өнгөрөгч онд нийт 6.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг харилцагч, даатгуулагч нартаа олгууллаа. Түүнчлэн зуучлалын үйлчилгээний гол зорилго нь талуудын эрх ашгийг харилцан эрх тэгш байлгахад оршдог. Бид хамтран ажиллагч даатгалын компаниуддаа нийт 7.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж, банкны даатгал зуучлалын салбарт тэргүүлэгч байр сууриа амжилттай хадгаллаа.



Харилцагчид

6.2 тэрбум төгрөгийн
нөхөн төлбөр



Даатгалын компаниуд

5.46 тэрбум төгрөгийн
хураамжийн орлого

ТАЙЛАНТ ОНД ОНЦЛОХ:



БАГЦ ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагчдын эрэлт хэрэгцээнд тулгуурласан, хүлээлтээс давсан цогц үйлчилгээг хүргэх зорилгоор "Платинум багц", "Эйнштэйн залуусын багц" бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүллээ. Тус багцыг авснаар харилцагчид банкны зарим бүтээгдэхүүн, үйлчилгээг шимтгэл, хураамжгүйгээр ашиглах юм.



ЦАХИМЖУУЛАЛТ

Ногоон банк, Дижитал банк болох стратеги зорилтуудынхаа хүрээнд иргэдэд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг цахимжуулж ажиллаа. Ингэснээр харилцагч нарын цаг хугацааг хэмнэж, банкны үйлчилгээг хэзээ ч, хаанаас хялбар авах боломжийг бүрдүүлж байна. Үүнд:

- Хадгаламжийн гэрээ
- Тэтгэврийн зээл
- Цалингийн зээл /Бүх банкны харилцагч нар/
- Хэрэглээний зээл
- Автомашины зээл



ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ

Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг нэмэгдүүлэх зорилгоор Зээлийн батлан даалтын сантай хамтран урьдчилгаа төлбөрийн батлан даалттай ипотекийн зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүллээ. Мөн бусад банканд үлдэгдэлтэй орон сууцны зээлээ дахин үнэлүүлэн шинэ зээл авах боломж бүхий цоо шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв. Түүнчлэн "Ногоон хувийн сууц"-ны зээлийн нөхцөлийг сайжруулан нэмэлт барьцаа хөрөнгө шаардлагагүйгээр авах боломжийг бүрдүүлсэн.



ГАДААДЫН ИРГЭД

Банк иргэдийн зах зээлээ тэлэх бодлогын хүрээнд Монгол улсад аялахаар болон бизнес эрхлэхээр ирж буй гадаад улсын иргэдэд харилцах болон хадгаламжийн данс нээж эхэллээ. Гадаадын иргэдээс Монгол Улсад оршин суух үнэмлэх шаардахгүйгээрээ онцлог юм.

ХУРИМТЛАЛТАЙ МОНГОЛ

Хуримтлалтай Монгол урамшуулалт аянаа 4 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. Аяны хүрээнд харилцагч нараа хуримтлуулсных нь төлөө хадгаламжийн эрх, гадаад улсаар аялах эрх зэргээр урамшуулсан юм. Мөн супер урамшууллын эзэндээ гал голомт бадраах **ТАУН ХАУС** бэлэглэсэн. 2023 оны аянд давхардсан тоогоор **500,000** гаруй харилцагч оролцон, хуримтлалын ач холбогдлыг таньж мэдлээ.

Түүнчлэн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хуримтлалын ашиг тусыг таниулах зорилготой Дэлхийн хуримтлалын өдөр аянд идэвхтэй оролцлоо. Аяны хүрээнд хуримтлалын ач холбогдлыг таниулах, цахим халдлагаас сэргийлэх сургалтад ЕБС-ын 70 сургууль, **500** багш, **3150** сурагчийг хамруулсан байна.

VISA DIRECT P2P

Бид Visa картаа ашиглан гадаад улс руу шилжүүлэг хийх “Visa Direct P2P” үйлчилгээг Монгол улсад анх удаа нэвтрүүлсэн. Тус үйлчилгээ өмнө нь 13 улс руу шилжүүлэг хийдэг байсныг өргөжүүлэн 28 улс руу гүйлгээ хийдэг боллоо.

HAPPY PAY

Visa International байгууллагатай хамтран виза картын хэрэглээг нэмэгдүүлэх, харилцагчаа халамжлах Happy pay урамшуулалт хөтөлбөрийг эхлүүллээ. Энэхүү хөтөлбөрөөр дамжуулан тайлант онд нийт 2153 харилцагчдаа мөнгөн урамшуулал олгосон байна.



ИРГЭДИЙН ЗЭЭЛИЙН ЧАНАР

Худалдаа Хөгжлийн Банк харилцагч нарынхаа зээлийн чанарыг сайжруулахад ихээхэн анхаарч ажилласан. Энэ хүрээндээ зээлтэй ажиллах аргачлалыг шинэчилж, зээл олголтын процесс болон судалгаа шинжилгээг сайжрууллаа. Мөн Genesys cloud буюу call center (Харилцагчийн мэдээллийн хэлтэс)-ийн системийг шинээр ашиглаж холбогдох харилцагчийн тоог нэмэгдүүлсэн юм. Үр дүнд нь бид иргэдийн сегментийн зээлийн багцыг системийн хамгийн бага түвшинд буюу 1.01%-д хүргэж чадлаа. Энэхүү үр дүнг дагаад зээлийн хүүгийн орлого нэмэгдэх, эрсдэлийн сангийн зардал буурах зэрэг олон эерэг өөрчлөлт гарсан юм.


ЦАХИМ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ




КАРТ, ТӨЛБӨР ТООЦОО

Бид харилцагч төвтэй банкны үйлчилгээ үзүүлэх эрхэм зорилгынхоо хүрээнд дижитал шинэчлэл, инновацыг нэвтрүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээнүүдээ зайнаас, түргэн шуурхай хүргэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаа.

Тайлант онд төлбөрийн карт хэрэглэгчдийн тоо 2022 онтой харьцуулахад 17%-аар нэмэгдлээ. Монгол Улсын Виза картаар гадаадад хийгдэж буй гүйлгээний 37% -с дээш хувийг манай банкны Виза картаар хийсэн байна. Бид Монгол Улс дахь хамгийн том, хамгийн найдвартай картын систем бүхий банк болохоо дахин нотоллоо.

 17%+
Карт эзэмшигчид

 37%+
Гадаадад хийгдсэн гүйлгээний зах зээлд эзлэх хувь

Энэхүү амжилтад хүрэхийн тулд бид харилцагчийнхаа зан төлөв, хэрэглээн дээр тулгуурлан шинэ картын бүтээгдэхүүн, олон төрлийн урамшууллын хөтөлбөрүүд, маркетинг идэвхжүүлэлтийн ажлуудыг хийлээ.



Бритто Виза картын харилцагч нартаа зориулж Улаанбаатар хот болон орон нутгийн 200 гаруй үйлчилгээний байгууллагатай хамтран 3-20%-ийн буцаан олголтын урамшуулал олгож байна.

CASHBACK 3-20%

Германы алдарт онолын физикч эрдэмтэн Альберт Эйнштейнийн хөрөгтэй Эйнштейн картыг зах зээлд амжилттай байршуулж, банкны харилцагчдын тоог шинэ харилцагчид болох залуу сегментээр амжилттай тэллээ. Cashback хөтөлбөрийн хамтрагч брэнд, платформуудыг нэмснээр картын борлуулалт болон гүйлгээний дүн тогтмол өссөн. Тэр дундаа e-commerce олон улсын гүйлгээний дүн эрчимтэй нэмэгдэж байна.




Харилцагчаа зайнаас бүртгэх, бүтээгдэхүүн үйлчилгээгээ илүү хялбар болгох үүднээс шинэ картын захиалга хүлээн авах суваг www.cardcenter.mn-г нээлээ. Шинэ сувгаа ашиглан онлайнгаар нэг цагийн дотор 1000 ширхэг картын захиалга авч, түүхэн борлуулалт хийв.



ТИ ДИ БИ ОНЛАЙН

ТиДиБи Онлайн хэрэглэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 24% өссөн байна. Банкны цахим сувгаар хийгдсэн гүйлгээний дүн 33% нэмэгдлээ.



Тайлант онд харилцагчдын цахим банкны хэрэглээг нэмэгдүүлэх, тасралтгүй хэвийн ажиллагааг хангах үүднээс дараах ажлуудыг систем болон хамтран ажиллагч байгууллагуудын хүрээнд хийж хэрэгжүүллээ. Үүнд:

- ТиДиБи Онлайн үйлчилгээний системийн архитектурыг шинэчилснээр системийн ачаалал даах чадвар нэмэгдэж, мобайл аппликейшний ажиллах хурд нэмэгдлээ.
- Тэтгэврийн зээл, ПОС орлого барьцаалсан зээлийг онлайнд шинээр нэвтрүүлэв. Ингэснээр харилцагч онлайн банкнаасаа хэзээ ч, хаанаас ч зээл авах боломжтой боллоо.
- Харилцагчийн хуримтлал үүсгэх дадлыг нэмэгдүүлэх, өөрийн хүссэн санхүүгийн зорилгодоо хүрэх боломжийг олгох "Миний Зорилго" функцийг онлайнд шинээр нэвтрүүлэв.
- Монголбанкнаас хэрэгжүүлсэн QR-ын шинэчилсэн стандартын дагуу холбогдох хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэлээ. Ингэснээр шинэ стандартаар төлбөр, тооцоогоо гүйцэтгэдэг боллоо.
- Монгол Улсад аялж буй гадаадын иргэдэд зориулсан шинэ эрхийн багцыг онлайнд бий болгов. Ингэснээр Монгол улсад зорчин, аялж буй гадаад иргэд төлбөр тооцоогоо ямар нэг саадгүй гүйцэтгэдэг боллоо.

ПОС ТӨХӨӨРӨМЖ

ПОС мерчантын тоо өмнөх онтой харьцуулахад 9% өссөн байна. Мөн ПОС терминалаар хийгдсэн гүйлгээний дүн 8% нэмэгдлээ.



9%
ПОС мерчантын
тоо

8%
ПОС терминалаар
хийгдсэн гүйлгээний дүн



Мерчант харилцагч нарт банкны үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дараах шинэчлэлтүүдийг хийлээ.

- ПОС терминалын дэлгэц дээрх QR code-ыг гар утсаараа уншуулан төлбөр төлөх
- Андроид ПОС терминал дээр мерчант байгууллага дотооддоо ашигладаг аппликейшныг суулган ашиглах
- ПОС дээр визний төлбөр хүлээн авах
- Мерчантын бүртгэлийн дотоод системийн бүрэн шинэчлэл

АТМ ТӨХӨӨРӨМЖ



Харилцагчийн үйлчилгээний нөхцөлийг сайжруулах зорилгоор 2022 онд Голомт банктай хамтын ажиллагаа эхлүүлсэн. Харин тайлант онд Төрийн банк, Капитрон банкнуудтай хамтран ажиллаж эхэллээ.

Хамтын ажиллагааны хүрээнд зарлагын гүйлгээний шимтгэлийг багасгаж, талуудын өөртөө үйлчлэх банкны төхөөрөмж /ATM, CDM, CRM/ дээр бэлнээр зарлага гаргахад шимтгэл 500₮ байсныг 100₮ болгон бууруулаад байна. Ийнхүү шимтгэлийг бууруулснаар харилцагчид Улаанбаатар хот болон орон нутагт байрлах Худалдаа хөгжлийн банкны **280**, Голомт банкны **410**, Төрийн банкны **328**, Капитрон банкны **29**, нийт **777** АТМ төхөөрөмжөөр хөнгөлөлттэй нөхцөлөөр гүйлгээ хийх боломж бүрдсэн.

ШИМТГЭЛ:

500₮ > **100₮**

Арилжааны банкнууд уян хатан хамтын ажиллагааг хэрэгжүүлж, салбарын хөгжилд хамтран хувь нэмрээ оруулахаар зорьж байна. Цаашлаад банк хоорондын үйлчилгээний чанарыг сайжруулах, нийт харилцагчдын сэтгэлд нийцсэн үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн олон асуудалд хамтран ажиллахаар төлөвлөж байна.

КЛИРИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Худалдаа Хөгжлийн Банк нь банкны секторын анхны бөгөөд цор ганц Клирингийн банк юм. Тайлант онд энэхүү эко системийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд эрхлэх зөвшөөрлөө хугацаагүйгээр дахин сунгаж, байр сууриа бататгалаа. 2023 онд Монгол Улсын арилжааны 13 банкны 4 банк нь манай клирингийн системд холбогдож, өөрсдийн картын бизнесийн болон технологийн үйлчилгээг авч байна.

Арилжааны банкнууд өөрсдийн төлбөрийн систем, техник программ хангамж, системийн аюулгүй байдлын найдвартай байдал зэргээ хангахын тулд их хэмжээний хөрөнгө оруулалтын давхардсан зардлууд гаргадаг. Харин бид "Систем ажиллуулах" болон "Аутсорсингийн үйлчилгээ авах" зөвшөөрлийг авснаар дээрх зардлуудыг бууруулах боломж бүрдүүлж байгаа юм. Мөн бусад хураамж, шимтгэлийг ч бууруулах онцгой ач холбогдолтой. Цаашлаад ББСБ-ууд болон финтек компаниуд ч энэхүү дундын үйлчилгээг ашиглаж, бага зардлаар харилцагчдадаа найдвартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэх боломжтой чухал үйл ажиллагаа юм.



ГАДААД ХАРИЛЦАА, ОЛОН УЛСЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Худалдаа Хөгжлийн Банк тайлант хугацаанд олон улсад нэр хүнд бүхий 41 банканд 77 ностро, 17 лоро данстай ажиллаа. Эдгээр дансаараа дамжуулан гадаад төлбөр тооцоог хамгийн олон буюу 16 төрлийн валютаар түргэн шуурхай, чанарын өндөр түвшинд гүйцэтгэсэн юм.



2023 онд Монгол Улсаас илгээсэн ам.долларын гүйлгээний тооны 45%, дүнгийн 35% орчмыг бид дангаар хийж гүйцэтгэсэн байна.

Монгол Улсаас илгээсэн ам.долларын гүйлгээний тоо



Монгол Улсаас илгээсэн ам.долларын гүйлгээний дүн



Монгол Улсын нийт импортын аккредитивын тооны 35%, гадаадад гаргасан баталгааны дүнгийн 58%, тооны 25% орчмыг Худалдаа, хөгжлийн банк гүйцэтгэлээ.

BNY MELLON

Монгол Улс 2019 онд ФАТФ-н саарал жагсаалтад орсноос хойш анх удаа АНУ-ын томоохон клиринг банканд ам.долларын ностро данстай боллоо. Бид The Bank of New York Mellon-д ностро данс нээж Монгол Улсын банк санхүүгийн салбарын түүхэнд шинэ хуудсыг эхлүүлэв.

MITSUI & CO., LTD.

Япон Улсын томоохон групп компаниудын нэг Mitsui & Co., Ltd.-тэй хамтран дотоодын катодын зэсийн үйлдвэрлэл болон экспортыг дэмжих, аж үйлдвэрийн олон улсын жишиг стандартыг Монгол Улсад нэвтрүүлэх, гадаад зах зээлд Монгол Улсыг таниулах, валютын нөөцийг нэмэгдүүлэх төслийг амжилттай санхүүжүүлсэн юм. Мөн хоёр улсын худалдааны хөгжил, стратегийн түншлэлийг дэмжих урт хугацааны хамтын ажиллагааны эхлэл тавигдлаа.

UniCredit

Итали Улсын Экспортын зээлийн агентлаг "SACE S.p.A"-ийн баталгаатайгаар 4 сая орчим еврогийн аккредитивыг нээж UniCredit S.p.A банкаар амжилттай баталгаажуулав. Ийнхүү Итали Улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хийж буй хамтын ажиллагааг нэг шат ахиулав.

BankABC

ICBC

COMMERZBANK

Crown Agents Bank

ODDO BHF ASSET MANAGEMENT

Их Британи Улсын Crown Agents Bank, Хятад Улсын ICBC, ABC банкнууд, Герман Улсын Commerzbank AG, ODDO BHF SE банкнууддээрх худалдааны санхүүжилтийн зээлийн шугамын хэмжээг тус бүр мэдэгдэхүйц дүнгээр нэмэгдүүллээ. Үр дүнд нь харилцагчдын худалдааны санхүүжилтийн хэрэгцээ шаардлагыг хангах боломж өргөжив.

KFW DEG

Герман Улсын Хөгжлийн Корпорац буюу "DEG"-тэй хамтран ажилласнаар худалдаа, үйлчилгээний салбарт хэрэгжиж буй томоохон төсөлд зориулж урт хугацаатай, хямд өртөгтэй санхүүжилтийг харилцагчид амжилттай олголоо.



Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк (IBEC)-тай хамтран зам тээврийн салбарт үйл ажиллагаа явуулдаг харилцагчийн Казахстан болон Эстони улсын нийлүүлэгчдээс худалдан авсан ачааны вагоны импортын төслийг нийт 12.4 сая еврогийн үнийн дүнгээр амжилттай санхүүжүүлээ. Мөн тус банктай хамтран зам тээвэр, гадаад худалдаа, аж үйлдвэр зэрэг төрөл бүрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг харилцагчдадаа нийт 30 гаруй сая юанийн санхүүжилт олголоо.



БНСУ-ын томоохон банк болох Shinhan банканд ам.доллар болон воннын ностро данс нээж корреспондент банкны сүлжээгээ өргөжүүлсэн юм. Ийнхүү харилцагчдад түргэн шуурхай, найдвартай гадаад төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх дэд бүтцийг төрөлжүүлэв.



Зүүн Өмнөд Азийн хамгийн том банк болох Сингапур Улсын DBS банканд ам.долларын ностро данс нээж харилцагчдын ам.долларын гүйлгээг саадгүй, найдвартай гүйцэтгэх сувгийг нэмэгдүүлэв.



Хятад Улсын төрийн өмчийн томоохон банкнуудтай хамтын ажиллагаа дахин эхлүүлж нийт 60 гаруй сая юанийн худалдааны санхүүжилтийг харилцагчдад олгов.

ТОКИО ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

Худалдаа, хөгжлийн банкны Токио дахь төлөөлөгчийн газар Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-гийн хэрэгжүүлж буй MICS for SDG's 2023 хөтөлбөрт нэгдэн, хамтран ажиллав. Тус хөтөлбөр нь Япон Монгол хоёр улсын төрийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, санал санаачилга, шийдлүүдээр Монгол улсын Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой юм.



Япон улсын эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам /METI/-н харьяа Японы гадаад худалдааг дэмжих агентлаг /JETRO/-тай хамтран Япон-Монгол хоёр улсын 40 гаруй хувийн хэвшлийн байгууллага оролцсон бизнес түншлэлийн уулзалтыг зохион байгууллаа. Ингэснээр банк өөрсдийн харилцагч байгууллагуудыг Японы төрийн байгууллагууд болон бизнесийн байгууллагуудтай холбож санал, мэдээлэл, туршлага солилцох боломжийг нээж байгаа юм.



Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу ЖАЙКА-тай хамтран Япон-Монгол хоёр улсын хувийн хэвшлийн 60 гаруй байгууллага оролцсон семинар болон бизнес түншлэлийн уулзалтуудыг зохион байгууллаа. ЖАЙКА Япон улсаас мэдээлэл технологи, боловсролын салбарт үйл ажиллагаа явуулдаг 20 орчим компанийн төлөөллийг Монгол Улсад урьсан юм. Банк тэдгээр байгууллагуудтай бизнесийн үйл ажиллагааны чиглэл нэгтэй өөрсдийн харилцагч байгууллагуудыг урьж оролцуулан бизнес хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх эхлэлийг тавилаа.



Үл хөдлөх хөрөнгө зуучлал, борлуулалт болон худалдааны чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг Япон улсын 12 компани банкны Токио дахь төлөөлөгчийн газартай хамтран ажиллаж, мэдээлэл зөвлөгөө аван Монгол улсад өөрсдийн салбар компанийг байгуулав.



ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Худалдаа, хөгжлийн банк Монгол Улсад анх удаа банкны харилцагчийн үйлчилгээг ОУ-ын түвшинд хүрэх боломжтойг баталгаажуулах Үйлчилгээний төгөлдөршлийн ISO 23592:2021 стандартын гэрчилгээг гардан авлаа. Уг стандартыг Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарттай нийцүүлэн хэрэгжүүлж эхэллээ.

2023 онд ISO 23592:2021 стандартыг баримтлан харилцагчаас ирүүлсэн гомдлыг дахин гаргахгүй байхад анхаарснаас гадна санал хүсэлт, гомдол шийдвэрлэлтийн хурдыг сайжруулах, салбарын үйлчилгээг зайнаас авах боломжийг нэмэгдүүлэх, банкны салбар болон дуудлагын төвөөр үйлчлүүлэх харилцагчийн хүлээлгийн хугацааг багасгахад анхаарлаа.



Харилцагчийн дуу хоолойг сонсож, цаг алдахгүй хүлээн авахад зориулан QR кодыг салбар бүрд байршууллаа. Үр дүнд нь асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэн, аливаа санал гомдлыг дахин давтагдахгүй байхад анхаарч, санал хүсэлт, гомдлыг ажлын 1.5-5 хоногт багтаан шийдвэрлэж байна.



2023 онд харилцагчдын ирүүлсэн 20,000 гаруй маргаантай гүйлгээний хүсэлт болон 6000 гаруй санал хүсэлт, гомдлыг шуурхай шийдвэрлэж ажиллаа. 9 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц хэмжээний санхүүгийн эрсдэлээс харилцагчаа хамгааллаа.



6000


харилцагчийн санал хүсэлтийг шийдвэрлэв.

9

тэрбум төгрөгтэй тэнцэхүйц хэмжээний санхүүгийн эрсдэлээс харилцагчдаа хамгааллаа

Банкны хэмжээнд нийт харилцагчийн цаасан хувийн хэргийн цахим санг үүсгэн төвлөрүүлсэн бөгөөд цаасаар хэвлэгддэг бүтээгдэхүүн, үйлчилгээний маягт, гэрээг шат дараатайгаар цахим хэлбэрт шилжүүлэн **БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, ЦААСГҮЙ, ЦАХИМ ШИЙДЛЭЭР** харилцагчид хүргэж эхэллээ.

Харилцагч төвтэй, Дижитал банк болох зорилгын хүрээнд харилцагчийг ХУР, ДАН, И-лавлагаа, тоон гарын үсэг зэрэг төрийн мэдээллийн сангийн цахим сувгаар дамжуулан танин, баталгаажуулж бүтээгдэхүүн, үйлчилгээг цаг алдалгүй хүргэхийг зорьж байна.



Банк, банкны ажилтнууд нь Харилцагчид үйлчлэх үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэхдээ Монголын банкны холбооноос танилцуулсан банкны салбарын хэмжээнд харилцагчийн эрхийг хамгаалах нэгдсэн стандарт бүхий "Харилцагчийн эрхийг хамгаалах банкны үйлчилгээний кодекс"-ыг үйл ажиллагаандаа нийцүүлэн мөрдөн ажиллаж байна.



Харилцагчийн эрхийг хамгаалах
банкны үйлчилгээний кодекс

ХАРИЛЦАГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Харилцагчийн сэтгэл ханамж болон үйлчилгээний чанарын түвшнийг тогтмол хэмжиж, үзүүлэлтийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна. Банкны салбар болон дуудлагын төвөөр үйлчлүүлсэн харилцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч ажиллаа.



+5%



94.2%

ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН УДИРДЛАГА

ВАЛЮТ АРИЛЖАА

Тайлант онд Монгол улсын төлбөрийн тэнцэл ашигтай гарч гадаад валютын албан нөөцийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөлсөн бөгөөд валютын нөөц оны эхэн үетэй харьцуулахад 44.8% орчим хувиар өссөн байна. Мөн, энэ онд нүүрсний экспорт эрчимжиж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн зэрэг нь валютын ханш тогтвортой байхад нөлөөллөө. Банк нь дотоодын валют арилжааны зах зээлд 25.4% орчим хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тайлант оны нийт хугацаанд харилцагчдынхаа гадаад болон дотоод төлбөр тооцоог тасалдуулахгүй, тогтвортой гүйцэтгэж, валютын эрэлт хэрэгцээг ханган ажиллаа.



ҮНЭТ МЕТАЛЫН АРИЛЖАА

"Алт-2" хөтөлбөрийн хүрээнд Монголбанк 2022 онд алт олборлогч компаниудын тушаасан алтыг олон улсын зах зээлийн ханшнаас 5 хувиар өндөр үнээр худалдан авч байсан. Энэ нь 2022 онд Монголбанканд тушаасан алтны хэмжээг өмнөх онтой харьцуулахад 10 хувиар буюу 22.9 тоннд хүргэхэд нөлөөлсөн. Харин 2023 онд Монголбанканд тушаасан алтны хэмжээ харьцангуй тогтвортой байсан бөгөөд нийт 17.8 тонн алт худалдан авсан байна.



17.8 ТОНН АЛТ МОНГОЛБАНКАНД
ТУШААГДСАН

Худалдаа Хөгжлийн Банк 2023 оны эцсийн байдлаар зах зээлд нийт тушаасан алтны 23% -г эзэлж, 2022 оны эцсээс 6% -р өссөн үзүүлэлттэй гарлаа.

Цаашид банк үнэт металлын баталгаажсан сорьцыг эрх бүхий байгууллагаас цахимаар хүлээн авах замаар харилцагчдын биет алтны арилжааны үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацаа, зардлыг хэмнэх шийдлийг эрэлхийлэн ажиллаж байна.



Дотоодын зах зээл дээр хөрвөх чадвартай үнэт цаасны **23** хувийг дангаар эзэлж байна.

МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2023 онд бид Монголбанкаас тогтоосон заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлагыг тасралтгүй хангаж ажиллахын зэрэгцээ дотоодын мөнгөний зах зээл дэх голлох байр сууриа бататгаж ажиллаа. Түүнчлэн, гадаад болон дотоодын банк санхүүгийн байгууллагуудад мөнгөний захын богино хугацаатай хадгаламж байршуулах, Засгийн Газрын гадаад үнэт цаасны арилжаанд оролцох замаар хөрвөх хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлж ажиллаа. Цаашид олон улсын болон дотоодын зах зээл дээрх хөрөнгө оруулалтуудын цар хүрээг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна.

АКТИВ, ПАССИВЫН УДИРДЛАГА

Нийлүүлэлтийн гаралтай инфляци улсын хэмжээнд Төвбанкны зорилтоос өндөр түвшинд байсантай холбоотойгоор бодлогын хүү 13 хувьд хадгалагдлаа. Инфляцийн өсөлтийн нөлөөгөөр банкны секторын эх үүсвэрийн өртөг нэмэгдэж, улмаар зээлийн хүү өсөх хандлагатай байна.

Банк нь 2023 онд инфляци, бодлогын хүүний хүлээлтэд үндэслэн хүүний эрсдэлийн удирдлагад түлхүү анхаарч цэвэр хүүгийн орлогыг зохистой түвшинд хадгалах чиглэлд өнгөрсөн 2 жилийн хугацаанд хүүгийн эрсдэлийг удирдах төлөвлөгөө боловсруулан ажиллаж, зохистой удирдлагыг хэрэгжүүллээ. Мөн дунд болон урт хугацааны хүүгийн эрсдэл, хэтийн төлвийн загварчлалыг сайжруулж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Түүнчлэн, Монгол улсын гадаад худалдааны нөхцөл байдал сайжирч, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт хүлээлтээс өндөр байсантай холбоотой эх үүсвэр, зээлийн зохистой байдалд анхаарч, хөрвөх чадварын удирдлагыг хэрэгжүүлж ажилласан.

КАСТОДИАН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант онд банк кастодианы бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэн харилцагчдынхаа эрэлт хэрэгцээг тасралтгүй хангасны үр дүнд Кастодианд хөрөнгөө хадгалуулж буй харилцагчдын тоо өмнөх оноос 61%-р, хадгалуулж буй хөрөнгийн хэмжээ 131%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Цаашид хөрөнгө оруулалтын сангууд, мэргэжлийн хөрөнгө оруулагчдад дотоодын болон олон улсын зах зээлд хөрөнгө оруулахад нь найдвартай гүүр болох, стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлж, сайжруулах чиглэлд анхаарч байна.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТЛОЦОО

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Аливаа санхүүгийн байгууллага нь үүсч болзошгүй бүх төрлийн эрсдэлийг урьдчилан илрүүлж, зөв тодорхойлж, материаллаг түвшний эрсдэлүүдийг бууруулах арга замыг оновчтой сонгох, цаашлаад эрсдэлийг боломж болгон ашиглах чадвартай байх нь урт хугацааны тогтвортой байдлын нэг үндэс байдаг.

Эрсдэлийн удирдлагын нэгжүүд нь тайлант онд Банкны зээл, зах зээл, хөрвөх чадвар, үйл ажиллагаа болон хүүгийн эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн түвшнийг үнэлэх, түүнийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хянах чиглэлээр олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын сайн туршлагыг нэвтрүүлж, Банкны үйл ажиллагааны тогтвортой байдлыг ханган ажиллахаас гадна ажилтнуудын эрсдэлийн тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрсдэлийн соёлыг банкны хэмжээнд түгээх чиглэлээр анхаарч ажиллаа.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP) болон Хөрвөх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-г нэвтрүүлээ

Банк нь Монголбанкнаас хэрэгжүүлж буй Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP) болон Хөрвөх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP) -ыг нэвтрүүлэх төслийн хүрээнд Банкны стратеги төлөвлөгөө, дунд хугацааны бизнес төлөвлөгөө, эрсдэлийн аппетит, чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөө, стресс тестийн үр дүн, эрсдэлийн бодлоготой уялдуулан Банкны богино (12 сар) болон дунд хугацааны (3 жил) тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор зээлийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, зах зээлийн эрсдэл, хүүгийн эрсдэл, төвлөрлийн эрсдэл зэрэг материаллаг гол эрсдэлүүдэд олон улсын аргачлалын дагуу өөрийн хөрөнгийг тооцож хуваарилах, Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон Банкны хөрвөх чадварын эрсдэл, санхүүжилтийн эрсдэлийг Базел III стандартын Багана II-ын дагуу цогцоор нь үнэлж ажиллаа.

Хэрэглээний болон жижиг, дунд бизнесийн зээлийг цахимаар шийдвэрлэх үндэс болсон скоринг моделийг нэвтрүүлээ

Банк нь тайлант онд машин сургалтын технологид суурилсан зээлдэгчийн скоринг моделийг Иргэдийн хэрэглээний зээлийн болон жижиг, дунд бизнесийн зээлийн үйл ажиллагаанд амжилттай нэвтрүүлснээр харилцагчийн зарим зээлийн хүсэлтийг цахимаар шууд шийдвэрлэдэг болсон. Мөн хэрэглээний зээлийн скоринг моделийн үр дүнд буцаан шалгалт хийж, скоринг моделийг сайжруулан ажилласнаар харилцагчийн үйлчилгээнд өндөр ач холбогдолтой ажил боллоо.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Тайланд онд зээлийн эрсдэлийн заавар, журмуудыг шинэчилж, зээлийн багцын эрсдэлийг удирдах, зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор Байгууллагын зээлийн бодлого, Уул уурхайн салбар, Мал, малын гаралтай түүхий эд материал бэлтгэн нийлүүлэх, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон Барилгын салбарт баримтлах санхүүжилтийн бодлогыг шинэчлэн боловсруулж ажиллаа.

Банк нь зээлийн багцын төвлөрөл, эдийн засгийн салбарын төвлөрөл, чанаргүй зээлийн түвшин, зээлдэгчдийн зээл эргүүлэн төлөх чадвар, барьцаа хөрөнгийн хангалт зэрэг үзүүлэлтүүдэд эрсдэлийн хязгаарлалт тогтоох замаар зээлийн эрсдэлийг бууруулж, хяналт тавин ажилладаг.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Зах зээлийн эрсдэлд гадаад валют, алт болон таваарын үнийн эрсдэл, хувьцааны үнэ, зах зээл дэх хүүгийн хэлбэлзэл зэргээс хамааран хүүд мэдрэмжтэй арилжааны санхүүгийн хэрэгслээс үүдэн банкны эзэмшиж буй хөрөнгөөс алдагдал хүлээх эрсдэлийг авч үздэг. Банк нь энэхүү эрсдэлээс үүдэн учирч болзошгүй алдагдлыг хэмжих, хянах, бууруулах замаар үр ашигтай удирдахыг зорьдог. Тайлант онд дараах 3 аргаар эрсдэлийг удирдаж, зах зээлийн эрсдэлийг удирдах зааврыг шинэчлэн боловсруулж ажиллаа. Үүнд:

- Монголбанкнаас тогтоосон гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг нэгж валют болон нийт валютаар өдөр бүр тооцож тайлагналаа.
- Базель III стандартын дагуу мэдрэмжид суурилсан аргачлалаар (MRCC) учирч болзошгүй алдагдлыг хаахад хүрэлцэхүйц өөрийн хөрөнгийн хэмжээг тодорхойлж ажиллаа.
- Нийт нээлттэй позицоос дараагийн ажлын өдөрт алдаж болох алдагдлын хэмжээг хамгийн их эрсдэлийн аргаар (VaR) тодорхойлж ажиллаа.

ХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банк нь хүүгийн эрсдэлийг удирдахдаа хүүгийн эрсдэлийг зохистой түвшинд барих, зах зээлийн хүүгийн өөрчлөлтөөс хамааран Банкны бүтээгдэхүүний хүүг оновчтой тогтоох, зах зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтөөс үүдэн учирч болох хүүгийн эрсдэлийн түвшин, алдагдлын хэмжээг урьдчилан тодорхойлох, хүндрэлийг шийдэх замаар эрсдэлийг удирддаг. Тайлант онд хүүгийн эрсдэлийг удирдах олон улсын жишиг хүүгийн эрсдэлийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх дохиог нэвтрүүлж, Базел III стандартад нийцүүлэн сценарь таамаглалуудыг сайжруулж, өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийн мэдрэмтгий байдал буюу ΔEVE, цэвэр хүүгийн орлогын өөрчлөлт (NII) буюу хүүгийн өөрчлөлтөөс үүдэн банканд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох аргачлалыг сайжруулан, хүүгийн эрсдэлийг удирдах зааврыг шинэчлэн боловсруулж ажиллаа.

ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Тайланд онд Банк нь Монголбанкны хөрвөх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангалттай нөөцтэйгөөр биелүүлэн ажиллаж, хөрвөх чадварын эрсдэлийг үнэлэх олон улсын жишиг үзүүлэлтүүд болох богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (LCR), тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR), Time to Wall, зээл хадгаламжийн харьцаа (LDR) зэрэг үзүүлэлтүүдэд хязгаарлалт тогтоон, шинжилгээ хийлээ. Мөн Монголбанкны ILAAP журмын төслийн хүрээнд дагуу Банк харилцагчийн анхны шаардлагаар гэрээний дагуу хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлэх, хөрвөх хөрөнгийн хангалттай нөөцийг ямагт хадгалах, Банкны тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор богино болон дунд хугацааны Банкны хөрвөх чадварын эрсдэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг Банкны үйл ажиллагаа, бизнес орчин, стратеги төлөвлөгөө, эрсдэлийн аппетиттай уялдуулан Базелын стандартын Багана II-ын дагуу цогцоор нь үнэлж ажиллаа.

ХАРИЛЦАГЧ ТАЛ, УЛС ОРНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Тайлант онд харилцагч талын эрсдэлийн хувьд Moody's банк үнэлгээний шинэчлэгдсэн загварт үндэслэн харилцагч талын эрсдэлийг үнэлэх, зээлжих зэрэглэлийг тогтоох арга, аргачлалыг сайжруулж, Базел III стандартад нийцүүлэн харилцагч талын эрсдэлийн бодлогыг шинэчлэн боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллаа.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банк нь бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээ, шинээр нэвтрүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ болон төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх ажиллагаандаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын аргачлалын дагуу эрсдэлийг хүлээн зөвшөөрөх түвшинд удирдахад анхаарч ажиллаа.

“Эрсдэл ба хяналтын өөрийн үнэлгээ (Risk Control Self Assessment)”-ний аргачлалаар хагас жилд нэг удаа ажилтан бүр эрсдэлээ тодорхойлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллаа. Мөн үйл ажиллагааны эрсдэлийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, хяналтын самбар (Dashboard)-аар хянаж ажлыг амжилттай гүйцэтгэлээ. Түүнчлэн үйл ажиллагааны эрсдэлээс хүлээж болзошгүй алдагдлын лимитийг тогтоон, эрсдэлийн аппетитийг тогтмол хянаж ажиллав.



ЦАХИМ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ дижитал хэлбэрт хурдацтайгаар шилжиж байгаатай холбоотойгоор банк болон харилцагчаа аливаа эрсдэлд өртөхөөс сэргийлэх зорилгоор цахим эрсдэлийг үр дүнтэйгээр удирдах олон улсын арга аргачлал, сайн туршлагуудыг банкныхаа үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаа.

Төлбөрийн картын аюулгүй байдлын PCI DSS (Payment Card Industry Data Security Standard) олон улсын стандартыг 7 дахь жилдээ бүрэн хангаснаар зөвхөн төлбөрийн картаар хязгаарлахгүйгээр бодлого журам, систем, программ хангамж, сүлжээ, карт хэвлэлт, хүргэлт, мерчантын үйлчилгээ зэрэг байгууллагын бүхий л түвшинд мэдээллийн аюулгүй байдал, дотоод хяналтыг олон улсын жишигт нийцүүлснийг дахин баталгаажуулсан үйл явдал боллоо.



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

2023 онд банк нь Дижитал банкны төслүүд, Суурь бүртгэлийн системийн шинэчлэл болон Мэдээллийн технологийн хамааралтай үйл ажиллагаа, дэд бүтцийн засвар үйлчилгээнд анхаарч ажиллаа.

Түүнчлэн банкны гүйлгээний хэмжээ тайлант онд өмнөх онтой харьцуулахад 19% өссөн. Дижитал банкны системээр дамжуулсан гүйлгээний хувь 30% өссөн үзүүлэлттэй байна.

Харилцагчийн сэтгэл ханамж болон иргэдийн сегментийг дэмжих ажлын хүрээнд харилцагчийн цагийг хэмнэсэн, өдөр тутмын үйл ажиллагааг хялбаршуулан автоматжуулсан хэд хэдэн технологийн шийдлийг нэвтрүүллээ.

Дижитал банкны шийдлийн хүрээнд зээлийн шийдвэр гаргалт, олголтыг бүрэн автоматжуулсан ба мөн технологийн компаниудтай хамтран нээлттэй банкны шийдлийг нэвтрүүллээ.



ШИНЭ ШИЙДЭЛ БОЛОН АВТОМАТЖУУЛАЛТ



ШИЙДЛИЙГ НЭВТРҮҮЛЭВ

Андройд гар утастай мерчантууд ашиглах боломж бүхий СОФТ ПОС буюу шинэ төрлийн ПОС төхөөрөмжийг төлбөрийн картын зах зээлд нэвтрүүлсэн. Уг шийдэл нь уламжлалт болон зайнаас унших төлбөрийн картыг аль алиныг нь дэмждэг, хэрэглэхэд хялбар, зардлыг бууруулах боломжийг харилцагчид олгож байгаа.



КОМПЛАЙНСЫН ШИНЭ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭВ

Банкны комплайнсын үйл ажиллагаатай холбоотой аливаа зөрчлөөс сэргийлэх комплайнсын шинэ системийг нэвтрүүлж, гадаад төлбөр тооцоо гүйцэтгэдэг харилцагчдын эрсдэлийг буурууллаа.



ХУР 1.5 СИСТЕМИЙН ИНТЕГРАЦИЙГ ХИЙВ

ХУР төрийн мэдээлэл солилцооны системтэй интеграци хийснээр банкны үйл ажиллагаанд автоматжуулалтын шийдлийг нэвтрүүлэх боломж бүрдсэн. Одоогийн байдлаар уг үйлчилгээнд суурилан харилцагчид хүрсэн 13 үйлчилгээг нэвтрүүлээд байна.



ПОС ТЕРМИНАЛД QR ТӨЛБӨРИЙН ШИЙДЛИЙГ НЭВТРҮҮЛЭВ

Женесис систем ХХК-тай хамтран ПОС терминалд QR төлбөрийн шийдлийг нэвтрүүлээ.



АГЕНТ БАНКНЫ ШИЙДЛИЙГ НЭВТРҮҮЛЭВ

Агент байгууллагаар дамжуулан харилцагчийн хүсэлтийг хүлээн авч, бүртгэх боломж бүхий Агент банкны системийг нэвтрүүлээ. Ийнхүү орон нутгийн иргэдэд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэх боломжийг бүрдүүлээ.



ТӨЛБӨРИЙН КАРТЫН СИСТЕМ



PAYMENT CARD INDUSTRY DATA SECURITY STANDARD

Олон улсын төлбөрийн картан системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах стандарт болон PCI-DSS (Payment Card Industry Data Security Standard)-г 7 дахь жилдээ баталгаажуулав.



VISA 3D SECURE 2.1 ХУВИЛБАР

E-Commerce буюу картан онлайн төлбөрийн системд VISA 3D Secure стандартын 2.1 хувилбарыг нэвтрүүлэв.

THALES

ТӨЛБӨРИЙН КАРТЫН СИСТЕМИЙН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Төлбөрийн картан гүйлгээний системийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж, сайжруулах зорилтын хүрээнд Thales 10K загварын нууцлал, аюулгүй байдлын төхөөрөмжөөр шинэчлэв.



ТӨЛБӨРИЙН КАРТЫН ЧИП ТЕХНОЛОГИ

Олон улсын стандартад нийцүүлэн банкны төлбөрийн картыг UBJ31 G33 чип технологи руу шилжүүлэв.



VISA болон MasterCard-тай хамтран жил бүр 2 удаа хийгддэг төлбөрийн картан системийн шинэчлэлт, сайжруулалтыг гүйцэтгэв.



Pulse Network-той хамтран сертификатыг гүйцэтгэв.



Олон улсын Diners club байгууллагатай хамтран сертификатыг гүйцэтгэв.



JCB буюу Japan Credit Bureau-той хамтран шинэ сеттлмент системийг нэвтрүүлэв.



ДИЖИТАЛ БАНКНЫ СИСТЕМ

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

"Бүрэн Скор ЗМС" ХХК хамтран Зээлийн мэдээллийн сангийн лавлагааны үйл ажиллагааг сайжруулсан. Ингэснээр зээлийн олон төрлийн үйлчилгээг харилцагчид түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдлээ.

ЦАЛИНГИЙН ЗЭЭЛ

Цалингийн зээлийн шийдвэр гаргалт, олголтыг бүрэн автоматжууллаа. Дижитал банкны системээр дамжуулан банкны харилцагчид төдийгүй бусад банкны харилцагчид цалингийн зээлийн хүсэлт гаргах, авах боломжтой болсон.

ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛ

Банк ахмад харилцагч нартаа зориулан Дижитал банкны системээр дамжуулан тэтгэврийн орлого дээрээ үндэслэн зээл авах боломжийг бүрдүүллээ.

ПОС ТЕРМИНАЛ

ПОС терминалтай, тогтмол орлоготой ЖДҮ сегментийн мерчант харилцагчид Дижитал банкны системээр дамжуулан ПОС терминалын орлогод үндэслэн зээл авах боломжийг бүрдүүлэв.

БИЗНЕСИЙН ЗЭЭЛ

ЖДҮ-ийн сегментийн харилцагчдад зориулан зээлжих чадварын үнэлгээг нэвтрүүллээ. Ийнхүү уг төрлийн харилцагчид дижитал банкны системээр дамжуулан зээлийн лимит шалгах боломж бүрдсэн.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан санхүүгийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Аудитлагдсан санхүүгийн тайлан

Агуулга	Хуудас
Банкны талаарх мэдээлэл	1
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл	2
Хараат бус аудиторын тайлан	3 – 6
Товчилсон үгийн тайлбар	7
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	8
Санхүүгийн байдлын тайлан	9
Өмчийн өөрчлөлтийн тайлан	10
Мөнгөн гүйлгээний тайлан	11 – 13
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	14 – 89

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Ерөнхий мэдээлэл

ТУЗ-ийн гишүүд:

Р. Коппа (ТУЗ-ийн дарга)
Д. Эрдэнэбилэг
Д. Янжмаа
Д. Хүрэлбаатар
Д. Отгонбилэг
А. Энхмэнд
Ж. Болормаа
Ж. Дэлгэрсайхан
З. Нарантуяа

Нарийн бичгийн дарга:

Н. Нямсүрэн

Албан хаяг:

Энхтайвны өргөн чөлөө 19,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар хот 14210,
Монгол улс

Аудиторууд:

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Худалдаа Хөгжлийн Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид Худалдаа Хөгжлийн Банк ХК (“Банк”)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр дурдсан санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөл (ОУНББСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (“СТОУС”)-ын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдолтой байсан гэж аудиторын мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид уг асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно. Аудитын гол асуудлыг бид хэрхэн авч үзсэн талаарх тайлбарыг дор өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагууд болон эдгээр асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагыг бид бүрэн биелүүлсэн. Үүний дагуу бид санхүүгийн тайлангуудын материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээнд тохирсон аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Дор дурдсан асуудлыг анхаарч үзэхдээ гүйцэтгэсэн горимуудыг багтаасан аудитын горимуудын үр дүн нь энд хавсаргасан санхүүгийн тайлангуудад өгсөн бидний аудитын дүгнэлтийн үндэслэл болно.

Аудитын гол асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
<p>Зээлийн үнэ цэнийн бууралт</p> <p>Удирдлага нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг тооцохдоо үнэлэмж болон өндөр түвшний төсөөлөл ашигладаг.</p> <p>Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны нийт хөрөнгийн 39 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд холбогдох тооцооллуудын тодорхойгүй байдлаас үүдэн харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг бид аудитын гол асуудал гэж үзсэн.</p> <p>Үнэ цэнийн бууралтын аргачлал нь ирээдүйг таамагласан Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (“ЗҮЦХА”)-ын загварт суурилсан. Энэхүү ЗҮЦХА-ын загварын бүрэлдэхүүн хэсгүүд нь ихээхэн төсөөлөл, болон тооцоолол шаарддаг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн хөрөнгийн шатлал; 	<p>2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлын санг тооцоолох аргачлалыг үнэлэхдээ бид Банкны ЗҮЦХ-ыг батлах, бүртгэх, хянах хяналтын загвар болон үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэх, мөн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг тооцоолох ЗҮЦХА-ын загварт Банкны ашигласан арга зүй, өгөгдөл, төсөөллүүдийг үнэлэх зэрэг аудитын горимуудыг гүйцэтгэсэн.</p> <p>Арга зүйг үнэлэхдээ бид банкны ЗҮЦХА-ын загвар болон удирдлагын ашигласан арга зүй, таамаглалын үндэслэлийн талаарх ойлголтыг авч, загварын үндэслэлтэй байдлыг үнэлж, салбарын жишигтэй харьцуулсан. Түүнчлэн бид ашигласан таамаглалуудын үндэслэлтэй байдал, шатлалын ангиллын үндэслэл, ЧМ, АХЧ болон ЧӨД-г тодорхойлох оновчтой байдал, загварт тусгагдсан макро эдийн засгийн хэтийн хувьсагчдыг авч үзсэн.</p>

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Худалдаа Хөгжлийн Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)

Аудитын гол асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
<p>Зээлийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)</p> <ul style="list-style-type: none"> ЗҮЦХА-ын загвар боловсруулах, загварын гол өгөгдлүүд болох Чанаргүйдлийн Магадал (“ЧМ”) болон Алдагдал хүргэх чанаргүйдэл (“АХЧ”)-ийг сонгох; Чанаргүйдэлд Өртөх Дүн (“ЧӨД”) болон ашиглагдаагүй зээлийн үүргийн хөрвүүлэлтийн коэффициентийг тодорхойлох; ЗҮЦХА-ын загварт оруулах эдийн засгийн өгөгдлүүдийг тодорхойлохын тулд ирээдүйн макро эдийн засгийн хувилбаруудыг сонгох, мөн тэдгээрийг магадлалаар нь жинлэх; болон Ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тооцоход хэрэглэсэн олон төрлийн төсөөлөл болон хүчин зүйлс дээр суурилан тусгайлан үнэлсэн зээлүүдийн үнэ цэнийн бууралтын санг тооцоолох. <p>Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого болон нягтлан бодох бүртгэлийн гол тооцоолууд, үнэлэмжүүдийг санхүүгийн тайлангийн Тодруулга 2.5-д толилуулсан.</p> <p>Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаатай хамааралтай бусад толилуулга болон зээлийн эрсдэлийн удирдлагыг санхүүгийн тайлангийн Тодруулга 2, 8, 17 болон 32.2-д тус тус толилуулсан.</p>	<p>Шатлалын ангилал зохистой эсэхийг шалгахдаа бид зээлийн хугацаа хэтрэлтийн мэдээлэл, харилцагчдад оноосон зээлжих зэрэглэлийг анхны хүлээн зөвшөөрсөн өдрөөр болон санхүүгийн тайлангийн өдрөөр тус тус шалгасан.</p> <p>Бид мөн насжилтын тайлангийн дүнг санхүүгийн бүртгэлд тусгасан дүнтэй тулгах замаар насжилтын тайлангийн иж бүрэн байдлыг шалгаж, санамсаргүй түүврийн аргаар насжилтын тайлангийн мэдээллүүдийг холбогдох баримтуудтай тулгах замаар насжилтын тайлангийн үнэн зөв байдлыг шалгасан.</p> <p>Бид ХБЗА-ын загварт ашигласан гол өгөгдлүүдийг Банкны боломжит дотоод эх үүсвэрээс олж авсан түүхэн мэдээлэл, гадаад эх үүсвэрээс олж авсан тухайн салбарын болон санхүү, эдийн засгийн мэдээллүүдтэй харьцуулсан. Бидний хяналтын горимд дараах ажлууд багтсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Түүхэн ЧМ, АХЧ-ийг тодорхойлох тооцоололд ашигласан дотоод болон гадаад эх сурвалжийн мэдээллүүдийн зөв зохистой байдлыг санамсаргүй түүврийн аргаар шалгасан; Макро эдийн засгийн хэмжүүрүүдийг боломжит гадаад эх сурвалжийн мэдээллүүдтэй тулгасан; ЧӨД болон зээлийн хөрвүүлэлтийн коэффициентүүдийн хүлээлтийн үнэн зөв байдлыг шалгасан; Үнэ цэнийн бууралтыг үнэлэх тусгайлан үнэлсэн зээлүүдээс сонгогдсон түүврүүдийн хувьд бид ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгал болон барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийн талаарх Банкны таамаглалуудыг хянаж үзсэн. <p>Бид ЗҮЦХА-ын загварын гол өгөгдлүүдэд ашигласан үнэлэмжийг тууштай ашигласан байдлыг авч үзсэн.</p> <p>Мөн бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлсэн</p>

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл

Захирлууд болон Гүйцэтгэх удирдлагууд бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт аудитын тайлан гарсан өдрөөс хойш гарахаар хүлээгдэж буй жилийн тайланд тусгагдах санхүүгийн тайлангууд болон тэдгээрт хамаарах аудиторын тайлангаас бусад мэдээлэл (“Бусад хэсэг”) багтана.

Санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангуудын аудиттай холбоотой бидний хүлээх хариуцлага нь бусад мэдээллийг уншиж, тэдгээр нь санхүүгийн тайлангууд эсвэл аудитын явцад бидний олж авсан мэдээллээс материаллаг байдлаар зөрүүтэй эсвэл алдаатай эсэхийг харгалзаж үзэх явдал юм.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Худалдаа Хөгжлийн Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл (үргэлжлэл)

Жилийн тайлангийн “Бусад хэсэг”-ийг унших үед тэнд материаллаг буруу илэрхийлэл байна гэж дүгнэвэл уг асуудлын талаар бид засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдэх шаардлагатай байдаг.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, бодитойгоор илэрхийлэх ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг
- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь бодитой илэрхийлэгдэх шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Худалдаа Хөгжлийн Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Мөн бид өөрсдийн хараат бус байдлыг хөндсөн ёс зүйн шаардлагуудыг хангасан тухай мэдэгдлийг засаглал хариуцсан этгээдүүдэд хүргэж, бидний хараат бус байдалд зохистойгоор хамааралтай гэж үзэж болох бүхий л харилцаа болон бусад асуудлуудын талаар болон хэрвээ шаардлагатай тохиолдолд аливаа эрсдэлийг арилгахаар авсан арга хэмжээг мэдэгддэг.

Засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдсэн асуудлаас бид тухайн тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудлуудыг аудитын онцгойлсон асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж нь уг асуудлуудын талаар олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлуудын талаар мэдээллэх нь олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлуудыг бид аудиторын тайландаа толилуулдаг

Бусад

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан



Доржбатын Мандахбаяр
Партнер

Монгол улс, Улаанбаатар хот
Огноо: 2024 оны 3-р сарын 29

Баталсан



Адриан Чу
Партнер

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АТМ	Автомат тооцооны машин
АПУХ	Актив пассивын удирдлагын хороо
АХЧ	Алдагдал хүргэх чанаргүйдэл
БҮЦӨАА	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх
БҮЦӨБДО	Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх
БЗҮХХ	Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖДБ	Жижиг, дунд байгууллага
ЗҮЦХА	Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал
ЗБҮЦ	Зээлээр баталгаажсан үнэт цаас
ИЗББ	Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас
LIBOR	Лондонгийн банк хоорондын хүү
МИК	Монголын Ипотекийн Корпораци
МХБ	Монголын хөрөнгийн бирж
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НББОУСЗ	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
SOFR	Баталгаажсан овернайт санхүүжилтийн хүү
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТУЗЭУХ	ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо
УИХ	Монгол Улсын Их Хурал
ҮТХТ	Үндсэн төлбөр ба хүүний төлбөр
ҮЦСК	Үнэт цаасны санхүүжилтийн корпораци
ҮАХ	Үр ашигт хүү
ХОЗҮХХ	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
ХАҮҮЦБ	Худалдаж авсан болон үүссэн үнэ цэнийн бууралт
ЧМ	Чанаргүйдлийн магадлал
ЧӨД	Чанаргүйдэлд өртөх дүн
ЭУХ	Эрсдэлийн удирдлагын хороо
VaR	Эрсдэлийн үнэ цэн

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тодруулга	2023 мян.төг	2022 мян.төг
Үр ашигт хүүгээр тооцсон хүүний орлого	4	721,933,116	642,747,024
Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого	4	42,779,283	31,331,028
Хүү болон түүнтэй адилтгах зардал	5	(469,048,440)	(354,478,116)
Хүүний цэвэр орлого		295,663,959	319,599,936
Шимтгэл, хураамжийн орлого	6	94,518,640	77,961,275
Шимтгэл, хураамжийн зардал	6	(33,159,051)	(27,512,673)
Шимтгэл, хураамжийн цэвэр орлого		61,359,589	50,448,602
Арилжааны болон үйл ажиллагааны бусад орлого	7	54,690,488	13,924,925
Нийт үйл ажиллагааны орлого		411,714,036	383,973,463
Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт/(зардал)	8	(35,419,047)	28,297,839
Үйл ажиллагааны цэвэр орлого		376,294,989	412,271,302
Үйл ажиллагааны зардал	9	(183,760,346)	(172,790,891)
Хараат компанийн ашигийн хувь	15	4,271,538	418,388
Татварын өмнөх ашиг		196,806,181	239,898,799
Орлогын албан татварын зардал	10.1	(45,587,714)	(45,650,106)
Тайлант жилийн ашиг		151,218,467	194,248,693
Нэгж хувьцааны ашиг (Төгрөг):			
Нэгж хувьцаанд ноогдох суурь болон хорогдуулсан ашиг	11	3,043	4,041
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал) (татварын дараах)			
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):</i>			
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт	29	17,862,582	(16,130,824)
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):</i>			
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт	29	14,547,040	14,779,163
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүр борлуулсны олз	14	25,620,309	—
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал) (татварын дараах):		58,029,931	(1,351,661)
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого		209,248,398	192,897,032

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй нэг хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

Холбоотой талууд гэдэгт Банктай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

Банктай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

- Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- Банканд томоохон нөлөөлөлтэй эсвэл
- Банкны эсвэл Банкны толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.

Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Банканд хамааралтай болно. Үүнд:

- Аж ахуйн нэгж болон Банк нь нэг ижил группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуйн нэгж нь гишүүн болох Банкны хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
- Аль аль аж ахуйн нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Холбоотой талын ажил гүйлгээ (үргэлжлэл)

- Аж ахуйн нэгж нь Банкны эсвэл Банктай холбоотой аж ахуйн нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Банк нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Банктай холбоотой тал болно.
- Аж ахуйн нэгжийг Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
- Банканд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон хувь хүн нь аж ахуйн нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуйн нэгжийн (эсвэл аж ахуйн нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- Аж ахуйн нэгж нь эсвэл Банкны аль нэг гишүүн нь Банк эсвэл Банкны толгой компанид гол удирдах албан тушаалтай.

Холбоотой талуудтай хийсэн материаллаг бүх гүйлгээ болон дансдын үлдэгдлийн мэдээллүүдийг санхүүгийн тайланд хавсаргасан бөгөөд Тодруулга 34-д задаргааг толилуулсан.

3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ажил нь санхүүгийн тайлангийн өдрийн байдлаар орлого, зардал, хөрөнгө ба өр төлбөр дээр үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөлөл хийх ба тэдгээрийн дагалдах тодруулгууд болон болзошгүй өр төлбөр тодруулга зэргийг хамардаг ба эдгээр нь зарим тохиолдолд удирдлагаас гаргасан үнэлэмж, тооцоолол болон төсөөлөл дээр үндэслэдэг. Эдгээр төсөөлөл болон тооцооллын үр дүн нь ирээдүйн тайлант жилүүдэд хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэд материаллаг залруулгууд хийх шаардлага буюу тодорхойгүй байдал үүсгэж болдог. Банк нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцдаа дараагийн тайлант жилүүд дэх хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэд материаллаг залруулга үүсгэж болзошгүй тодорхой эрсдэл бүхий дараах гол тооцооллууд болон ирээдүйн төсөөлөл, үнэлэмжүүдийг ашигласан.

Банк хянах боломжгүй бусад хүчин зүйлүүд ирээдүйд үүссэнээс шалтгаалан банкны одоогийн тодорхойлсон байгаа ирээдүйн төсөөлөл болон нөхцөл байдлыг өөрчлөхөд хүргэж болзошгүй. Санхүүгийн байдлын тайланд орсон мэдэгдэхүйц нөлөөтэй зүйлсийг тэдгээрт ашигласан удирдлагын үнэлэмж ба/эсвэл тооцооллууд нь хоорондоо хэрхэн нийцэж байгааг доор тусгав.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Бүх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцоход Банкны удирдлагын үнэлэмж шаардагддаг. Ялангуяа ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон хугацаа, барьцаа хөрөнгийн үнэлгээг тодорхойлох шаардлагатай байдаг. Эдгээр тооцоолол нь хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгдөх бөгөөд эдгээрийн өөрчлөлт нь өөр өөр түвшний үнэ цэнийн бууралтын сан байгуулахад хүргэдэг.

Банкны зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын (ЗҮЦХА) тооцоолол нь хувьсах өгөгдөл болон тэдгээрийн харилцан хамаарлыг сонгоход ашигласан олон төсөөллүүдээс бүрдсэн цогц загварын үр дүн юм. ЗҮЦХА загварын элементүүд нь доорх нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж болон тооцооллыг шингээсэн байна:

- Тус тусын үнэлгээ бүрт ашиглах чанаргүйдлийн магадлалыг (ЧМ) тодорхойлдог Банкны зээлийн дотоод үнэлгээний загвар
- Банкны санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр ихэссэн байна гэж үнэлэх шалгуур үзүүлэлтүүд болон санхүүгийн хөрөнгүүдийн нөөц санг нийт хугацааны ЗҮЦХА болон чанарын үнэлгээ ашиглан тооцно
- ЗҮЦХА нь бүлгийн үнэлгээгээр тооцоологддог бол санхүүгийн хөрөнгийн сегментчилэл
- Өгөгдлүүдийн сонголт болон томъёонуудыг ашиглан ЗҮЦХА загварын хөгжүүлэлт
- Макро эдийн засгийн өгөгдлүүдийн харилцан холбоо хамаарлыг тодорхойлох болон эдгээрийн чанаргүйдлийн магадлал (ЧМ), чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД), алдагдалд хүргэх чанаргүйдэлд (АХЧ) үзүүлэх нөлөө зэрэг
- ЗҮЦХА загварт ирээдүйг чиглэсэн макро эдийн засгийн хувилбаруудаас сонгох, тэдгээрийн жигнэсэн дундаж магадлалыг тодорхойлох, эдийн засгийн өгөгдлүүдийг гаргах

Банк нь бодит алдагдал хүлээсэн дүн дээрээ үндэслэн өөрийн загварыг жил бүр үнэлэж, шаардлагатай бол залруулж байх журамтай.

3. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд (үргэлжлэл)**Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн**

Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжилтийн өдрөөрх идэвхтэй зах зээл дээрх үнээр хэмжиж чадахгүй бол бодит үнэ цэнийг дискаунтлагдсан мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн үнэлгээний аргыг ашиглан хэмжиж болно. Энэхүү үнэлгээний загварт ашигласан орцуудыг ажиглаж болохуйц идэвхтэй зах зээлийн мэдээллээс олж авсан ба тэдгээр нь нийцтэй биш тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тодорхой түвшний үнэлэмжийг авч ашигласан. Ашигласан төсөөллүүдийн өөрчлөлтүүд нь тайлагнасан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнд нөлөөлж болно. Дэлгэрэнгүй толилуулгыг Тодруулга 33-өөс харна уу.

Хөрөнгийн дахин үнэлгээ

Банк хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг (ХОЗҮХХ) бодит үнэ цэнээр бүртгэж бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг. Түүнээс гадна, Банк газар болон барилга байгууламжийг дахин үнэлэгдсэн дүнгээр хэмждэг бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрдөг. ХОЗҮХХ, газар болон барилга байгууламжийн бодит үнэ цэн нь итгэмжлэгдсэн хараат бус үнэлгээний хийсэн үнэлгээнд үндэслэдэг. Хөрөнгүүдийг шаардлагатай тохируулга (хөрөнгийн шинж чанар, байршил, барилгын элэгдэл гэх зэрэг хүчин зүйлсийг харгалзан) хийсэн ижил төстэй барилгын үнэ болон орлогын хандлагын аргыг ашиглан зах зээлийн мэдээлэлд суурилан үнэлсэн. 2023 оны 12 сарын 31-ний байдлаарх ХОЗҮХХ, 2021 оны 12 сарын 31-ний байдлаарх газар, барилга байгууламжийн бодит үнэ цэн нь хараат бус мэргэшсэн үнэлгээчдийн үнэлгээн дээр үндэслэсэн байна.

Энэхүү үнэлгээ нь Тодруулга 33-д дурдсаны дагуу удирдлага болон үнэлгээчний хөрөнгийн үнэлэмжийг шаарддаг.

20%-с доош саналын эрх эзэмшдэг аж ахуйн нэгжид Банкны мэдэгдэхүйц нөлөөллийг тодорхойлох нь

Банк нь хэдийгээр Монголын Ипотекийн Корпораци "МИК"-ийн саналын эрхийн 20%-с доош хувийг эзэмшдэг ч МИК-д мэдэгдэхүйц нөлөөтэй гэж үзэж байна. Учир нь Банк нь МИК-ийн 10%-г эзэмшдэг (бодитоор 13.58%) томоохон хувьцаа эзэмшигчдийн нэг бөгөөд бусад хувьцаа эзэмшигчид 10%-с доош хувийг эзэмшдэг. Үүнээс гадна, Банкны холбоотой этгээдүүд ойролцоогоор МИК-ийн 35.6% (бодитоор 35.6%)-ийг эзэмшиж байгаа нь Банкны саналын эрх нь холбоотой этгээдүүдийн хамтаар бусад хувьцаа эзэмшигчдийн саналын эрхээс их байгаа юм. Түүнчлэн, Банк нь жил бүр тогтмол МИК-тэй томоохон ажил гүйлгээнүүдийг хийдэг. Хэдийгээр эдгээр гүйлгээнүүд нь бизнесийн ердийн үйл ажиллагааны хүрээнд хийгддэг боловч хэмжээ болон үнийн дүнгийн хувьд материаллаг юм.

4. Хүү болон түүнтэй адилтгах орлого

	2023	2022
	мян.төг	мян.төг
<i>Үр ашигт хүүний аргаар тооцсон хүүний орлого</i>		
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	502,863,241	475,595,163
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэглүүр	122,654,748	79,036,606
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр	19,219,201	65,525,281
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	37,570,628	13,062,605
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	39,322,246	8,711,102
Урвуу репо хэлцэл	303,052	816,267
	721,933,116	642,747,024
<i>Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого</i>		
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө	31,745,201	19,544,616
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	11,034,082	11,786,412
	42,779,283	31,331,028

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

5. Хүү болон түүнтэй адилтгах зардал

	2023	2022
	мян.төг	мян.төг
Харилцагчдын харилцах, хадгаламж	375,598,199	227,586,554
Зээлээр авсан санхүүжилт	78,350,667	93,256,863
Репо хэлцэл	10,962,353	19,796,976
Гаргасан өрийн бичиг	–	6,326,356
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	2,086,910	6,521,237
Түрээсийн өглөг (Тодруулга 22)	2,050,311	990,130
	469,048,440	354,478,116

6. Шимтгэл, хураамжийн цэвэр орлого

	2023	2022
	мян.төг	мян.төг
<i>Санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн даруй хүлээн зөвшөөрсөн хураамж, шимтгэлийн орлого:</i>		
Картын үйлчилгээ	39,441,990	34,325,781
Гуйвуулгын үйлчилгээ	18,975,795	16,846,301
Зээлийн үйлчилгээ	9,789,095	4,831,542
Гар утас болон цахим банкны үйлчилгээ	7,581,552	6,356,065
Бусад	3,556,703	2,857,941
	79,345,135	65,217,630
<i>Үйлчилгээ үзүүлсэн хугацааны туршид хүлээн зөвшөөрсөн хураамж, шимтгэлийн орлого:</i>		
Санхүүгийн баталгаа	12,084,388	9,871,697
Картын үйлчилгээ	3,089,117	2,871,948
	15,173,505	12,743,645
	94,518,640	77,961,275
<i>Шимтгэл, хураамжийн зардал</i>		
Картын үйлчилгээний шимтгэл	27,875,380	22,960,261
Бусад	5,283,671	4,552,412
	33,159,051	27,512,673
	61,359,589	50,448,602

7. Арилжааны болон үйл ажиллагааны бусад орлого/(зардал)

	2023	2022
	мян.төг	мян.төг
Ханшийн тэгшитгэлийн олз/(гарз), цэвэр	43,851,423	(65,052,424)
ХОЗҮХХ-ийн үнэлгээний олз (Тодруулга 19)	2,873,791	95,125
Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны олз/(гарз), цэвэр	2,097,115	(4,541,099)
БҮЦӨАА-д бүртгэх өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	1,700,000	–
Үнэт металлын арилжааны олз, цэвэр	1,630,146	6,053,482
ХОЗҮХХ борлуулсны олз	385,314	–
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга (Тодруулга 28)	203,242	232,737
Ногдол ашгийн орлого (Тодруулга 14)	194,694	182,954
Үндсэн хөрөнгө борлуулсны олз/(гарз), цэвэр	21,290	(133,393)
Бусад авлагын бүтцийн өөрчлөлтөөс үүссэн гарз (Тодруулга 18)	(8,311,181)	(13,861,532)
Своп хэлцлийн хүүний цэвэр зардал	(7,137,392)	(8,464,794)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэрэгжээгүй олз/(гарз)	(2,719,591)	97,805,076
БҮЦӨБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн олз/(гарз)	(69,385)	125,429
Орон сууцны зээлийн бүтцийн өөрчлөлтөөс үүссэн цэвэр гарз (Тодруулга 17)	–	(7,781,905)
Борлуулах зорилготой хөрөнгө борлуулсны олз/(гарз), цэвэр	–	(102,101)
Бусад	19,971,022	9,367,370
	54,690,488	13,924,925

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

8. Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал/(буцаалт)

	2023 мян.төг	2022 мян.төг
Бусад хөрөнгө (Тодруулга 18)	20,194,888	14,566,431
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Тодруулга 17)	11,761,534	(40,484,584)
Тэнцлийн гадуурх зээлийн үүрэг (Тодруулга 31)	3,116,152	(2,380,577)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэглүүр (Тодруулга 14)	334,357	226,875
Монголбанкинд байршуулсан мөнгө (Тодруулга 12)	138,967	52,543
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (Тодруулга 13)	35,986	349
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр (Тодруулга 14)	(162,837)	(278,876)
	35,419,047	(28,297,839)

9. Үйл ажиллагааны зардал

	2023 мян.төг	2022 мян.төг
Ажилтнуудын цалин, хөлс ба урамшуулал	88,706,960	77,025,204
Даатгал	16,126,922	7,473,497
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 21)	14,180,303	13,182,054
Зар сурталчилгаа, олон нийтийн харилцаа	14,280,646	14,778,631
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	6,977,664	7,153,613
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл (Тодруулга 22)	6,782,507	5,345,669
Мэдээллийн технологийн ашиглалт	6,651,094	5,686,303
Техникийн туслалцаа ба гадаадын банкны гуйвуулгын хураамж	5,431,175	4,179,474
Бичиг хэрэг, хангамжийн хэрэгсэл	4,064,581	4,040,166
Харилцаа холбооны үйлчилгээ	3,376,244	3,184,130
Ашиглалтын зардал	1,701,473	1,324,706
Томилолт	1,530,279	907,891
Харуул хамгаалалт	1,263,146	247,803
Засвар, үйлчилгээ	1,040,921	2,292,005
Биет бус хөрөнгийн хорогдуулалт (Тодруулга 23)	920,110	1,644,302
Түрээс	773,674	537,900
Сургалт	646,280	395,602
Хүлээн авалт, үзвэр үйлчилгээ	507,053	1,196,952
Тээвэр	506,333	583,593
Бэлэн мөнгөний зохицуулалт	461,967	967,593
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 21)	110,214	7,225,692
Борлуулах зориулалттай хөрөнгө борлуулсны гарз	8,831	–
Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 23)	1,809	1,685
Бусад	7,710,160	13,416,426
	183,760,346	172,790,891

Мэргэжлийн үйлчилгээний төлбөрт аудитын төлбөр болох 992,574 мянган төгрөг (2022 онд: 915,263 мянган төгрөг) багтсан болно.

10. Орлогын албан татвар

10.1 Орлогын албан татварын зардал

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх орлогын албан татварын зардал:

	2023 мян.төг	2022 мян.төг
Орлогын албан татвар:		
Тайлант үеийн орлогын албан татварын зардал	45,160,560	52,883,282
Өмнөх тайлант үеийн орлогын албан татварын тохируулга	–	(8,775,015)
Хойшлуулсан татвар:		
Татварын түр зөрүү (Тодруулга 10.3)	427,154	1,541,839
	45,587,714	45,650,106

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

10. Орлогын албан татвар (үргэлжлэл)

10.1 Орлогын албан татварын зардал (үргэлжлэл)

Банк нь санхүүгийн тайланд орлогын дүнг орлогын албан татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын албан татварын зардлыг тооцдог. Банк нь Монгол Улсын татварын хууль тогтоомжын дагуу 6 тэрбум (2022 онд: 6 тэрбум) төгрөг хүртэлх татвар ногдох орлогоос 10% (2022 онд: 10%), 6 тэрбум (2022 онд: 6 тэрбум)-аас илүү гарсан дүнгээс 25% (2022 онд: 25%) орлогын албан татвар төлдөг. Засгийн Газрын бондын хүүний орлого нь хуулийн дагуу татвар ногдохгүй орлого болно.

Банк нь татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Банкинд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд 2023 оны 12 дугаар сарын 31-нээр хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2023 мян.төг	2022 мян.төг
Татварын өмнөх ашиг	196,806,181	239,898,799
Татварын хувь хэмжээ болох 25%-иар тооцсон орлогын татварын зардал (2022 онд: 25%)	49,201,545	59,974,700
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөө	8,153,101	15,244,967
Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын нөлөө	941,635	1,047,492
Татвар ногдохгүй орлогын нөлөө	(1,410,671)	(957,973)
Татварын хувь хэмжээний зөрүү	(4,315,919)	(1,703,595)
Татвараас чөлөөлөгдөх орлогын нөлөө	(6,774,069)	(16,735,241)
Татварын хөнгөлөлтийн нөлөө	(207,908)	(37,852)
Өмнөх тайлант үеийн орлогын албан татварын тохируулга	–	(8,775,015)
Өмнөх тайлант үеийн хүлээн зөвшөөрөөгүй татварын алдагдлын ашиглалт	–	(2,407,377)
Тайлант жилийн татварын зардал	45,587,714	45,650,106

2023 онд ногдох үр ашигт татварын хувь хэмжээ нь 23.16% (2022: 19.03%).

10.2 Орлогын албан татварын өглөг

	2023 мян.төг	2022 мян.төг
1 сарын 1-нээрх орлогын татварын өглөг	55,742,118	12,499,999
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	45,160,560	52,883,282
Өмнөх тайлант үеийн орлогын албан татварын тохируулга	–	(8,775,015)
Ашиг алдагдалд ангилахгүй БҮЦӨБДО-д бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны орлогын албан татвар	7,340,103	–
Бусдад суутгуулсан	(941,635)	(866,148)
Төлсөн татвар	(30,393,733)	–
12 сарын 31-нээрх орлогын татварын өглөг	76,907,413	55,742,118

10.3 Хойшлогдсон татварын өр төлбөр

	2023 оны 1 сарын 1-нээр мян.төг	Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг	Ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг	2023 оны 12 сарын 31-нээр мян.төг
Хойшлуулсан татварын (хөрөнгө) /өр төлбөр				
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээ	254,219	3,563,918	–	3,818,137
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн дахин үнэлгээ	3,058,458	–	–	3,058,458
Хараат компанийн ашгийн хувь	(957,759)	–	427,154	(530,605)
Түрээсийн өглөг ба Ашиглах эрхтэй хөрөнгө	46,872	–	–	46,872
	2,401,790	3,563,918	427,154	6,392,862

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

10. Орлогын албан татвар (үргэлжлэл)

10.3 Хойшлогдсон татварын өр төлбөр (үргэлжлэл)

2022 оны 12 сарын 31-нээр	2022 оны 1 сарын 1-нээр мян.төг	Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг	Ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг	2022 оны 12 сарын 31-нээр мян.төг
Хойшлуулсан татварын (хөрөнгө) /өр төлбөр				
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээ	429,612	(175,393)	–	254,219
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн дахин үнэлгээ	1,558,458	–	1,500,000	3,058,458
Хараат компанийн ашгийн хувь	(999,598)	–	41,839	(957,759)
Түрээсийн өглөг ба Ашиглах эрхтэй хөрөнгө	46,872	–	–	46,872
	1,035,344	(175,393)	1,541,839	2,401,790

11. Нэгж хувьцаанд ногдох ашиг

Доорх хүснэгтээр нэгж хувьцааны үндсэн болон хорогдуулсан ашгийн тооцоололд ашигласан орлого болон хувьцааны мэдээллийг үзүүлэв:

	2023 мян.төг	2022 мян.төг
Энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг – үндсэн болон хорогдуулсан	151,218,467	194,248,693
Нэгж хувьцааны үндсэн болон хорогдуулсан ашгийн тооцоололд хэрэглэгдэх энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо	49,690,110	48,070,860

Нэгж хувьцаанд ногдох ашиг

Тухайн тайлангийн хугацаанд Банкны хувьцаа эзэмшигчдийн:	Төгрөг	Төгрөг
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг		
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	3,043	4,041
Энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг – үндсэн болон хорогдуулсан	3,043	4,041

Нэгж хувьцаанд ногдох ашгийг тухайн жилийн цэвэр ашгийг тухайн жилд эргэлтэнд байгаа энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хуваан тооцоолсон ба тайлангийн дараах үеийн хувьцааны өөрчлөлтийн нөлөөгөөр тохируулсан (Тодруулга 29-ийг харна уу)

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

12. Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө

	2023 мян.төг	2022 мян.төг
Бэлэн мөнгө	68,202,441	69,650,934
Монголбанк дахь харилцах	1,049,656,108	824,923,439
Монголбанк дахь хадгаламж	1,191,259,381	861,881,738
Дансны үнэ	2,309,117,930	1,756,456,111
Хасах нь: Монголбанкинд байршуулсан мөнгөний үнэ цэнийн бууралтын сан	(387,784)	(248,817)
Цэвэр дансны үнэ	2,308,730,146	1,756,207,294

Монголбанкнаас тавигддаг шаардлагын дагуу Монголбанкинд харилцан данс байршуулдаг. Монголбанкинд байршуулах бэлэн мөнгөний заавал байлгах нөөцийн үлдэгдэл нь хоёр долоо хоногийн туршид харилцагчдын харилцах, хадгаламжын дундаж үлдэгдлийн төгрөгийн 8.0% (2022 онд: 8.0%) ба гадаад валютын 18.0% (2022 онд: 18.0%)-иас тус тус багагүй байдаг

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны заавал байлгах шаардлагатай 14 хоногийн дундаж нөөцийн хэмжээ төгрөгөөр 323,409,967 мян.төг (2022 онд: 214,059,644 мян.төг) ба гадаад валютаар 738,326,513 мян.төг (2022 онд: 646,037,152 мян.төг) байсан.

Монголбанкинд байршуулсан мөнгөний үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд жилийн эцсийн ангилал болон Банкны дотоод зээлийн үнэлгээний систем дээр үндэслэсэн бэлэн мөнгө ороогүйгээр зээлийн чанар, зээлийн эрсдэлийн хамгийн их хэмжээг харуулав. Доор харуулсан дүнгүүд үнэ цэнийн бууралтын дүнг оруулаагүй дүнгээр илэрхийлэгдсэн. 2023 болон 2022 оны 12 сарын 31-ны байдлаар хөрөнгүүд нь В-үнэлгээтэй ба Шатлал 1-д ангилагдсан. Банкны дотоод үнэлгээний систем болон ЗҮЦХА-ын тооцооллыг тусгай эсвэл бүлгийн үнэлгээгээр тооцох зэрэг бодлого журмыг тодруулга 32-д дэлгэрэнгүй тусгасан болно:

	12 сар ЧМ шатлал	Нийт	
		Чанаргүйдэлд өртөх дүн Шатлал 1 мян.төг	ЗҮЦХА Шатлал 1 мян.төг
2023 оны 12 сарын 31	2.447%	2,240,915,489	(387,784)
2022 оны 12 сарын 31	2.373%	1,686,805,177	(248,817)

2023 болон 2022 оны 12 сарын 31-ний ЗҮЦХА-ын сангийн өөрчлөлтийн дүнг дараах байдлаар харуулав:

	2023 мян.төг	2022 мян.төг
1 сарын 1-нээр	248,817	196,274
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 8)	138,967	52,543
12 сарын 31-нээр	387,784	248,817

Нэмэлт мөнгөн урсгалын мэдээлэл

	2023 мян.төг	2022 мян.төг
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө (Тодруулга 12)	2,309,117,930	1,756,456,111
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (Тодруулга 13)	1,651,839,858	767,073,137
Монголбанкны үнэт цаас - 3 сараас доош хугацаатай (Тодруулга 14)	1,363,375,430	949,566,385
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,324,333,218	3,473,095,633
Хасах нь: Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаггүй Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	(1,061,736,480)	(860,096,796)
Хасах нь: Гадаадын банканд байршуулсан барьцаа	(3,644,263)	(188,969,117)
Хасах нь: Барьцаанд байршуулсан Монголбанкны үнэт цаас - 3 сараас доош хугацаатай	(46,255,897)	(308,646,228)
Цэвэр мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,212,696,578	2,115,383,492

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

13. Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

	2023 мян.төг	2022 мян.төг
Гадаадын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах	860,814,839	411,613,586
Гадаадын банканд байшуулсан барьцааны данс	3,644,263	188,969,117
Дотоодын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах	5,085,812	3,921,113
Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж	488,141,631	162,569,321
Дотоодын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж	294,153,313	–
Дансны дүн	1,651,839,858	767,073,137
Хасах нь: үнэ цэнийн бууралтын сан	(41,483)	(5,497)
Цэвэр үлдэгдэл	1,651,798,375	767,067,640

Бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд Банкны дотоод зээлийн үнэлгээний систем болон жилийн эцсийн үеийн шатлалын ангилал дээр үндэслэн зээлийн чанарын болон зээлийн эрсдэлийн дээд хэмжээг харуулав. Доор харуулсан дүнгүүд үнэ цэнийн бууралтын дүнг оруулаагүй дүнгээр илэрхийлэгдсэн. Банкны дотоод үнэлгээний систем болон ЗҮЦХА-ын тооцооллыг тусгай эсвэл бүлгийн үнэлгээгээр тооцох зэрэг бодлого журмыг тодруулга 32-д дэлгэрэнгүй тусгасан болно.

	12 сар ЧМ шатлал	Нийт	
		Чанаргүйдэлд өртөх дүн Шатлал 1 мян.төг	ЗҮЦХА Шатлал 1 мян.төг
2023 оны 12 сарын 31-нээр			
Дотоодын үнэлгээ			
A- to AA+ үнэлгээ	0.011% - 0.043%	1,344,103,021	3,437
BBB- to BBB+	0.1725%	1,618,714	4
B- to BB+	0.687% - 2.735%	300,956,089	37,127
Үнэлэгдээгүй	10.89%	5,162,034	915
		1,651,839,858	41,483
2022 оны 12 сарын 31-нээр			
Дотоодын үнэлгээ			
A- to AA+ үнэлгээ	0.008% - 0.033%	737,773,958	1,940
BBB- to BBB+	0.140%	2,244,155	6
B- to BB+	0.604% - 2.6%	8,902,522	243
Үнэлэгдээгүй	11.18%	18,152,502	3,308
		767,073,137	5,497

Дараах байдлаар 2022 болон 2023 оны 12 сарын 31-ний ЗҮЦХА-н сангийн өөрчлөлтийн шинжилгээ болон холбогдох дүнг харуулав:

	2023 Шатлал 1 мян.төг	2022 Шатлал 1 мян.төг
1 сарын 1-ний байдлаар дансны дүн	767,073,137	504,422,698
Шинээр худалдаж авсан хөрөнгө	57,190,702,069	393,377,371
Төлөгдсөн	(56,296,422,836)	(160,522,920)
Гадаад валютын тохируулга	(9,512,512)	29,795,988
12 сарын 31-ний байдлаар дансны дүн	1,651,839,858	767,073,137
1 сарын 1-ний байдлаар ЗҮЦХА	5,497	5,148
Шинээр худалдаж авсан хөрөнгө	32	3,558
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө (данснаас хассаныг оруулахгүй)	(2,323)	(168)
ЗҮЦХА-ын тооцоонд ашигласан дүнд оруулсан өөрчлөлтүүд	38,277	(3,041)
Тайлант жилд цэвэр байгуулсан (Тодруулга 8)	35,986	349
12 сарын 31-ний байдлаар ЗҮЦХА	41,483	5,497

14. Санхүүгийн хөрөнгө оруулалт

	2023 мян.төг	2022 мян.төг
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд		
бүртгэгдэх өрийн хэрэглүүр		
Биржид бүртгэлтэй Засгийн газрын ам.долларын бонд (а)	105,989,124	102,883,542
Биржид бүртгэлгүй Монголбанкны үнэт цаас (б)	1,363,375,430	949,566,385
Биржид бүртгэлтэй бонд-МИК (в)	41,170,073	27,362,835
	1,510,534,627	1,079,812,762
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд		
бүртгэгдэх өмчийн хэрэглүүр		
Биржид бүртгэлгүй өмчийн хэрэглүүр (г)	3,168,023	3,168,532
Биржид бүртгэлтэй өмчийн хэрэглүүр (д)	38,804,358	70,359,946
	41,972,381	73,528,478
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд		
бүртгэгдэх өмчийн хэрэглүүр		
Биржид бүртгэлгүй өмчийн хэрэглүүр (е)	1,700,000	–
	1,700,000	–
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр		
Биржид бүртгэлгүй бонд - Засгийн газар (ё)	–	242,599,801
Зээлээр баталгаажсан үнэт цаас - Давуу эрхтэй транч (ж)	1,311,976	7,953,415
	1,311,976	250,553,216
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд		
бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө		
Орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас (з)	360,010,446	260,184,968
Зээлээр баталгаажсан үнэт цаас - Энгийн эрхтэй транч (ж)	2,399,558	5,832,160
	362,410,004	266,017,128
	1,917,928,988	1,669,911,584

- (а) Бирж дээр бүртгэлтэй Засгийн газрын бондод гадаадын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагддаг Засгийн газрын бондууд багтана.
- (б) Биржид бүртгэлгүй Монголбанкны үнэт цаасыг нэрлэсэн үнээр эсвэл урамшуулал, хорогдуулалттай үнээр худалдаж авч болно.
- (в) Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй бонд нь гадаадын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагддаг МИК-ийн бонд юм.
- (г) Бирж дээр бүртгэлгүй өмчийн үнэт цаасны ангилалд хаалттай хувьцаат компанид оруулсан өмчийн хөрөнгө оруулалтууд багтана. Банк нь эдгээр компаниудад хяналтын бус ашиг сонирхолтой байдаг. Эдгээр хөрөнгө оруулалтуудыг Банк стратегийн шинж чанартай гэж үзэн эргэлт буцалтгүйгээр бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэхээр ангилсан
- (д) Бирж дээр бүртгэлтэй өмчийн үнэт цаас нь Виза компанид оруулсан хөрөнгө оруулалт юм. Тайлант жилийн туршид Банк нь Виза компаниас 194,694 мянган төгрөгийн ногдол ашиг (2022: 182,954 мянган төгрөг) хүлээн авч орлогын тайланд бусад орлогоор хүлээн зөвшөөрсөн. Тайлант хугацаанд Банк Монголиан Майнинг Корпорэйшн ХХК дахь хөрөнгө оруулалтаа борлуулж, бусад дэлгэрэнгүй орлогод 32,960 сая төгрөгийн (татварын дараах 25,620 сая төгрөг) олзыг хүлээн зөвшөөрсөн.
- (е) Монголиан нэшнл рийр ийрт корп ХХК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт бөгөөд банк тус компанийн нийт хувьцааны 10 хувийг эзэмшдэг.
- (ё) Засгийн газрын бонд нь хөрөнгийн биржид бүртгэлгүй, хүүтэй Монгол улсын Засгийн газрын бонд ба 2023 онд бүрэн төлөгдсөн.
- (ж) Зээлээр баталгаажсан үнэт цаас (“ЗБҮЦ”) нь Үнэт Цаасны Санхүүжилтийн Корпораци (“ҮЦСК”)–ийн 100% эзэмшлийн Тусгай Зориулалттай компаниудаас гаргасан хүүтэй, урт хугацаат энгийн болон давуу эрхтэй транчаас бүрдэнэ. Банк нь тогтмол хүүтэй буцаан худалдан авах гэрээгээр санхүүжүүлсэн бизнесийн зээлүүдийг ТЗК-д шилжүүлж, оронд нь ЗБҮЦ-ыг хүлээн авсан (Тодруулга 17-г харна уу)
- (з) Орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас (“ИЗББ”) нь Монголын Ипотекийн Корпораци (“МИК”)–аас гаргасан хүүтэй, урт хугацаат энгийн болон давуу эрхтэй бондноос бүрдэнэ (Тодруулга 17-г харна уу).

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

14. Санхүүгийн хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд Банкны дотоод зээлийн үнэлгээний систем болон жилийн эцсийн шатлалын ангилал дээр үндэслэсэн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх болон хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг зээлийн эрсдэл ба ЗҮЦХА-ын хамт харуулав. 2022 болон 2023 оны 12 сарын 31-нээр өрийн хэрэглүүрүүдийн дотоод зээлийн үнэлгээ нь В- ээс В+ ба шатлал 1-д ангилагдсан. Банкны дотоод үнэлгээний систем, үнэ цэнийн бууралтын хэмжилтийн талаархи мэдээллийг Тодруулга 32-д тайлбарласан.

	2023		2022	
	Бодит үнэ цэн/Нийт дансны үнэ мян.төг	ЗҮЦХА мян.төг	Бодит үнэ цэн/Нийт дансны үнэ мян.төг	ЗҮЦХА мян.төг
БУЦӨБДО-д бүртгэгдэх өрийн хэрэглүүр				
1 сарын 1-нээр	1,079,812,762	717,436	1,754,434,647	490,561
Шинээр худалдаж авсан хөрөнгө	9,232,252,460	935,714	10,855,406,821	485,116
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(8,819,778,863)	(608,578)	(11,531,546,548)	(258,241)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт	5,751,514	7,221	(18,175,222)	–
Валютын ханшийн тохируулга	12,496,754	–	19,693,064	–
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 8)	–	334,357	–	226,875
12 сарын 31-нээр	1,510,534,627	1,051,793	1,079,812,762	717,436
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр				
1 сарын 1-нээр	250,731,568	178,352	591,136,516	457,228
Шинээр худалдаж авсан хөрөнгө	2,823,891	15,515	25,860,700	49,096
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(252,227,968)	(178,352)	(366,265,648)	(327,972)
Тайлант жилд байгуулсан/(буцаалт)	–	(162,837)	–	(278,876)
12 сарын 31-нээр	1,327,491	15,515	250,731,568	178,352

15. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк нь МИК-ийн 10.00% (2022 онд: 10.00%) (МИК-ийн халаасны хувьцааг авч үзвэл 13.58% (2022 онд: 13.58%))-г эзэмшдэг (Тодруулга 3-ыг харна уу).

МИК-ийн үндсэн үйл ажиллагаа нь Монгол улсад ИЗББ гарган, түүгээр барьцаалан эсвэл олон улсын зах зээл дээр гаргасан бондын санхүүжилтээр орон сууцны зээлийн багц худалдан авах юм. МИК нь МХБ-д бүртгэлтэй хувьцаат компани юм. Банк нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар МИК-ийн 2,070,932 ширхэг (2022 онд: 2,070,932 ширхэг) хувьцааг эзэмшиж байгаа ба МХБ дээрхи МИК-ийн нэгж хувьцааны хаалтын ханш 22,000 төгрөг (2022 онд: 20,260 төгрөг) байсан.

Энэхүү Банкны санхүүгийн тайлан гарах өдрийн байдлаар МИК нь 2023 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон жилийн аудитлагдсан санхүүгийн тайлангаа гаргасан байсан. Банкны МИК дахь хөрөнгө оруулалтыг МИК-ийн 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн эздийн өмчийн аргаар бүртгэв (2022 онд: Боломжит хамгийн сүүлийн санхүүгийн мэдээлэл).

	Мян.төг
2022 оны 1 сарын 1-нээр	506,297
Хараат компанийн тайлант жилийн ашгийн Банканд ногдох хувь	418,388
2022 оны 12 сарын 31-нээр болон 2023 оны 1 сарын 1-нээр	924,685
Хараат компанийн тайлант жилийн ашгийн Банканд ногдох хувь	3,817,834
Өмнөх жилийн ашгийн Банканд ногдох хувийн залруулга	453,704
Нийт ашгийн Банканд ногдох хувь	4,271,538
2023 оны 12 сарын 31- нээр	5,196,223

15. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Банкны МИК-д оруулсан хөрөнгө оруулалтын хураангуй санхүүгийн мэдээллийг дараах хүснэгтэд үзүүлэв:

	2023 мян.төг	2022 мян.төг
Хараат компани: МИК		
Нийт хөрөнгө	5,180,166,368	4,551,197,297
Нийт өр төлбөр	<u>(5,141,902,576)</u>	<u>(4,544,388,129)</u>
Эздийн өмч	38,263,792	6,809,168
Эздийн өмч дэхь Банкны эзэмшлийн хувь 13.58% (2022: 13.58%)	<u>5,196,223</u>	<u>924,685</u>
Тухайн жилийн цэвэр хүүний орлого	83,224,706	80,832,933
Тухайн жилийн нийт бусад дэлгэрэнгүй орлого	28,113,656	3,080,311

16. Үүсмэл санхүүгийн хэрэглүүр

Доорх хүснэгтэд хөрөнгө болон өр төлбөрт бүртгэгдсэн үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг нэрлэсэн үнийн хамтаар харууллаа. Нэрлэсэн үнэ нь үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн суурь болж буй хөрөнгө, жишиг ханш эсхүл индекс байх бөгөөд үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжих суурь болно. Нэрлэсэн үнэ нь тайлант жилийн эцсийн байдлаарх гүйлгээний дүнг харуулах бөгөөд энэ нь зах зээлийн эрсдэл эсхүл зээлийн эрсдэлийг тодорхойлох үзүүлэлт болж чадахгүй юм.

	Нэрлэсэн үнэ мян.төг	Бодит үнэ цэнэ	
		Хөрөнгө мян.төг	Өр төлбөр мян.төг
2023 оны 12 сарын 31-нээр			
<i>Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэглүүр</i>			
МИК, Монголбанктай хийсэн валют, хүүний своп хэлцэл (а)	515,730,880	1,135,791	152,977,717
Монголбанктай хийсэн валют, хүүний своп хэлцэл (б)	726,552,450	167,518,868	6,132,032
Бусадтай хийсэн валют, хүүний своп хэлцэл (в)	62,351,320	3,533,918	–
	<u>1,304,634,650</u>	<u>172,188,577</u>	<u>159,109,749</u>
2022 оны 12 сарын 31-нээр			
<i>Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэглүүр</i>			
МИК, Монголбанктай хийсэн валют, хүүний своп хэлцэл (а)	515,730,880	164,487,198	163,873,260
Монголбанктай хийсэн валют, хүүний своп хэлцэл (б)	514,981,550	98,664,180	17,439
Форвард хэлцэл	91,916,250	2,223,053	2,312,838
	<u>1,122,628,680</u>	<u>265,374,431</u>	<u>166,203,537</u>

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хувьд анхны хөрөнгө оруулалт бага байх буюу эсхүл огт шаардахгүй. Хэдий тийм боловч эдгээр санхүүгийн хэрэглүүр нь ихэвчлэн хөшүүргийн зэргийг өндөрсгөх бөгөөд нилээн тогтворгүй байна. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэлцлийн хөрөнгө, түвшин, индексийн үнэлгээний жижиг хэмжээний өөрчлөлт нь банкны ашиг, алдагдалд томоохон нөлөө үзүүлж болзошгүй.

Банк нь үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн гэрээний эрсдэлд өртөх дүнг банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд тодорхойлдог. Банкны эрсдэлийн удирдлагын стратеги ба түүний хэрэгжүүлэлтийн талаар Тодруулга 32-д толилуулав.

(а) Банк нь 2019 оны 3 дугаар сарын 28-нд МИК-тэй валют, хүүний своп хэлцэл (үүсмэл санхүүгийн өр төлбөр) хийсэн ба мөн өдөр Монголбанктай эсрэг позицитай хэлцэл (үүсмэл санхүүгийн хөрөнгө) хийсэн буюу Банк нь зуучлагчын байр суурьнаас хэлцэлд орсон. Банк нь анх МИК-ээс америк долларын санхүүжилт хүлээн авч спот ханшаар тооцон төгрөг төлсөн ба мөн Монголбанкинд америк долларын санхүүжилт шилжүүлж, спот ханшаар тооцон төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Монголбанктай байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд SOFR дээр тодорхой хэмжээний ашиг нэмсэн хүүг хүлээн авч төгрөгийн санхүүжилтэд төв банкны бодлогын хүүгээр хүү төлсөн. Нөгөөтэйгүүр МИК-тэй байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд Монголбанкнаас авсан хүүтэй ижил хувиар хүү төлж, төв банкны бодлогын хүү дээр 0.1%-ийг нэмсэнтэй тэнцэх хүү хүлээн авна. Банк нь энэхүү хоёр гэрээ дуусах өдрөөрх ханшийн зөрүүгээр санхүүжилтийг барагдуулж мөн төлбөрийг хүлээн авна.

16. Үүсмэл санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

(б) Банк нь Монголбанктай валют, хүүний своп хэлцэл хийсэн. Банк нь анх Монголбанкинд америк долларын санхүүжилт төлж, спот ханшаар тооцон төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Монголбанктай байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд SOFR дээр тодорхой хэмжээний ашиг нэмсэн хүүг хүлээн авах ба төгрөгийн санхүүжилтэд төв банкны бодлогын хүүтэй тэнцүү хувиар тооцсон хүү төлнө. Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд анхны гүйлгээний валютын ханшаар үндсэн төлбөрийг солилцоно.

(в) Банк нь 2023 оны 8 дугаар сарын 14 болон 2023 оны 10 дугаар сарын 2-ний өдөр Дижитал Концепт ХХК-тай валют, хүүний своп хэлцэл (үүсмэл санхүүгийн өр төлбөр) хийсэн ба мөн өдөр Монголбанктай эсрэг позицйн хэлцэл (үүсмэл санхүүгийн хөрөнгө) хийсэн буюу Банк нь зуучлагчын байр суурьнаас хэлцэлд орсон. Банк нь анх Дижитал Концепт ХХК-аас америк долларын санхүүжилт хүлээн авч спот ханшаар тооцон төгрөг төлсөн ба мөн Монголбанкинд америк долларын санхүүжилт шилжүүлж, спот ханшаар тооцон төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Монголбанктай байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд SOFR дээр тодорхой хэмжээний ашиг нэмсэн хүүг хүлээн авч төгрөгийн санхүүжилтэд төв банкны бодлогын хүүгээр хүү төлсөн. Нөгөөтэйгүүр Дижитал Концепт ХХК-тай байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь америк долларын санхүүжилтэд Монголбанкнаас авсан хүүтэй ижил хувиар хүү төлж, төв банкны репо хүү дээр 1%-ийг нэмсэнтэй тэнцэх хүү хүлээн авна. Банк нь энэхүү хоёр гэрээ дуусах өдрөөрх ханшийн зөрүүгээр санхүүжилтийг барагдуулж мөн төлбөрийг хүлээн авна.

17. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

	2023	2022
	мян.төг	мян.төг
Байгууллагын зээл	3,346,336,133	3,238,302,119
Иргэдийн зээл	1,128,045,255	609,782,895
Жижиг, дунд байгууллага (“ЖДБ”)-ын зээл	598,955,743	419,507,830
Гүйцэтгэх удирдлага, захирал, ажилтнуудад олгосон зээл	23,475,898	19,397,814
Харилцагчдад олгосон нийт зээл ба урьдчилгаа	5,096,813,029	4,286,990,658
Үнэ цэнийн бууралтын сан	(411,987,392)	(480,684,826)
Харилцагчдад олгосон цэвэр зээл ба урьдчилгаа	4,684,825,637	3,806,305,832
БҮЦӨАА-д бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	248,631,585	330,876,566
Нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	4,933,457,222	4,137,182,398

Нийт дүнгээр нь үл хүлээн зөвшөөрч шилжүүлсэн санхүүгийн хөрөнгүүд

Орон сууцны зээлийн багцын борлуулалт

Банк нь тайлант жилд тогтмол хүүтэй орон сууцны барьцаат зээлийн багцаас орж ирэх мөнгөн урсгалыг хүлээн авах эрхийг МИК-ийн тусгай зориулалтын компаниудад худалдаж, оронд нь ИЗББ-ыг худалдан авсан. Банк нь 279,126,790 мянган төгрөгийн (2022 онд: 191,776,365 мянган төгрөг) зээлийн багцыг үл хүлээн зөвшөөрч энгийн болон давуу эрхтэй ИЗББ-ыг санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 14-ийг харна уу). Банк нь шилжүүлсэн хөрөнгүүдийн хувьд үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэх байдлаар үргэлжлүүлэн оролцож байгаа бөгөөд улирал тутам үйлчилгээний үнийн дүнгийн 2.5%-ийг үйлчилгээний хөлс болгон авдаг. 2023 онд хүлээн зөвшөөрсөн үйлчилгээний нийт төлбөр хураамж 5,205 сая төгрөг (2022 онд: 2,003 сая төгрөг) байсан ба энэ нь шимтгэлийн орлогод багтсан.

Бизнесийн зээлийн багцын борлуулалт

2021 оны 2 дугаар сарын 20-д Монгол улсын Засгийн Газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх” 10 их наядын цогц төлөвлөгөөг баталсан. Хөтөлбөр нь жижиг дунд үйлдвэрүүд (ЖДҮ), орон сууцжуулалт, стратегийн ач холбогдол бүхий төсөл хөтөлбөрүүд, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, боловсролын хүртээмжийг дэмжих 5 хэсгээс бүрдсэн бөгөөд 2023 он хүртэл үргэлжлэх төлөвтэй байна.

17. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Нийт дүнгээр нь үл хүлээн зөвшөөрч шилжүүлсэн санхүүгийн хөрөнгүүд (үргэлжлэл)

Бизнесийн зээлийн багцын борлуулалт (үргэлжлэл)

Банк нь ЖДҮ-ийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд ҮЦСК-ийн 100%-ийн өмчит тусгай зориулалтын компанитай үнэт цаасжуулалтын хөтөлбөрт оролцож, ЖДҮ-ийн зээлийн багцыг худалдсан. Банк нийт 3,503 сая төгрөгийн (2022 онд: 28,561 сая төгрөг) жилийн 10.5%-ийн хүүтэй, 2-3 жилийн хугацаатай ЖДҮ-ийн зээлийн багцыг үл хүлээн зөвшөөрч, хариу төлбөрт ЗБҮЦ хүлээн авсан. Эдгээр гүйлгээний хүрээнд ҮЦСК-д худалдсан зээлтэй холбоотой бүх эрсдэл, өгөөж Банканд үлдээгүй бөгөөд Банк хөрөнгийн хяналтыг ҮЦСК-д бүрэн шилжүүлсэн. Иймд Банк зээлийн багцыг үл хүлээн зөвшөөрч, жилийн 9.0%-ийн (2022 онд: 9.5%) хүүтэй, 3 хүртэлх жилийн хугацаатай давуу болон энгийн эрхтэй ЗБҮЦ-ыг санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 14-ийг харна уу).

Банк нь шилжүүлсэн хөрөнгүүдийн хувьд үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэх байдлаар үргэлжлүүлэн оролцож байгаа бөгөөд улирал тутам үйлчилгээний үнийн дүнгийн 0.5%-ийг үйлчилгээний хөлс болгон авдаг. 2023 онд хүлээн зөвшөөрөгдсөн үйлчилгээний нийт төлбөр хураамж 60,805 мянган төгрөг (2022 онд: 96,047 мянган төгрөг) ба энэ нь шимтгэлийн орлогод багтсан.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

2023 оны 12 дугаар 31-нээр Банк нь 248,632 сая төгрөгийн (2022 онд: 319,335 сая төгрөг) МИК-д худалдах ипотекийн зээлийн багц, 0 төгрөгийн (2022 онд: 11,541 сая төгрөг) ҮЦСК-д худалдах зээлийн багцыг эзэмшиж байсан. Эдгээр харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгөд ангилсан.

Нийт дүнгээр нь үл хүлээн зөвшөөрөөгүй шилжүүлсэн санхүүгийн хөрөнгүүд

Түүнчлэн, Банк нь МИК-д үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан зээлийн багцаас орж ирэх ирээдүйн мөнгөн урсгалыг үүрэг хүлээх нөхцөлтэйгээр худалдсан. Банк нь 2021 онд нийт 119,683 сая төгрөгийн (2022, 2023 онд: байхгүй) дүнтэй орон сууцны зээлийг МИК руу худалдсан ба оронд нь 13.8%-ийн хүүтэй санхүүжилт хүлээн авсан бөгөөд энэ нь 2023 онд бүрэн төлөгдөж дууссан (Тодруулга 28-ийг харна уу). Эдгээр гүйлгээний дагуу зарагдсан зээлийн бүх эрсдэл ба өгөөжийг банк бүрэн хариуцна. Тиймээс уг хөрөнгө нь данснаас үл хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангаагүй. 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үл хүлээн зөвшөөрөлтийг хангаагүй хөрөнгө байгаагүй (2022 онд: 143,281 сая.төгрөг).

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд Банкны дотоодын зээлийн үнэлгээний систем, жилийн эцсийн ангилал дээр тулгуурлаж зээлийн чанарыг багц болон сангийн хөдөлгөөнөөр илэрхийлж харуулсан болно. Үүнд үнэ цэнийн бууралтын санг оруулаагүй бодит хэмжээг тусгасан. Банкны дотоод үнэлгээний системийн талаар болон ЗҮЦХА-ыг тусгай болон бүлгийн үнэлгээгээр хэрхэн үнэлэхийг тодруулга 32-д дэлгэрэнгүй тайлбарласан.

2023 оны 12 сарын 31-нээр	Байгууллагын		Иргэдийн зээл мян.төг	Нийт мян.төг
	зээл мян.төг	ЖДБ-ын зээл мян.төг		
2023 оны 1 сарын 1-ээрх дансны дүн	3,238,302,119	420,167,378	628,521,161	4,286,990,658
Шинээр олгосон	1,225,001,918	368,596,902	913,846,138	2,507,444,958
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(1,014,257,559)	(183,611,608)	(391,952,628)	(1,589,821,795)
Хуримтлагдсан хүүний цэвэр хөдөлгөөн	(11,718,519)	(1,372,942)	488,148	(12,603,313)
Сегментийн өөрчлөлтийн нөлөө	4,145,829	(4,145,829)	–	–
Данснаас хассан	(78,326,253)	(14,247)	(16,456)	(78,356,956)
Валютын ханшийн тохируулга	(16,811,402)	(4,189)	(24,932)	(16,840,523)
2023 оны 12 сарын 31-нээр	3,346,336,133	599,615,465	1,150,861,431	5,096,813,029
2023 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	429,176,309	33,990,825	17,517,692	480,684,826
Шинээр олгосон	31,557,019	5,312,242	2,847,530	39,716,791
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(29,181,950)	(9,156,939)	(5,413,433)	(43,752,322)
Хуримтлагдсан хүүний цэвэр хөдөлгөөн	6,940,724	239,847	270,390	7,450,961
ЗҮЦХА-н шатлал шилжилт болон тооцооллын өөрчлөлтийн нөлөө	1,532,900	5,866,785	946,419	8,346,104
Сегментийн өөрчлөлтийн ЗҮЦХА-д үзүүлэх нөлөө	66,847	(66,847)	–	–
Тайлант хугацааны цэвэр зардал (Тодруулга 8)	10,915,540	2,195,088	(1,349,094)	11,761,534
Данснаас хассан	(78,326,253)	(14,247)	(16,456)	(78,356,956)
Валютын ханшийн тохируулга	(2,087,581)	147	(14,578)	(2,102,012)
2023 оны 12 сарын 31-нээр	359,678,015	36,171,813	16,137,564	411,987,392

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

17. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан (үргэлжлэл)

2022 оны 12 сарын 31-нээр	Байгууллагын зээл мян.төг	ЖДБ-ын зээл мян.төг	Иргэдийн зээл мян.төг	Нийт мян.төг
2022 оны 1 сарын 1-ээрх дансны дүн	3,672,863,022	535,436,302	572,177,859	4,780,477,183
Шинээр олгосон	878,273,917	91,766,582	394,879,755	1,364,920,254
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(1,382,812,916)	(198,453,620)	(337,847,573)	(1,919,114,109)
Хуримтлагдсан хүүний цэвэр хөдөлгөөн	(63,199,291)	(2,602,198)	(804,538)	(66,606,027)
Сегментийн өөрчлөлтийн нөлөө	4,787,430	(4,787,430)	–	–
Данснаас хассан	(10,417,350)	(1,407,856)	(305,713)	(12,130,919)
Валютын ханшийн тохируулга	138,807,307	215,598	421,371	139,444,276
2022 оны 12 сарын 31-нээр	3,238,302,119	420,167,378	628,521,161	4,286,990,658
2022 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	460,582,583	51,525,615	18,225,753	530,333,951
Шинээр олгосон	15,671,639	2,256,615	1,992,656	19,920,910
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(114,561,275)	(20,154,936)	(6,891,084)	(141,607,295)
Хуримтлагдсан хүүний цэвэр хөдөлгөөн	(12,911,072)	(142,381)	(3,271)	(13,056,724)
ЗҮЦХА-н шатлал шилжилт болон тооцооллын өөрчлөлтийн нөлөө	85,290,145	4,477,993	4,490,387	94,258,525
Сегментийн өөрчлөлтийн ЗҮЦХА-д үзүүлэх нөлөө	2,568,811	(2,568,811)	–	–
Тайлант хугацааны цэвэр зардал (Тодруулга 8)	(23,941,752)	(16,131,520)	(411,312)	(40,484,584)
Данснаас хассан	(10,417,350)	(1,407,856)	(305,713)	(12,130,919)
Валютын ханшийн тохируулга	2,952,828	4,586	8,964	2,966,378
2022 оны 12 сарын 31-нээр	429,176,309	33,990,825	17,517,692	480,684,826
	Байгууллагын зээл мян.төг	ЖДБ-ын зээл мян.төг	Иргэдийн зээл мян.төг	Нийт мян.төг
2023 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	2,386,451,751	554,897,185	1,127,526,777	4,068,875,713
Анхаарал хандуулах	391,754,945	4,121,198	5,528,808	401,404,951
Хэвийн бус	132,326,310	12,540,207	4,684,732	149,551,249
Эргэлзээтэй	123,447,377	2,474,805	1,296,954	127,219,136
Муу	312,355,750	25,582,070	11,824,160	349,761,980
Нийт	3,346,336,133	599,615,465	1,150,861,431	5,096,813,029
2022 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	2,032,577,414	371,098,063	603,925,636	3,007,601,113
Анхаарал хандуулах	420,687,760	3,437,427	2,965,130	427,090,317
Хэвийн бус	267,708,014	18,176,509	6,639,945	292,524,468
Эргэлзээтэй	118,910,776	4,807,424	3,111,008	126,829,208
Муу	398,418,155	22,647,955	11,879,442	432,945,552
Нийт	3,238,302,119	420,167,378	628,521,161	4,286,990,658

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

17. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны дансны үнэ болон СТОУС 9-н дагуу санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарын дагуу харгалзах ЗҮЦХА сангийн өөрчлөлтүүдийг харуулвал:

<i>Бизнесийн зээл</i>	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
*Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн бэлэн мөнгөөрх нэмэгдэлийг илэрхийлнэ.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

31. Болзошгүй өр төлбөр ба үүрэг

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд, Банк нь янз бүрийн буцалтгүй үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээж байдаг. Хэдийгээр эдгээр үүргийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй байж болох ч, эдгээр нь зээлийн эрсдэл, улмаар Банкны нийт эрсдэлийг бүрдүүлж байдаг (Тодруулга 32-ыг харна уу).

	2023 мян.төг	2022 мян.төг
Эх үүсвэргүй баталгаа болон аккредитив	522,557,915	321,497,517
Ашиглаагүй зээлийн шугам	455,919,038	248,247,384
	978,476,953	569,744,901

Доорхи хүснэгтээр тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүрэг дээрх үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг харуулав:

	Эх үүсвэргүй баталгаа болон аккредитив мян.төг	Ашиглаагүй зээлийн шугам мян.төг	Нийт мян.төг
2023 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	2,566,608	2,374,778	4,941,386
Шинээр нэмэгдсэн	3,402,151	1,041,703	4,443,854
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(798,247)	(529,455)	(1,327,702)
Тайлант жилийн эрсдэлийн сангийн зардал (Тодруулга 8)	2,603,904	512,248	3,116,152
2023 оны 12 сарын 31-нээр	5,170,512	2,887,026	8,057,538
2022 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	3,302,522	4,019,441	7,321,963
Шинээр нэмэгдсэн	2,066,586	1,194,407	3,260,993
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(2,802,500)	(2,839,070)	(5,641,570)
Тайлант жилийн эрсдэлийн сангийн зардал (Тодруулга 8)	(735,914)	(1,644,663)	(2,380,577)
2022 оны 12 сарын 31-нээр	2,566,608	2,374,778	4,941,386

2023 болон 2022 оны 12 сарын 31-ний дансны үлдэгдэл болон холбогдох ЗҮЦХА сангийн өөрчлөлтийн болон зээлийн чанарын шинжилгээг доорх хүснэгтэд харуулав:

Эх үүсвэргүй баталгаа болон аккредитив

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2023 оны 1 сарын 1-ээрх дансны дүн	308,769,629	11,809,226	918,662	321,497,517
Шинээр нэмэгдсэн	410,728,582	12,852,753	2,862	423,584,197
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(215,119,125)	(7,577,386)	172,712	(222,523,799)
Шилжилт/ Шатлал 1 руу	(342,513)	342,513	–	–
2023 оны 12 сарын 31-нээр	504,036,573	17,427,106	1,094,236	522,557,915
2023 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	3,522,506	(955,898)	–	2,566,608
Шинээр нэмэгдсэн	3,373,050	28,421	680	3,402,151
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(2,311,797)	970,177	543,373	(798,247)
Шилжилт/ Шатлал 1 руу	(1,072)	1,072	–	–
2023 оны 12 сарын 31-нээр	4,582,687	43,772	544,053	5,170,512

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

31. Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)

Эх үүсвэргүй баталгаа болон аккредитив (үргэлжлэл)

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2022 оны 1 сарын 1-ээрх дансны дүн	312,654,951	–	40,149,702	352,804,653
Шинээр нэмэгдсэн	247,969,388	2,433,577	–	250,402,965
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(194,816,405)	(58,863,400)	(28,030,296)	(281,710,101)
Шилжилт/ Шатлал 1 руу	11,200,744	–	(11,200,744)	–
Шилжилт/ Шатлал 2 руу	(68,239,049)	68,239,049	–	–
2022 оны 12 сарын 31-нээр	308,769,629	11,809,226	918,662	321,497,517
2022 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	2,538,355	–	764,167	3,302,522
Шинээр нэмэгдсэн	2,043,902	22,684	–	2,066,586
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(1,054,469)	(983,864)	(764,167)	(2,802,500)
Шилжилт/ Шатлал 1 руу	–	–	–	–
Шилжилт/ Шатлал 2 руу	(5,282)	5,282	–	–
2022 оны 12 сарын 31-нээр	3,522,506	(955,898)	–	2,566,608

2022 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх дансны үнийг зээлийн чанараар харуулвал:

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2023 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	504,036,573	–	–	504,036,573
Анхаарал хандуулах	–	17,427,106	–	17,427,106
Хэвийн бус	–	–	1,094,236	1,094,236
Нийт	504,036,573	17,427,106	1,094,236	522,557,915
2022 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	308,769,629	–	–	308,769,629
Анхаарал хандуулах	–	11,809,226	–	11,809,226
Хэвийн бус	–	–	918,662	918,662
Нийт	308,769,629	11,809,226	918,662	321,497,517

Ашиглаагүй зээлийн шугам

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2023 оны 1 сарын 1-ээрх дансны дүн	243,344,806	4,817,058	85,520	248,247,384
Шинээр нэмэгдсэн	152,870,544	246,533	61,784	153,178,861
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	58,271,675	(3,730,459)	(48,423)	54,492,793
Шилжилт/ Шатлал 1 руу	(8,512)	–	8,512	–
2023 оны 12 сарын 31-нээр	454,478,513	1,333,132	107,393	455,919,038
2023 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	2,340,987	33,782	9	2,374,778
Шинээр нэмэгдсэн	1,038,060	3,643	–	1,041,703
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(549,668)	16,145	4,068	(529,455)
Шилжилт/ Шатлал 1 руу	–	–	–	–
2023 оны 12 сарын 31-нээр	2,829,379	53,570	4,077	2,887,026

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

31. Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)

Ашиглаагүй зээлийн шугам (үргэлжлэл)

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2022 оны 1 сарын 1-ээрх дансны дүн	284,295,098	11,612,186	1,188,453	297,095,737
Шинээр нэмэгдсэн	122,319,732	4,044,473	–	126,364,205
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(163,126,077)	(11,154,106)	(932,375)	(175,212,558)
Шилжилт/ Шатлал 1 руу	767,165	(453,445)	(313,720)	–
Шилжилт/ Шатлал 2 руу	(724,592)	769,941	(45,349)	–
Шилжилт/ Шатлал 3 руу	(186,520)	(1,991)	188,511	–
2022 оны 12 сарын 31-нээр	243,344,806	4,817,058	85,520	248,247,384
2022 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	3,983,938	35,503	–	4,019,441
Шинээр нэмэгдсэн	1,167,930	26,477	–	1,194,407
Хугацаа дууссан эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(2,816,054)	(22,256)	(760)	(2,839,070)
Шилжилт/ Шатлал 1 руу	13,737	(13,737)	–	–
Шилжилт/ Шатлал 2 руу	(7,825)	7,825	–	–
Шилжилт/ Шатлал 3 руу	(739)	(30)	769	–
2022 оны 12 сарын 31-нээр	2,340,987	33,782	9	2,374,778

2022 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх дансны үнийг зээлийн чанараар харуулвал:

	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
2023 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	454,478,513	–	–	454,478,513
Анхаарал хандуулах	–	1,333,132	–	1,333,132
Хэвийн бус	–	–	107,393	107,393
Нийт	454,478,513	1,333,132	107,393	455,919,038
2022 оны 12 сарын 31-нээр				
Хэвийн	243,344,806	–	–	243,344,806
Анхаарал хандуулах	–	4,817,058	–	4,817,058
Хэвийн бус	–	–	85,520	85,520
Нийт	243,344,806	4,817,058	85,520	248,247,384

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар Банк 74 сая ам.доллар (2022 онд: 89 сая ам. доллар) (Тодруулга 21) болон 3,100 сая төгрөгийн (2022 онд: 1,030 сая төгрөг) бусад гэрээний үүрэг хүлээсэн байна.

Болзошгүй өр төлбөр

Аккредитив, баталгаа нь тусгай үйл явдал тохиолдоход харилцагчийн өмнөөс голдуу тендер, төлбөрийн баталгаатай холбоотойгоор төлбөр хийх үүргийг банканд ногдуулдаг. Баталгаа нь зээлийн эрсдэлтэй ижил эрсдэлийг агуулдаг.

Үүрэг

Үүрэг гэдэг нь Банкны зүгээс зээл олгох, зээлийн шугам нээх гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл олгох үүрэг нь хэрэгжээгүй байтал тус үүргийнх нь хугацаа нь дууссан байж болох тул гэрээнд заасан дүн нь ирээдүйн мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн ойлголт биш юм.

Ашиглаагүй зээлийн шугам

Энэхүү хэрэгслийн гол зорилго нь харилцагчид шаардлагатай хэмжээний санхүүжилт бэлэн байгааг баталгаажуулах юм. Батлагдсан зээлийн шугамын эрхээс ашиглагдаагүй байгаа хэсэг нь зээлийг нэмэгдүүлэх үүргийг тодорхойлно. Зээлийг нэмэгдүүлэх үүргийн эрсдэл нь, ашиглаагүй зээлийн эрхийн хэмжээгээр Банк алдагдал хүлээх эрсдэл юм. Гэсэн хэдий ч, зээлийн эрхийг хэвийн байлгах тодорхой шалгуур үзүүлэлтүүдээс хамааран алдагдлын дүн нь нийт ашиглаагүй зээлийн эрхийн хэмжээнээс бага байх талтай байдаг.

31. Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)**Шүүхийн нэхэмжлэл**

Бизнесийн онцлог шинж чанарын улмаас Банкны салбарт аливаа маргааныг шүүхийн үйл ажиллагааны дагуу шийдвэрлэх нь энгийн үзэгдэл байдаг. Банк нь шүүхийн нэхэмжлэлтэй хэрхэн ажиллах талаар тогтсон журамтай. Нэгэнт мэргэжлийн зөвлөгөө авсан, гарч болох хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолсон бол Банк нь тухайн нэхэмжлэлийн банкны санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс хамгаалан дансандаа залруулах бичилт хийдэг.

2022 болон 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар дээр дурдсанаас бусад Банктай холбоотой ямар нэгэн томоохон шүүхийн хэрэг бүртгэгээгүй байна.

Татварын тухай хууль тогтоомж

Монгол Улсын татварын хууль тогтоомжид тайлбар, өөрчлөлт тодорхой хэмжээгээр орж байдаг. Банкны гүйлгээ, үйл ажиллагаанд хамааралтай ийм хууль тогтоомжийн талаарх удирдлагын тайлбарыг татварын алба үгүйсгэж болно.

Монголын татварын алба хууль тогтоомж, үнэлгээг тайлбарлахдаа илүү хатуу байр суурь баримталж байгаа бөгөөд урьд өмнө маргаан үүсгээгүй гүйлгээ, үйл ажиллагааг татварын алба няцааж болзошгүй юм. Үүний үр дүнд ихээхэн хэмжээний нэмэлт татвар, торгууль, хүүг тооцож болзошгүй. Санхүүгийн жилүүд татварын талаар хянах жилийн өмнөх таван жилийн хугацаанд эрх бүхий байгууллагуудаар хянуулахад нээлттэй хэвээр байна. Зарим тохиолдолд тойм нь илүү урт хугацааг хамарч болно.

Монгол Улсын үнэ шилжилтийн тухай хууль тогтоомж нь татварын албанд үнэ шилжилтийн тохируулга хийх, хянах боломжтой бүх гүйлгээ, түүний дотор дотоод шилжилтийн үнэтэй холбоотой нэмэлт татварын өр төлбөр ногдуулах боломжийг олгож байна. Гүйлгээний нөхцөл нь зах зээлийн нөхцлөөс гажсан тохиолдолд татварын алба татвар ногдуулах зүйлд тохируулга хийх, нэмэлт татвар, торгууль, хүүний торгууль ногдуулах эрхтэй. Одоогийн Монгол Улсын үнэ шилжилттэй холбоотой өөрчлөлтийн үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй хэдий ч байгууллагын санхүүгийн байдал, нийт үйл ажиллагаанд томоохон нөлөөтэй байх боломжтой.

Монгол Улсын татварын хууль тогтоомж нь тодорхой чиглэлээр, ялангуяа НӨАТ, суутганы албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар болон бусад чиглэлээр эцсийн шийдвэрлэх зааварчилгаа өгдөггүй. Банк нь аль болох ойрхон хугацаанд татварын ерөнхий хэмжээг бууруулж болохуйц эргэлзээтэй хэсгүүдийг тодорхой болгохыг эрмэлздэг. Дээр дурдсанчлан сүүлийн үеийн захиргааны болон шүүхийн үйл ажиллагааны зохицуулалтын өөрчлөлт, шинэчлэлтийн үр дүнд нарийн хяналтын дагуу татварын ийм байр сууриуд бий болж болох юм. Эдгээр нь байгууллагын санхүүгийн байдал болон ерөнхий үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой буюу нөлөөтэй байх боломжтой хэдий ч Татварын албанаас бий болгож болох аливаа шийдвэр, хяналт шалгалтын үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй билээ.

Удирдлагын зүгээс татварын эрсдэлийн талаар тогтмол үнэлгээ, шинжилгээ хийдэг боловч одоогийн байдлаар хангалттай урьдчилан таамаглах боломжгүй ирээдүйн өөрчлөлтөөс болж нөхцөл байдал өөрчлөгдөж болох юм.

32. Эрсдэлийн удирдлага**(1) Оршил**

Банкны үйл ажиллагааны салшгүй гол эрсдэлүүд бол зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хүүний түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлүүд байдаг. Банкны Зээлийн эрсдлийн газар ("ЗЭГ") нь банкны зээлийн эрсдэлийг удирдах үүрэгтэй бол Эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын газар нь зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг ерөнхийд нь дэмжих үүрэгтэй. Энэхүү тодруулгад Банкны хөрөнгө зохицуулалт, эрсдлийн удирдлага ба хяналтын үйл ажиллагаа, бодлого, зорилтууд болон дээр дурдсан эрсдэлд өртөх байдлын талаарх мэдээллийг толилуулав.

Төлөөлөн удирдах зөвлөл

Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь Банкны эрсдэлийн удирдлагын оновчтой тогтолцоог бий болгохыг хариуцах ба эрсдэлийн удирдлагын бодлого болон Банкны ерөнхий эрсдэл хүлээх чадвар болон хүлээн зөвшөөрөх эрсдэлийг батлах үүрэгтэй.

ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо ("ТУЗЭУХ")

ТУЗЭУХ нь банкны эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, бодлого, зарчмыг батлах ба гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын бодлогыг банкны үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжүүлж ажилладаг. ТУЗЭУХ нь дотоодын аудитын дэмжлэгтэйгээр эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэн ажилладаг.

32. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(1) Оршил (үргэлжлэл)

Дотоод аудит

Банкны эрсдэлийн удирдлагын үйл явцад Дотоод аудитын газар жилд нэг удаа аудит хийх ба аудитын үед Банкны журмуудын зохистой байдал хийгээд Банканд дагаж мөрдөж байгаа байдлыг шалгадаг. Дотоод аудит нь журмын зохистой байдлыг шалгахаас гадна Банкны журмын мөрдөлт, хэрэгжүүлэлтийг хянадаг.

Гүйцэтгэх удирдлагын хороо

Гүйцэтгэх удирдлагын хороо нь Банкны Гүйцэтгэх удирдлагуудаас бүрдэх бөгөөд Банкны стратегийн асуудал, бизнесийн бодлого төлөвлөлт болон банкны үйл ажиллагааны тогтвортой хөгжлийн талаар хэлэлцэж шийдвэр гаргаж, захирлуудын харилцан уялдааг ханган ажилладаг.

Актив пассивын удирдлагын хороо (“АПУХ”)

АПУХ нь санхүүжилтийн хөрөнгө болон өр төлбөрийг төвлөрсөн удирдлагаар хангах, хөрвөх чадвар, гадаад валют, эргэн төлөгдөх хугацааны зөрүү болон хүүний эрсдэлийг тодорхой түвшинд хангаж ажиллах үүрэгтэй. АПУХ-ны зорилго нь Банкны санхүүгийн тайлангийн актив пассивын бүтцийг Банкний тогтвортой хөгжлийг хангах байдлаар тогтоох, актив пассивын ерөнхий удирдлагаар ашигт ажиллагаа болон хөрвөх чадварыг хангах болон удирдахад оршино.

Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”)

Эрсдэлийн Удирдлагын хороо нь үндсэн зорилгынхоо хүрээнд эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэл даах чадвар, ICAAP, ILAAP болон бусад эрсдэлийн удирдлагын арга хэрэгслийг баталж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулах санал, зөвлөмж гаргах үүрэгтэй.

Зээлийн хороод

Зээлийн хорооны бүтцийг Банкны бүх төрлийн зээлийн эрсдэлийг удирдахад дөхөм байхаар зохион байгуулсан. Зээлийн хяналт болон шийдвэр гаргалтанд дараах түвшний Зээлийн хороод оролцдог:

1. Зээлийн хороо нь 1 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй зээлийн өргөдлийг хэлэлцэн батлахаас гадна Банкны зээлийн үйл ажиллагааны заавар журмын өөрчлөлтийг батална.
2. Зээлийн дэд хороо нь 500 сая төгрөгөөс 1 тэрбум хүртэлх дүнтэй зээлийн өргөдлийг баталдаг.
3. Зээлийн зөвлөл нь салбар зээлийн хорооны батлах хязгаараас дээш 500 сая төгрөг хүртэлх зээлийн өргөдлийг баталдаг.
4. Салбарын зээлийн зөвлөл нь цалин болон тэтгэврийн зээлээс бусад салбарын захирлын хязгаараас дээш салбарын зээлийн зөвлөлийн хязгаар хүртэлх зээлийн өргөдлийг баталдаг.
5. Зээлийн зөвлөл нь 30 сая төгрөгөөс дээш дүнтэй цалин болон тэтгэврийн зээлийн өргөдлийг баталдаг.
6. Салбарын зээлийн зөвлөл нь салбарын эрхийн хэмжээнд үндэслэн 100-300 сая төгрөгийн зээлийн өргөдлийг баталдаг.

Банкны эрсдэлийн удирдлагын бодлогыг Банканд тулгарч буй эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, эрсдэлийн зохих хязгаарлалт, хяналтыг тогтоох, эрсдэл ба хязгаарлалтад нийцэж буй байдалд хяналт тавих зорилгоор тогтоодог. Зах зээлийн нөхцөл байдал, санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний өөрчлөлтийг тусгахын тулд эрсдэлийн удирдлагын бодлого, системийг тогтмол хянаж үздэг. Банк нь сургалт, стандарт, журмаараа дамжуулж ажилтнуудаа өөрсдийн үүрэг, хариуцлагаа ухамсарлаж байх сахилга баттай, үр дүнтэй хяналтын орчинг бий болгохыг зорьж байна.

Эрсдэлийг хэмжих болон тайлагнах систем

Банк нь статистик загваруудын тусламжтайгаар түүхэн алдагдлаас ойролцоолон тооцсон ердийн тохиолдолд хүлээж болзошгүй алдагдал болон гэнэтийн тохиолдолд учирч болзошгүй онцгой алдагдлыг давхар хэмжиж чадах системийг ашиглан эрсдэлийг хэмждэг. Эдгээр статистик загваруудыг түүхэн өгөгдлөөр тооцсон магадлалыг эдийн засгийн өнөөгийн орчинд нийцүүлэх байдлаар хэрэглэдэг.

Эрсдэлийг хянах, хянах гол хэрэгслүүдийн нэг бол эрсдэлийн аппетитын хязгаар юм. Банк нь үйл ажиллагааныхаа эрсдэлийн аппетитийг Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан зохистой байдлын шалгуур үзүүлэлт, түүнд тавих хяналт шалгалтын журам, Базелийн хорооноос гаргасан эрсдэлийн удирдлагын олон улсын зөвлөмж, түүнчлэн банкны өөрийн эрсдэлийн удирдлагын бодлого гэх мэт олон төрлийн хүчин зүйлсэд үндэслэн тодорхойлдог. Эдгээр бүх хүчин зүйлүүд нь банкны эрсдэлийн аппетитийг бий болгоход чиглэгддэг.

32. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**(1) Оршил (үргэлжлэл)****Эрсдэлийг хэмжих болон тайлагнах систем (үргэлжлэл)**

Эрсдэлийн аппетитийг тогтсоноор Банкны стратегийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд саад учруулж болох гол эрсдэлүүдийг харгалзан стратегийн болон дунд хугацааны зорилгодоо хүрэхийн тулд тухайн жилд хүлээж авах эрсдэлийн түвшинг тодорхойлдог.

Эрсдэлд дүн шинжилгээ хийх, хянах, эрт илрүүлэх зорилгоор банкны бүх нэгжээс гаргасан тайлангуудыг шалгаж боловсруулдаг. Судалгааны үр дүнг ТУЗ, ТУЗЭУХ, АПУХ, ЭУХ, Зээлийн хороод болон бизнесийн хэлтэс тус бүрийн даргад танилцуулна. АПУХ болон ЭУХ аль аль нь улирал бүр эрсдэлийн иж бүрэн тайланг хүлээн авдаг бөгөөд энэ нь Банкны эрсдэлийг үнэлэх, дүгнэлт гаргахад шаардлагатай бүх мэдээллээр хангах зорилготой юм.

Эрсдэлийг бууруулах

Хүүгийн түвшний эрсдэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болох болзошгүй эрсдэлийн хэмжээг мэдрэмжийн шинжилгээгээр тооцон, хянаж ажилладаг. Банк зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор барьцаа хөрөнгө болон хувь хүний батлан даалт авдаг.

Эрсдэлийн хэт төвлөрөл

Эдийн засгийн нэг салбарын Банкны харилцагчдад олгосон зээл, Банкны тодорхой бүтээгдэхүүн үйлчилгээг цөөн тооны зээлдэгчид үзүүлэх зээлийн өндөр төвлөрөл нь зээлийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Иймд Банк өдөр тутмын үйл ажиллагаандаа Монголбанкнаас тогтоосон зээлийн төвлөрлийн хязгаарыг баримталж, зээлийн багцын оновчтой бүтцийг тодорхойлж, хэт төвлөрсөн бүтцийг төрөлжүүлэх бодлого, стратегийг баримтлан ажиллаж байна.

Эрсдэлийн хэт төвлөрлөөс зайлсхийх үүднээс Банк өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг.

Зээлийн төвлөрлийн эрсдэл болон Банкны эрсдэл даах чадварыг зохицуулах уялдаа холбоотой байдлыг хангах үүднээс зохицуулагч байгууллага нь “Банкны үйл ажиллагааны зохистой байдлыг тогтоох, хяналт тавих журам”-ын дагуу хязгаар тогтоодог. Үүнд:

- Нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд олгох нийт зээлийн дүн болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн нийлбэр дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 20%-аас хэтрэхгүй.
- Банк холбогдох этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 5%-аас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20%-аас тус тус хэтрэхгүй.

(2) Зээлийн эрсдэл

Банкны харилцагч гэрээний дагуух үүргээ биелүүлээгүй тохиолдолд Банканд үүсч болох алдагдлын эрсдэлийг зээлийн эрсдэл гэнэ. Банк нь зээлийн өргөдлүүдийг анхааралтай хянах, эрсдэлийн түвшинд тохируулсан хүүний хувь хэмжээг тогтоох, харилцагч талуудыг газарзүйн байршил, аж үйлдвэрийн салбараар ангилан зээлийн эрсдэлд өртөх түвшинд хязгаар тогтоох зэргээр зээлийн эрсдэлд хяналт тавьдаг.

Банк нь харилцагч талуудын зээлжих чадварт орж болзошгүй өөрчлөлт (барьцаа хөрөнгөө тогтмол шинэчлэх гэх мэт)-ийг эртнээс олж таних зорилгоор зээлийн чанарын хяналтын процессийг нэвтрүүлсэн. Зээлийн чанарын хяналтын процесс нь Банканд болзошгүй алдагдлыг тодорхойлох, засах арга хэмжээг эрт авах боломжийг бий болгодог.

Банк зээлийн үйл ажиллагааг сайжруулахын тулд зээлийн журам зааврыг тогтмол шалгаж, сайжруулж шинэчилдэг.

Зээлтэй холбоотой болзошгүй үүргийн эрсдэл

Банк нь харилцагчийн өмнөөс төлбөр төлөх магадлал бүхий баталгаа, аккредитивийг гаргадаг. Төлбөр төлөгдөх тохиолдолд баталгаа, аккредитивийн нөхцөлд тулгуурлан харилцагчаас эх үүсвэрийг төвлөрүүлнэ. Банканд зээлтэй нэгэн адил эрсдэл учруулах тул эдгээрийг зээлийн үйл ажиллагааны бодлого, журмаар зохицуулна.

Үнэ цэнийн бууралтын үнэлгээ***Чанаргүйдэл, үнэ цэнийн бууралт ба сайжруулалтын тодорхойлолт***

Зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрөө 90 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн эсвэл Банк зээлдэгчийн барьцаа хөрөнгийг борлуулах замаар эргэн төлөлтийг гүйцээх магадлалтай бүх тохиолдолд тухайн санхүүгийн хэрэглүүрийг үл төлөгдөх магадлалтай гэж үзэн хүлээгдэж буй алдагдлыг тооцдог.

32. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)****Үнэ цэнийн бууралтын үнэлгээ (үргэлжлэл)*****Чанаргүйдэл, үнэ цэнийн бууралт ба сайжруулалтын тодорхойлолт (үргэлжлэл)***

Харилцагчдын санхүүгийн хэрэглүүрийг чанарын үнэлгээгээр үнэлж зээлийг “үнэ цэнийн бууралттай” гэж үзэх болон эргэн төлөгдөхгүй байх магадлалуудыг Банк авч үздэг. Энэ тохиолдолд Банк харилцагчийн санхүүгийн хэрэглүүрийг үл төлөгдөх магадлалтай эсэхийг нарийвчлан шинжилж хүлээгдэж буй алдагдлыг 2-р шатлал эсвэл 3-р шатлалын алинд нь тооцоологдохыг тодорхойлох замаар үнэлгээг хийнэ. Чанарын үнэлгээг хийхдээ дараах хүчин зүйлийг харгалзан үздэг. Үүнд:

- Зээлдэгчийн санхүүгийн хүндрэлээс болж тус зээл нөхцөл өөрчлөлтөд орсон;
- Зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрөө 90 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн
- Зээлдэгч нь эрсдэлд орох нөхцөл байдал үүссэн эсвэл ойрын хугацаанд эрсдэх магадлалтайг тодорхойлсон Банкны дотоод үнэлгээ
- Зээлдэгч нас барах аль эсхүл хөдөлмөрийн чадвараа алдах
- Зээлдэгчийн үйл ажиллагаа гэнэтийн хүчин зүйлээс эрсдэлд учирсан
- Зээлийн хугацаанд барьцаа хөрөнгийн үнэ цэн материаллаг хэмжээгээр буурах;
- Зээлдэгч (эсвэл зээлдэгчийн бүлэгт хамаарах аливаа хуулийн этгээд) нь дампуурлын талаархи өргөдөл мэдэгдэл гаргах.

Үл төлөгдөх магадлалд орох эсэх шалгууруудын хүчин зүйл нь дараалсан 6 сар үргэлжлэн илрээгүй бол санхүүгийн хэрэглүүрийг "үнэ цэн сайжирсан" гэж үзэн 3-р шатлалаас шилжүүлэх эсэхийг Банк өөрийн бодлогоор зохицуулна. Активын үнэ цэн сайжирч 1-р шатлал болон 2-р шатлалд ангилах эсэх шийдвэр нь тухайн зээлийн болон зээл олгох үеийн дотоод үнэлгээтэй харьцуулахад эрсдэл хэрхэн өссөн байгаагаас хамаарна.

Банкны дотооддоо хэрэглэдэг үнэлгээний систем болон ЧМ-ын тооцоолол

Банкны зээлийн эрсдэлийн газар нь дотоод үнэлгээний загварыг гаргадаг. Энэхүү загварууд нь чанарын болон тоон мэдээллийг агуулдаг бөгөөд зээлдэгчийн онцлог мэдээллээс гадна зээлдэгчийн зан төлөвт нөлөөлж болох гадны нэмэлт мэдээллийг ашигладаг. Практик боломжтой үед Банк нь олон улсын, тухайлбал Мүүдиз, Стандарт энд Пурс, Фитч үнэлгээний байгууллагуудын мэдээллийг ашигладаг. Аль шатлалд хөрөнгийг ангилахад дээрх эх сурвалжуудыг ашигладаг.

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа төлбөрийн чанаргүйдлийн магадлалыг тооцоходоо түүхэн мэдээллүүд дээр үндэслэн тооцох бөгөөд холбогдох макро эдийн засгийн хүчин зүйлсийг ашиглан урьдчилан таамаглалын тохируулгыг хийнэ. ЧМ нь нөхцөлт ЧМ гэж тодорхойлогддог бөгөөд энэ нь өмнөх хугацаанд тухайн дансны хувьд хийгдсэн бүрэн ба хэсэгчилсэн төлөлтийг харгалзан үзэж ЧМ муруйг бий болгодог. Мөн түүнчлэн, Банк ЧМ муруйг янз бүрийн хугацааны хувьд тооцоолохын тулд банк “кохорт” дүн шинжилгээг ашигладаг.

Зээл болон урьдчилгаанаас бусад санхүүгийн хөрөнгийн хувьд ашигладаг ЧМ загвар нь үнэлгээний матриц дээр суурилсан бөгөөд энэ нь холбоотой талуудын олон улсын зээлийн үнэлгээний мэдээллээс гардаг. Энэхүү зээлийн үнэлгээний мэдээллүүд нь ирээдүйн мэдээллүүдийг агуулсан байдаг.

Хөрөнгө зохицуулалт, арилжаа ба банк хоорондын харилцаа

Банкны хөрөнгө зохицуулалт, арилжаа ба банк хоорондын харилцаа болон хамтрагч талуудад санхүүгийн байгууллагууд, банк, брокер-дилерүүд, хөрөнгийн биржүүд болон клеринг төвүүд багтана. Эдгээр харилцагч байгууллагын хувьд, Банкны Хөрөнгө зохицуулалтын газраас олон улсын үнэлгээний агентуудын (тухайлбал, Мүүдиз) нийтэд нээлттэй гадаад мэдээлэлд дүн шинжилгээ хийж дотооддоо үнэлгээ өгдөг.

Бизнесийн болон ЖДБ зээл

Бизнесийн болон ЖДБ зээлийн эрсдэлийг үнэлэхдээ зээлдэгчдийг зээлийн эрсдлийг газрын шинжээчдийн хяналт дор зээлийн мэргэжилтнүүд үнэлдэг. Зээлийн эрсдлийн үнэлгээ нь харилцагчийн түүхэн, одоо, ирээдүйн нөхцөл байдлын мэдээллийг харгалзан үздэг. Үүнд:

- Харилцагчийн санхүүгийн төсөөлөл болон түүхэн мэдээлэл. Энэхүү санхүүгийн мэдээлэл нь харилцагчийн санхүүгийн гүйцэтгэлийн хэрэгжилт, хүлээгдэж буй үр дүн, төлбөрийн чадварын харьцаа, хөрвөх чадварын харьцаа болон бусад холбогдох санхүүгийн чадамжийг үнэлэх харьцаануудыг агуулна. Эдгээр үзүүлэлтүүдийн зарим нь үйлчлүүлэгчидтэй хийсэн гэрээнүүд дээр тулгуурласан байдаг тул илүү анхаарч авч үздэг.
- Харилцагчдын талаарх бусад эх сурвалжаас гаралтай нийтэд нээлттэй мэдээлэл.
- Макро-эдийн засгийн болон геополитикийн аливаа мэдээлэл
- Банкны гүйцэтгэлд хамаарах харилцагчийн менежментийн чанар, ур чадварын талаарх бодитой мэдээлэл

32. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

Үнэлгээний арга барилын нарийн төвөгтэй байдал нь зээлийн хэмжээ болон харилцагчийн цар хүрээндээ шалтгаалан өөр өөр байдаг. Зарим бизнесийн зээл нь жижиг бизнест зориулсан Банкны дотоод загвараар үнэлэгддэг.

Хэрэглээний зээл

Хэрэглээний зээлд иргэдийн бүх төрлийн хэрэглээний зээл, кредит карт болон орон сууцны зээлүүд багтдаг. Эдгээр зээлийн бүтээгдэхүүнүүд болон зарим жижиг бизнесийн зээлийн эрсдэлийн үнэлгээг зээлдэгчийн хугацаа хэтрэх магадлалыг тодорхойлох аргачлал бүхий программын загвараар үнэлдэг. Үүнд: хүн ам зүй, зээл хүсэгчийн зээлийн түүх, барьцаа хөрөнгө, одоогийн орлогын түвшин, дансны орлогын өөрчлөлт, өр төлбөрийн үлдэгдэл болон хүссэн зээлийн нөхцөл зэргийг харгалзан үздэг.

Банкны дотоод үнэлгээ

Дотоод үнэлгээ	Дотоод үнэлгээний тайлбар	Олон улсын үнэлгээ
Хэвийн	Маш сайн	A- to AA+ зэрэгтэй
Анхаарал хандуулах	Ахисан дунд үнэлгээ	BBB- to BBB+
Хэвийн бус	Дунд үнэлгээ	B- to BB+
Эргэлзээтэй	Доод үнэлгээ	Саа-С
Муу	Үнэ цэн буурсан	–
Үнэлэгдээгүй	Үнэлэгдээгүй	–
Тусгай үнэлгээгээр үнэ цэн буурсан	Тусгай үнэлгээгээр үнэ цэн буурсан	–

Чанаргүйдэлд өртөх дүн (“ЧӨД”)

ЧӨД нь тайлант өдрөөс хойш эрсдэлд хүлээгдэж буй өөрчлөлтүүд, тухайлбал гэрээгээр эсвэл өөр хэлбэрээр төлөвлөгдсөнөөс үл хамааран үндсэн зээлийн болон хүүний эргэн төлөлт, хүлээгдэж буй хөрөнгийн зарцуулалт, хуримтлагдсан хүү зэрэг хүлээгдэж буй өөрчлөлтийг харгалзан тооцсон ирээдүйд санхүүгийн хэрэглүүр чанаргүйдэх үед өртөх хэмжээг хэлнэ. Санхүүгийн хөрөнгийн ЧӨД нь түүний үнэ цэнийн бууралтын тооцоонд хамаарах нийт дансны үнийг илэрхийлдэг бөгөөд энэ нь чанаргүйдэлд ойртох үед үйлчлүүлэгчийн өртөх дүнгээ нэмэгдүүлэх, мөн эрт урьдчилан төлөх боломжийн аль алиныг нь харгалзан үздэг. Зээлийн карт болон бусад зээлийн шугамын чанаргүйдэлд өртөх дүнг тодруулга 2.5-аас харна уу.

1-р шатлалд буй зээлийн ЧӨД-г тооцоолохдоо Банк нь 12 сар дотор үүсэж болох чанаргүйдэх үйл явдлыг 12 сарын ЗҮЦХА-г тооцоход авч үзнэ. 2-р шатлал болон 3-р шатлалуудад ЧӨД-г тодорхойлохдоо нийт хугацааны түүхэн чанаргүйдэх үйл явдлыг авч үзнэ.

12 сарын болон зээлийн хугацааны ЧӨД нь бүтээгдэхүүний төрлөөс хамааран хүлээгдэж буй төлбөрийг үндэслэн тодорхойлогддог:

- Хорогдуулсан болон нэг удаагийн эргэн төлөлттэй зээлийн, зээлдэгчийн 12 сарын хугацаанд эсвэл зээлийн хугацаанд нь төлөх гэрээний төлбөрт үндэслэнэ. Мөн түүнчлэн зээлдэгчийн хүлээгдэж буй илүү төлөлтийг тохируулж өгнө. Энэхүү тооцооллод эрт төлөлт/дахин санхүүжүүлэлтийн таамаглалыг мөн тусгаж өгнө.
- Зээлийн шугамын бүтээгдэхүүний хувьд ЧӨД-г тодорхойлохдоо лимитээс ашигласан дүн дээр чанаргүйдэх үед лимитээс үлдсэн дүн зээлд хөрвөх хүлээгдэж буй дүнг таамаглах "зээлд хөрвөх хүчин зүйл"-ийг нэмэх замаар урьдчилан таамаглаж байна. Эдгээр таамаглал нь бүтээгдэхүүний төрөл болон одоогийн хязгаарын ашиглалтаас хамаарч өөр өөр байдаг.

Алдагдалд хүргэх чанаргүйдэл

АХЧ нь Банкны хүлээгдэж буй үл төлөгдөх зээлийн хэмжээг илэрхийлнэ. АХЧ нь харилцан тохиролцсон хэлбэр, нэхэмжлэлийн төрөл болон зэрэглэл, барьцаа хөрөнгө эсвэл бусад зээлийн дэмжлэг зэргээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. АХЧ нь зээл/авлага дефолт болох үед хүлээх алдагдлын нэгж хувиар илэрхийлэгдэнэ. АХЧ-ийг 12 сар эсвэл зээлийн хугацааны туршид тооцдог бөгөөд 12 сарын АХЧ нь дараагийн 12 сард дефолт болох тохиолдолд гарах алдагдлын хувийг тооцдог бөгөөд зээлийн хугацааны туршид АХЧ нь үлдэгдэл зээлийн хугацаанд гарах алдагдлын хувийг тооцдог.

АХЧ нь барьцааны үнэ болон төлөлтөөс хамааран цаг хугацаа өнгөрөх тусам өөрчлөгдөж байдаг. АХЧ -ийн коэффициентийн гол элементүүд нь:

- Цагийн хэмжээс (ЧӨД параметрийг баталгаатай, баталгаагүй хэсэгт хуваах) ба
- Барьцаа хөрөнгийн үнэ цэн өөрчлөгдөхөд (үл хөдлөх хөрөнгө гэх мэт барьцааны тохиолдолд үнэ нь өөрчлөгдөхгүй хэвээр байх болно)

32. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)*****Алдагдалд хүргэх чанаргүйдэл (үргэлжлэл)***

Санхүүгийн хэрэглүүрд барьцаа хөрөнгө байхгүй, үл төлөлтийн түүхэн өгөгдөл хангалттай байгаа тохиолдолд Банк шинжээчдийн дүгнэлтийг гаргадаг. Тайлангийн өдрөөрх нөхцөл байдал, өгөгдлийн бүрэн гүйцэд байдлаас хамааран Банк АХЧ-ийн коэффициентийн үе шатыг тодорхойлохын тулд түүхэн мэдээллийн хандлага эсвэл гадаад эх сурвалжаас авсан түүхэн өгөгдлийг ашигладаг.

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт

Банк нь ЗҮЦХА-д хамаарах бүх хөрөнгийг тасралтгүй хянадаг. Тухайн нэг санхүүгийн хэрэглүүр эсвэл багц хэрэглүүр нь 12 сарын ЗҮЦХА эсвэл нийт хугацааны ЗҮЦХА-т хамаарах эсэхийг тодорхойлохын тулд Банк нь уг хөрөнгүүдийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг үнэлдэг.

Анх хүлээн зөвшөөрөгдсөнөөс хойш санхүүгийн хэрэглүүрийг чанаргүйдэх эрсдэл мэдэгдэхүйц хэмжээнд өссөн эсэхийг тодорхойлохдоо Банк нь зардал, хүчин чармайлт гаргахгүйгээр олж авсан үндэслэлтэй болон хамааралтай мэдээллийг авч үздэг. Үүнд Банкны түүхэн туршлага, шинжээчдийн зээлийн үнэлгээнд үндэслэсэн, хэтийн төлөвийг харуулсан тоон болон чанарын мэдээлэл, дүн шинжилгээ орно.

Банк нь гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн тохиолдолд чанарын шинжилгээ хийдэг. Зарим тохиолдолд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн шалтгааныг чанаргүйдэл бус “Чанаргүйдлийн тодорхойлолт”-д дурьдагдсан үйл явдлуудтай холбож тайлбарладаг. Зээлийн ангиллын өөрчлөлтийг үл харгалзан 30 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн байна гэж үздэг.

Ижил төстэй бүлэг хөрөнгүүдийн ЗҮЦХА-г тооцохдоо, анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг шинжлэхдээ ижил арга, аргачлалуудыг ашигладаг.

Бүлгийн үнэлгээгээр санхүүгийн хөрөнгүүдийг ангилах нь

Доорх хүчин зүйлээс хамаарч “ЗҮЦХА зарчмуудын тойм” 2.5-т тайлбарласнаар Банк нь ЗҮЦХА -ын нөөцийг бүлгийн болон тусгай үнэлгээгээр тооцдог.

Банк нь ЗҮЦХА -ийг тусгай үнэлгээгээр тооцоолох хөрөнгийн ангилалд дараах зээлүүд орсон:

- Шатлал 3-т ангилагдсан, зээлийн өрийн үлдэгдэл 5.0 тэрбум төгрөгөөс их зээлдэгчдийн хувьд тусгайлсан үнэлгээг хийх
- Холбоотой зээлдэгчдийн доторх аль нэг зээлдэгч нь шатлал 3-т ангилагдсан бөгөөд тухайн холбоотой зээлдэгч нарын нийт зээлүүдийн өрийн үлдэгдэл (бүх үе шатууд дах зээлүүд орно) нь 5.0 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй байх
- Шатлал харгалзахгүйгээр томоохон бөгөөд онцгой шинж чанартай байгууллагын зээлийн багцын зээл

Банк нь ЗҮЦХА -ийг бүлгийн үнэлгээгээр тооцоолох үед тусгай үнэлгээнд ороогүй бүх зээлийг оруулна. Банк нь эдгээр зээлүүдийг зээлдэгчийн сегмент дээр үндэслэн доорх жижиг багцуудад ангилдаг.

- Байгууллагын зээл
- Жижиг, дунд байгууллага (“ЖДБ”)-ын зээл
- Иргэдийн зээл

ЗҮЦХА -ын загварын өгөгдөлд дүн шинжилгээ хийх нь – Ирээдүйн мэдээлэл

Банк нь ЧМ болон ЗҮЦХА-г тооцоолохдоо ирээдүйг илтгэх мэдээллийг ашиглан ирээдүйн макро эдийн засгийн өөрчлөлт ЗҮЦХА-д хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж үздэг. Энгийн шугаман хамаарлын аргыг ашиглан ажиглагдахуйц чанаргүйдлийн/дефолтын хувь болон макро эдийн засгийн хүчин зүйл хоорондын харилцан хамаарлыг тооцдог. Ашигласан мэдээллийн багцад зээлийн бүтээгдэхүүн бүрд хамаарах ЧМ болон голлох макро хүчин зүйлүүдийн улирал бүрийн мэдээллүүд ордог. Макро эдийн засгийн хүчин зүйлийн мэдээллийг Үндэсний статистикийн хороо болон Монголбанкны мэдээллийн сангаас татдаг бол ЧМ хувь нь банкны дотоод мэдээллийн сангаас гаргасан түүхэн мэдээллийг ашигладаг. Банк нь 2023 онд Иргэдийн зээлийн хувьд бодлогын хүү болон инфляцийн түвшинг, Байгууллагын болон ЖДБ зээлийн хувьд ДНБ-ийн өсөлт болон инфляцийн түвшинг ашигласан ба эдгээр нь чанаргүйдэх магадлалтай хамгийн өндөр харилцан хамааралтай байсан (2022 онд: Иргэдийн зээлийн хувьд бодлогын хүү болон инфляцийн түвшинг нэг жил нэг улирлын хоцрогдолтойгоор, Байгууллагын болон ЖДБ зээлийн хувьд ДНБ-ийн өсөлт болон Зээлийн өсөлт).

32. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

ЗҮЦХА -ын загварын өгөгдөлд дүн шинжилгээ хийх нь – Ирээдүйн мэдээлэл (үргэлжлэл)

Арга зүйн хувьд, эхлээд оновчтой макро эдийн засгийн хүчин зүйлүүдийг урьдчилан сонгохдоо шугаман хамаарлын шинжилгээ хийсэн. Дараа нь коэффициентуудыг энгийн регрессийн шинжилгээ ашиглан тооцоолсон. Тооцооллын үр дүнд гарсан коэффициентууд болон таамаглалуудаас ЧМ-д хамаарах ирээдүйн талаарх мэдээлэл хүчин зүйлүүдийг тохируулан авч үзсэн тул урьдчилсан чанаргүйдлийн хувь болон түүхэн дундаж чанаргүйдлийн хувийн харьцааг ЧМ болгон авч үзсэн. Эдгээр тохируулга нөлөөлөгч хүчин зүйлс болон тохируулсан ЧМ хувиуд нь ирээдүйн эдийн засгийн өсөлтийн талаар хамгийн бодитой төсөөлөл өгч чадна гэж үзсэн тул ЗҮЦХА загварын суурь төсөөлөл болно. Сайн болон муу төсөөллүүдийг тухайн загвараар таамагласан чанаргүйдлийн хувь дахь түүхэн тохируулагч хүчин зүйлүүдийг үндэслэн тооцсон ба тохируулагч хүчин зүйлийн тархалтыг тодорхой тоонуудаар хэмжсэн. Төсөөлөл бүрийн ЗҮЦХА-г тухайн төсөөлөлд хамаарах ЧМ хувьд үндэслэн тооцсон бол бодит ЗҮЦХА-г дээрх гурван төсөөллийн дараах пропорцоор жигнэсэн дунджаар авсан байна. Үүнд: эерэг болон сөрөг төсөөллийн 15%, суурь төсөөллийн 70%.

Тооцооллын 3 төсөөлөлд хамаарах тохируулгын коэффициентийг доорх хүснэгтээс харна уу:

	Байгууллагын зээл	ЖДБ-ын зээл	Иргэдийн зээл
2023 оны 12 сарын 31-нээр			
Сөрөг төсөөлөл	2.2921	2.2921	1.7680
Суурь төсөөлөл	0.7850	0.7850	0.5053
Эерэг төсөөлөл	0.4222	0.4222	0.2669
2022 оны 12 сарын 31-нээр			
Сөрөг төсөөлөл	2.1048	2.1048	1.6981
Суурь төсөөлөл	1.3574	1.3574	1.1363
Эерэг төсөөлөл	0.4406	0.4406	0.4922

Бүтцийн өөрчлөлт орсон зээлийн тойм

Эрсдэлийн удирдлагын үүднээс зээлд бүтцийн өөрчлөлт орсон бол Банкны Тусгай аквивын хэлтэс нь зээлийг эргэн төлөгдөх хүртэл хяналт тавьдаг.

Доорхи хүснэгтэд бүтэц өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгийн нийт дансны дүн болон холбогдох ЗҮЦХА-г 2022 оны болон 2023 оны 12 сарын 31-ээр тус бүр харуулав:

	2023 мян.төг	2022 мян.төг
<i>Бүтэц өөрчлөгдсөн зээлүүд:</i>		
Дансны нийт үнэ	52,614,502	56,806,027
Холбогдох ЗҮЦХА	(33,749,533)	(21,933,646)

Эрсдэлийн төвлөрлийн шинжилгээ

Банк дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний систем, шатлалыг ашиглан гаргасан зээлийн чанар болон зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнтэй холбоотой тодруулгуудыг 12, 13, 14 ба 17-р тодруулгаас харна уу.

Дараах хүснэгтэд Банкны харилцагчдад олгосон зээл, урьдчилгааг (Тодруулга 17) аж үйлдвэрийн салбараар нь ангилан, зээлийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэн эсвэл зээлийн чанарыг сайжруулах бусад зүйлүүдийг авч үзэхээс өмнөх нийт дүнгээр нь үзүүлэв:

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

32. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Эрсдэлийн төвлөрлийн шинжилгээ (үргэлжлэл)

	Нийт багцын хэмжээ			
	2023 мян.төг	%	2022 мян.төг	%
Худалдаа, үйлчилгээ	939,847,708	18%	989,179,347	21%
Уул уурхай, олборлолт	594,847,744	11%	618,573,404	13%
Барилга байгууламж	376,491,765	7%	473,147,282	10%
Санхүүгийн үйлчилгээ	377,195,935	7%	355,983,175	8%
Үйлдвэрлэл	586,842,868	11%	523,074,747	11%
Орон сууц	609,560,516	11%	515,069,970	11%
Төлбөрийн карт	528,421,873	10%	278,200,090	6%
Зочид буудал, ресторан, аялал жуулчлал	135,283,643	3%	151,931,463	3%
Тээвэр, харилцаа холбоо	259,503,316	5%	168,262,695	4%
Түлшний импорт, худалдаа	215,092,310	4%	–	0%
Хадгаламж барьцаалсан	118,298,002	2%	100,641,414	2%
Эрүүл мэнд	37,971,252	1%	30,018,101	1%
Боловсрол	72,855,274	1%	58,040,193	1%
Цахилгаан, эрчим хүч ба дулаан	11,654,177	0%	19,875,704	0%
Хөдөө аж ахуй	71,627,403	1%	23,345,917	1%
Бусад	409,950,828	8%	312,523,722	7%
	5,345,444,614	100%	4,617,867,224	100%

*Бусад салбарын компаниудын хувьцааг л эзэмшдэг холдинг компанийг банкны салбарын кодчиллын дагуу санхүүгийн үйлчилгээ гэж ангилсан.

Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд

Барьцаа хөрөнгийн төрөл болон үнэлгээний дүн нь зээлдэгчийн зээлийн эрсдэлийн үнэлгээ болон олгох зээлийн төрлөөс хамаарна. Барьцаанд авсан хөрөнгийн гол төрлүүдийг доор үзүүлэв. Үүнд:

- Байгууллагуудад олгосон зээл: Үл хөдлөх хөрөнгө, бараа материал, үйлдвэр ба тоног төхөөрөмж, машин механизм;
- Иргэдийн зээл: Тээврийн хэрэгсэл; орлого; үл хөдлөх хөрөнгө; орон сууцны үл хөдлөх хөрөнгө
- Жижиг, дунд үйлдвэрлэлд олгосон зээл: Үл хөдлөх хөрөнгө

Банк барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тогтмол хянадаг ба гэрээний дагуу шаардлагатай үед нэмэлт барьцаа хөрөнгө гаргуулахыг шаардаж болно. Банк журмын дагуу өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг зохион байгуулалттайгаар борлуулдаг. Хөрөнгө борлуулсанаас олсон орлогыг зээлийн үлдэгдэл төлбөрийг багасгах болон төлж дуусгахад зориулна. Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг Банк нь өөрийн бизнесийн хэрэгцээнд ашигладаггүй.

Банк дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний систем ба жилийн эцсийн шатлалын ангиллыг ашиглан гаргасан зээлийн чанар болон зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнтэй холбоотой тодруулгуудыг 12, 13, 14 ба 17-р тодруулгаас харна уу. Санхүүгийн хэрэглүүрүүд нь бодит үнэ цэнээрээ бүртгэгддэг санхүүгийн хэрэглүүрийн хувьд тодруулга 14-д, ирээдүйн үнэлгээний өөрчлөлтөөс үүдэн гарах зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнг бус харин одоогийн байгаа зээлийн эрсдэлийг харуулсан.

Банкны харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны барьцааг доор харуулав:

	Нийт дансны дүн мян.төг	Барьцаа хөрөнгийн бодит үнэ цэн мян.төг	%
2023 оны 12 сарын 31-нээр			
Байгууллагын зээл	3,346,336,133	8,664,934,415	259%
ЖДБ-ын зээл	599,615,465	1,648,591,251	275%
Иргэдийн зээл	1,150,861,431	1,817,582,235	158%
	5,096,813,029	12,131,107,901	
2022 оны 12 сарын 31-нээр			
Байгууллагын зээл	3,238,302,119	8,967,114,590	277%
ЖДБ-ын зээл	420,167,378	1,224,305,300	291%
Иргэдийн зээл	628,521,161	1,404,319,468	223%
	4,286,990,658	11,595,739,358	

32. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**(2) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)****Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд (үргэлжлэл)****Зээлийн төвлөрлийн харьцаа**

Банкны тухай хуульд заасны дагуу Банкнаас аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалт, бусад хэлцлийн нийлбэр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй. Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга болон гишүүн, гүйцэтгэх удирдлага, банкны ажилтан эсвэл түүнтэй холбоотой аливаа этгээдэд олгох зээл, түүнтэй адилтгах хөрөнгө, баталгааны дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас нийт дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх ёстой. 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ямар нэгэн зөрчил байхгүй.

(3) Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй нөхцөлд төлбөр тооцооны үүргээ гүйцэтгэх боломжгүй байх эрсдэлийг төлбөрийн чадварын эрсдэл гэнэ. Уг эрсдэлийг хязгаарлахын тулд удирдлага нь үндсэн харилцах, хадгаламжийн эх үүсвэрээс гадна олон төрлийн эх үүсвэрийг төвлөрүүлэх ба өдөр тутам ирээдүйн мөнгөн урсгал болон төлбөрийн чадвараа хянадаг. Үүний тулд нэмэлт эх үүсвэр шаардагдсан үед ашиглагдах өндөр үнэлгээтэй барьцаа хөрөнгийн бэлэн байдал болон хүлээгдэж буй мөнгөн урсгал зэргийн үнэлгээ хийхийг шаарддаг.

Харилцагч харилцахаас татан авалт хийх, хадгаламжийн хугацаа дуусаж бэлэн мөнгө авах болон Банк зээлдэгчид зээлийн олголт хийх тохиолдолд Банк нь хангалттай хэмжээний бэлэн мөнгөтэй байх шаардлагатай болдог. АПУХ нь бэлэн мөнгөний эдгээр гадагш мөнгөн урсгалыг нөхөх хамгийн бага мөнгөн урсгалын түвшин болон гэнэтийн эрэлтийн үед гарах зардлыг нөхөхөд бэлэн байх ёстой банк хоорондын болон бусад зээлийн хэрэгслийн доод түвшинд хязгаарлалт тогтоодог.

Төлбөрийн чадварын эрсдэлд өртөх байдал

Банкнаас төлбөрийн чадварын эрсдэлийг удирдахад ашигладаг гол хэмжүүр бол төлбөрийн чадвартай хөрөнгийг нийт өр төлбөртэй харьцуулах харьцаа бөгөөд энэ нь Монгол Улсын Банкны тухай хуульд заасан төлбөрийн чадварын харьцаатай нийцэж байгаа юм.

Энэ зорилгоор Банк төлбөрийн чадварын харьцааг дараах байдлаар тооцоолдог. Банкны төлбөрийн чадвартай хөрөнгийг тооцохдоо бэлэн мөнгө, бусад банк болон санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж, Монголбанкны хөрөнгө оруулалтын үнэт цаасыг оруулна. Харин түргэн гүйцэтгэгдэх өр төлбөрийг тооцохдоо харилцагчаас төвлөрүүлсэн харилцах, хадгаламж, бусад банк болон санхүүгийн байгууллагуудаас байршуулалсан харилцах, хадгаламж, гадаадын санхүүгийн байгууллагуудын зээл, татвар, гаргасан өрийн бичиг зэрэг орно.

Тайлангийн өдрөөрх төлбөрийн чадварын харьцаа:

	2023	2022
12 дугаар сарын 31-ний байдлаар	<u>49.7%</u>	<u>43.4%</u>

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ

Дараах хүснэгтэд 2022 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн өр төлбөр болон хөрөнгийн дуусгавар хугацааг тэдгээрийн гэрээний дагуу эргэн төлөх үүрэг дээр үндэслэн харууллаа. Мөн Банк дийлэнх харилцагчид нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй байх гэсэн хүлээлт дээр үндэслэсэн бөгөөд харилцах, хадгаламжийн тодорхой хувийг хадгалах хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тусгаагүй болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2023 оны 12 сарын 31

32. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

(3) Төлбөрийн чадварын эрсдэл (үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ (үргэлжлэл)

2023 оны 12 сарын 31-нээр	Хугацаагүй мян.төг	3 сараас ихгүй мян.төг	3 сараас 6 сар мян.төг	6 сараас 1 жил мян.төг	1-ээс 5 жил мян.төг	5-аас дээш жил мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө							
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	1,117,858,549	1,193,856,976	–	–	–	–	2,311,715,525
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	869,544,915	783,230,812	–	–	–	–	1,652,775,727
Санхүүгийн хөрөнгө оруулалт	–	1,224,738,338	247,269,570	107,443,178	186,940,736	956,661,854	2,723,053,676
Нийт хэрэгжсэн своп хэлцэл:							
- Орж ирсэн гүйлгээ	–	39,750,576	3,646,159	4,473,604	11,755,341	–	59,625,680
- Гарсан гүйлгээ	–	(40,440,564)	(6,363,445)	(7,121,919)	(22,983,257)	–	(76,909,185)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	554,076,511	802,131,637	615,471,775	1,415,886,826	2,876,815,855	1,877,285,064	8,141,667,668
Бусад санхүүгийн хөрөнгө	30,996,818	27,724,891	13,496,593	49,488,420	268,656,334	–	390,363,056
	<u>2,572,476,793</u>	<u>4,030,992,666</u>	<u>873,520,652</u>	<u>1,570,170,109</u>	<u>3,321,185,009</u>	<u>2,833,946,918</u>	<u>15,202,292,147</u>
Санхүүгийн өр төлбөр							
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	23,863,949	294,709,383	–	–	–	–	318,573,332
Репо хэлцэл	–	–	–	35,363,068	19,680,137	–	55,043,205
Харилцагчдын харилцах, хадгаламж	4,962,670,005	1,308,989,787	836,125,118	1,628,943,151	573,473,246	18,825,467	9,329,026,774
Нийт хэрэгжсэн своп хэлцэл:							
- Орж ирсэн гүйлгээ	–	41,396,162	3,087,757	2,583,633	8,858,627	–	55,926,179
- Гарсан гүйлгээ	–	(46,489,388)	(4,861,811)	(4,400,466)	(16,465,645)	–	(72,217,310)
Зээлээр авсан санхүүжилт	–	159,310,715	83,352,194	536,071,195	131,063,322	25,411,246	935,208,672
Түрээсийн өглөг	–	2,089,904	1,979,903	3,841,872	7,888,740	–	15,800,419
Бусад санхүүгийн өр төлбөр	–	166,628,192	–	–	5,558,789	547,914	172,734,895
